



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС

Нийтлэлийн бодлого

- Шударга ёсыг бэхжүүлэх онол, арга зүйн асуудал
- Шударга ёсыг зохицуулах хууль эрх зүйн орчны онол, арга зүйн асуудал
- Шударга ёсыг тогтоон бэхжүүлэх онол, арга зүйн асуудал
- Авлигын шалтгаан, нөхцөл судлал
- Сайн туршлага
- Гадаад орны болон олон улсын үйл ажиллагаа, туршлага

Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР, АТГ-ЫН ДАРГА З.ДАШДАВАА НАРЫН ЯРИЛЦЛАГА	4
АВЛИГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АВЛИГЫН ИЛРЭХ ХЭЛБЭР, АВЛИГА ҮҮСЭХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭС АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, докторант Н.Тамир	7
АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛИЙГ ОЛОХ НЬ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар	14
АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШИГ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч А.Мөнхбаяр	22
ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Тэмүүжин	29
ЭД ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ, ХӨРӨНГИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ, ХЯЗГААРЛАХ ТУХАЙ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Ц.Золзаяа	33
ХУЛГАЙЛАГДСАН ХӨРӨНГИЙГ ЦАРЦААХ, БУЦААН АВАХ АСУУДАЛ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Эрдэнэсайхан	37
АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ЭРХЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦААНЫ ГЭРЭЭ БОЛОН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Б.Батбилэг	45

<p>МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Д.Цогтоо</p>	50
<p>ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ АСУУДАЛ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Балдандорж</p>	55
<p>АВЛИГЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан Н.Дамдинсүрэн</p>	58
<p>ӨВСӨН ДОТРООС ЗҮҮ ЭРЭХ НЬ АТГ-ын хэвлэлийн ажилтан Т.Мөнхтунгалаг</p>	64
<p>“СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ГУРАВДАГЧ ОРОН”-Ы ЖАГСААЛТ БА МОНГОЛ УЛС АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан Б.Баярсайхан</p>	69
<p>НИЙГМИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАН ОЛОН НИЙТИЙН СЭТГЭЛ ЗҮЙД НӨЛӨӨЛЖ БУЙ БАЙДАЛ АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан Д.Жаргалан</p>	76
<p>ЧОНО БОРООНООР БУЮУ АВЛИГА “ХОРООНОО”-ГООР... АТГ-ын хэвлэлийн ажилтан Т.Мөнхтунгалаг</p>	92
<p>“ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АВЛИГЫН МӨНГӨӨ ОЛОН ХҮН ЦУГЛАСАН ГАЗАР УУЛЗАЖ, БЭЛНЭЭР АВДАГ ЮМ БИЛЭЭ” Сэтгүүлч Н.Пунцагболд</p>	95
<p>АВЛИГЫН КРИМИНОЛОГИ “Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн зохицуулагч А.Амармэнд</p>	99

УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР, АТГ-ЫН ДАРГА З.ДАШДАВАА НАРЫН ЯРИЛЦЛАГА

АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа “Бүрэн зураглал” нэвтрүүлэгт оролцож “Хууль, шударга ёс” сэдвээр УИХ-ын дарга Г.Занданшатартай ярилцсан юм. Уг ярилцлагыг бүрэн эхээр нь сийрүүлэн хүргэе.

Авлигын гэмт хэргийг дагнасан шүүхээр шийдвэрлүүлдэг больё

Г.Занданшатар: -Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар батлаад 5 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ. Үндсэн хууль

бол алганд багтсан Монгол Улс, ард түмний хүсэл эрмэлзлийг шингээж араг яс болж зангидсан. Гэхдээ үүнийг хэрхэн бяруулж амилуулах вэ гэхээр органик хуулиар булчин шөрмөсүүдийг нь зангидаж өгөх ёстой.

З.Дашдаваа: -2019 онд орсон Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр нийтдээ 50 орчим хуулиуд өөрчлөгдөнө гэж үзэж байгаа. Эдгээр хуулиудад оруулах зарим нэг нэмэлт, өөрчлөлтийн саналыг Танд уламжлан хүргүүлж байгаа юм.

Г.Занданшатар: -Ард түмэн



авлигын асуудлыг их ярьж байгаа. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол зорилго бол харилцан хяналт тэнцлийг бэхжүүлэх замаар шударга ёсыг тогтоож, авлигыг арилгах юм.

З.Дашдаваа: -2007 онд АТГ байгуулагдаж 13 дахь жилдээ ажиллаж байна. Мөрдөн шалгах чиглэлээр АТГ нэлээд мэргэшиж, тодорхой түвшинд хүрсэн. Прокурорууд бас тодорхой түвшинд мэргэшсэн гэж ойлгож байгаа. Бидний хүсэн хүлээж байгаа зүйл бол авлигын гэмт хэргийг дагнасан шүүхээр шийдвэрлүүлэх сонирхолтой байдаг. Энэ талаар олон улсын жишиг ч бий. Монгол Улсын Үндсэн хуульд шүүхийн тухай орсон өөрчлөлтөөр бол шүүхийг дагнан байгуулж болно гэсэн заалт байгаа. Тэгэхээр дагнасан шүүх байгуулснаараа авлигатай тэмцэх ажилд нэлээд ахиц гарна.

Тангаргийн үгийг өөрчлөх нь УИХ-ын гишүүдийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж байгаа ажил

Г.Занданшатар: -АТГ нь шинэлэг хандлага, олон улсын туршлага, цахим засаглал, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон ажил хийхээр зохион байгуулж төлөвлөөд УИХ-д багц саналуудаа ирүүлсэн. Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлдэггүй байх, мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, АТГ-ын салбар, нэгжийг орон нутагт байгуулах гэх мэт. Улс төрийн намын санхүүжилтийн механизмыг ил тод, хариуцлагатай болгох санал нь Үндсэн хуульд яг ингэж орсон. УИХ-ын гишүүдийн ёс суртахуун, шударга, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол зорилго.

Төрийн түшээд, УИХ-ын гишүүд маань шударга ёс, сахилга хариуцлагаа дээрээсээ ингээд үлгэрлээд эхэлбэл доор шударга ёс тогтоно. Ийм учраас АТГ-аас УИХ-ын гишүүдийн тангаргийн үг болон тангараг өргөх дэгт зарим өөрчлөлт оруулахаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад саналаа ирүүлсэн. Үүнийг УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд болон УИХ-ын тухай хуульд оруулахаар төлөвлөж байна. Энэ саналаа Та тодорхой тайлбарлаж өгнө үү.

З.Дашдаваа: -Өнөөдрийн мөрдөгдөж байгаа дэгээр бол УИХ-ын гишүүд бүгд нэг дуугаар уншаад, туганд мөргөөд л, тангараг өргөх үйл ажиллагаа өндөрлөж байгаа. Монгол Улсын төрийн эрх мэдэл бүх ард түмний гарт байдаг. Энэ эрх мэдлээ УИХ-ын гишүүнээр дамжуулан хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуульд заасан. Тийм учраас УИХ-ын гишүүн төр, түмний төлөө зүтгэх учиртай. УИХ-ын гишүүн тангараг өргөсөн эхний өдрөөсөө л энэхүү үүрэг хариуцлагаа сайтар ойлгож ажиллах ёстой гэж бид үзэж байгаа.

“Монгол Улсын Их Хурлын гишүүн би ...иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн төрийн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж” гэж бид нэмж оруулж байгаа. “Гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ хэмээн төрийн сүлдэнд тангараг өргөнө” гэж өөрчлөн найруулах, СЕХ-ны дарга илтгэл тавьсны дараа насаар ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлж тангараг өргөх гэснийг “СЕХ-ны дарга илтгэл тавьсны дараа гишүүн нэг бүр насны эрэмбээр Монгол Улсын Үндсэн хууль дээр гараа тавьж тангаргийн үгийг цээжээр уншиж тангараг өргөнө” гэж өөрчлөн найруулах

саналтай байна.

Тодорхой хэмжээнд нэг өдөр суугаад уншаад цээжилнэ гэдэг бол ингэхэд би ер нь ямар ажил албанд очиж байгаа билээ гэдэг мэдрэмж зайлшгүй төрнө. Үндсэн хуулиа зайлшгүй уншина.

Тодорхой цаг хугацаа орох байх. Гэхдээ нэгэнт төрийн эрх барих дээд байгууллагад орж ажиллаж байгаа хүн ард түмнийхээ өмнө өөрийн биеэр энэ тангаргийг өргөдөг байх ёстой. Ингэж илэрхийлэх нь тухайн сонгогдож байгаа гишүүнд ойлгомжтой байх юм болов уу гэж бид харж, ийм санал оруулж байна.

Тангаргийн үгэнд бас “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна” гэж оруулах санал өгч байгаа нь УИХ-ын эрхэм гишүүдийг аливаа гэмт хэрэг, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлж байгаа том ажил.

Иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлж байх нь зүйтэй

Г.Занданшатар: -Үндсэн хуульд шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй бол хэнийг ч гэм буруутайд тооцохгүй гэсэн заалт бий. Гэтэл нийгмийн сүлжээ, зарим төрийн бус байгууллагууд урьдчилаад хүнийг ялладаг, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлдөг, улстөржүүлдэг байдал сонгууль дөхөхөөр хавтгайрах хандлагатай болдог. Энэ байдал нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд саад болох, мөрдөн байцаалтын нууц задрах гэх мэт тодорхой хүндрэл учруулдаг гэсэн яриа

бий. Тийм учраас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон мөрдөн шалгах чиглэлээр Та бүхний баримталж байгаа стратеги, тактикт ямар өөрчлөлт оруулья гэж Та үзэж байна вэ?

З.Дашдаваа: -Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шалгагдаж байгаа хэргийн материал нууц. Прокурорын зөвшөөрөлтэйгөөр тодорхой мэдээллүүдийг өгдөг. Иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлж байх нь зүйтэй гэж үздэг. Тэр тусмаа авлигын гэмт хэрэг дээр. Аливаа асуудал хаалттай байгаа нь хардлага сэрдлэг төрүүлдэг. Тийм учраас тодорхой мэдээллийг ингэж ингэж өгч болно гэсэн заалтуудыг холбогдох хуульд оруулах хэрэгтэй. Ингэвэл иргэд, олон нийт хий хардлага сэрдлэгэд автахгүй, хэвлэлд таамгаар бичээд байхгүй. Байгууллагын мэдээллийг ил тод өгснөөр дээрх бэрхшээл арилна гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: -За, их баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сурталчлан таниулах ажил бол УИХ-ын үүрэг. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил бол АТГ-ын үүрэг. Өнөөдрийн ярилцлагын зорилго нь АТГ-ын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр мэдээлэл солилцох байлаа. Үр дүнтэй ярилцлага боллоо. Танд баярлалаа.

З.Дашдаваа: -За, баярлалаа.

**Тэмдэглэсэн Т.Мөнхтунгалаг
2020.04.09**



АВЛИГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, АВЛИГЫН ИЛРЭХ ХЭЛБЭР, АВЛИГА ҮҮСЭХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭС

АТГ-ын Мөрдгөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, докторант Н.Тамир

Авлигын тодорхойлолт, мөн чанар

Авлига нь улс төр, эдийн засаг, нийгмийн олон талт үзэгдэл тул түүнийг олон янзаар тодорхойлдог. Авлигыг тодорхойлсон нэгдсэн нэг тодорхойлолт байхгүй боловч авлигын эсрэг тэмцдэг байгууллага, судлаачид авлига гэж юуг хэлэх талаар тодорхойлолтуудыг гаргасан байна.

“Авлига” гэдэг үгийг Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толь бичигт нэгдүгээрт, эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах, хоёрдугаарт, хээл хахууль гэсэн утгаар тайлбарласан байна¹. Авлига буюу “corruption” гэдэг үг нь “corruptio” гэсэн латин үгнээс гаралтай, ихэвчлэн эрх мэдэлтэй хүний гаргадаг шударга бус үйлдэл, ёс суртахуунгүй зан чанар, хууль бус үйлдлийг хэлнэ гэж англи хэл зүйн толь бичигт мөн тайлбарлажээ².

Авлига нь нийгэм дэх шударга бус үйлдэл, шан харамж, ёс суртахууны доголдол зэрэг үйлдлийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт болох нь судлаачдын тодорхойлолтод тусгагджээ. Үүнд:

Өөрт ноогдсон эрх мэдлийг хувийн

зорилгод ашиглах явдлыг авлига гэнэ.³

Авлига нь төрийн албан хаагч өөрт олгогдсон эрх мэдлийг урвуулан ашиглаж, өөрөө ашиг олох, өөрийн дотнын хүмүүсийг зүй бусаар хууль зөрчин баяжуулах, хууль бусаар мөнгө төгрөг, эд бараа, эзэмшлийн бусад эрхийг шууд олж аваад хариуд нь бусад давуу эрх олгох байдлаар илэрнэ.⁴

Авлига гэж...албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.⁵

Мөн Британника нэвтэрхий тольд авлига гэдэг үгийг “өөртөө болон хэн нэгэнд ашиг гаргахын тулд хууль зөрчиж хийсэн зүй бус үйлдлийг хэлнэ” гээд тэнд хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах, албаны дотоод нууц мэдээллийг зүй бусаар завших, задруулах гэхчлэнгээр тайлбарлажээ.

Авлигын тодорхойлолтуудад байгаа нийтлэг шинж чанарыг харьцуулж дүгнэн

1 Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 16 дахь тал

2 Longman Dictionary of Contemporary English, Longman Group Ltd, England, 1995, p. 306

3 http://www.transparency.org/news_room/faq/corruption_faq

4 Нээлттэй нийгэм форум, “Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томьёоны тайлбар толь”, Улаанбаатар, 2006 он, 1 дүгээр хуудас

5 Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл,

судлаач Д.Зүмбэрэлхам авлигыг эрх зүйн зөрчил болох үүднээс тайлбарлан "...аливаа албан хаагч өөрт нь итгэж олгосон эрх хэмжээ буюу албан тушаалын байдлаа тухайн албаны эрх ашгийн эсрэг хувийн ашиг сонирхолдоо урвуулан ашиглаж хийвэл зохих үүргээс татгалзах, эсхүл хийхийг хориглосон үйлдлийг хийх зүй бус үйлдлийг илэрхийлнэ"⁶ гэж тодорхойлжээ

Дээрх бүх тодорхойлолтуудаас харахад нийгэм дэх сөрөг үзэгдлийн нэг болох "авлига" нь нийтийн ашиг сонирхлыг худалдсанаар хувийн ашиг сонирхлыг хангах зүй бус үзэгдэл гэж тодорхойлогдохоор байна. Нийгэм дэх зүй бус үйлдэл болох үүднээс авлига гэдгийн дор дараах асуудлыг хамруулан ойлгож болохоор байна. Үүнд:

- Төрийн алба, улс төр, бизнесийн хүрэн дэх худалдагдсан эрх мэдэл;
- Эрх мэдэл, албан тушаалаа хууль бусаар урвуулан ашиглах үзэгдэл;
- Нийгэмд хортой үр дагавар бүхий ёс бус үйлдэл, эс үйлдэл.

Авлигын төрөл, хэлбэр

Нийгэм дэх авлигын түвшинг хэмжих, авлигатай хийх тэмцлийн арга хэлбэрийг сонгох, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс бодлогын шийдвэр гаргагчид, судлаачид авлигын үзэгдлийг судалж төрөл, илрэх хэлбэрийг тодорхойлж ангилсан байна.

Авлигыг олон янзаар ангилж бүлэглэсэн байдгаас дараах ангилал нь түгээмэл юм.

Хэмжээний хувьд том ба жижиг. Жижиг авлига нь бага тушаалын албан хаагчид жирийн иргэд, үйлчлүүлэгчдээс хууль бус хураамж, шан харамж авах

байдлаар илэрдэг бол том хэмжээний авлига нь нийгмийг хамарсан, ихээхэн хор уршигтай байдаг. Улс төр, санхүү, захиргааны өндөр албан тушаалтнууд төрийн бодлого боловсруулах явцдаа албан тушаалаа урвуулан хувийн ашиг хонжоо олоход ашигласан ихээхэн хэмжээний мөнгөн дүнтэй авлигыг том авлига гэж тодорхойлох бөгөөд төрийн үйлчилгээг гажуудуулах, аль нэг салбар байгууллагад давуу эрх, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, гадаадын иргэн байгууллагаас ихээхэн хэмжээний хахууль авч өрсөлдөөний нөхцөлийг өөрчлөх гэх мэтээр илэрдэг.

Авлига гарч буй *салбараас нь хамааруулан улс төр, захиргаа, бизнесийн салбар* дахь авлига гэхчлэн ангилдаг байна.⁷

Улс төрийн авлига нь ихэвчлэн сонгуулийн үйл явцтай холбоотойгоор илэрдэг бол захиргааны авлига нь бодлогын хэрэгжилтийг гажуудуулах үйлдлээр илэрдэг.

*Зохион байгуулалттай ба зохион байгуулалтгүй авлига*⁸: Зохион байгуулалттай авлигыг гэмт хэргийн бүлэг, эвслүүд үйлддэг, ихэвчлэн үндэстэн дамнасан хэлбэртэй байх бөгөөд оролцогч талууд тодорхой зохион байгуулалт, тохиролцоотойгоор үйл ажиллагаанд оролцдог. Давуу тал авсан боловч эргээд хариу барих нь баталгаагүй бол зохион байгуулалтгүй гэж тодорхойлдог байна.

Авлига нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд дараах тодорхой хэлбэрүүдээр илэрдэг байна.⁹ Үүнд:

- Гадаадад хууль бусаар мөнгө шилжүүлэх;
- Төрийн өмчийг хууль бусаар хувьчлах;

6 Зүмбэрэлхам, Д., "Авлигын гэмт явдал: сургалтын гарын авлага", USAID, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2007, 6-р тал

7 Өлзийбаяр, В., "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага", Удирдлагын академи, гарын авлага, 2008

8 Авлигатай тэмцэх газар, UNDP, "Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага, УБ, 2011, 4 дэх тал

9 Нээлттэй нийгэм форум, "Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь", Улаанбаатар, 2006 он, 2 дахь тал

- Хууль бусаар хөрөнгө эзэмших;
- Эрх мэдлээ урвуулан ашиглах, айлган сүрдүүлэх;
- Хуурамч нотолгоо гаргах;
- Үүрэг хариуцлагаа үл биелүүлж ажил цалгардуулах;
- Сонгуулийг будилаантуулах;
- Дотоодын нууц мэдээллийг зүй бусаар ашиглах;
- Бичиг баримтыг хуурамчаар ашиглах
- Зүй зохистой хэмжээнээс хэтэрсэн бэлэг сэлт, мөнгөн төлбөр авах;
- Хууль бус хяналт шалгалт хийх, харилцаа холбоог зүй бусаар ашиглах;
- Албаны тамга тэмдэг, орон байр, үйлчилгээ болон бусад давуу эрхийг хууль бусаар ашиглах.

Авлигын илрэх хэлбэрийг тодорхойлсон судалгаанаас үзвэл дараах нийтлэг хэлбэрүүд байдаг байна. Үүнд:

Хээл хахууль: Албан хаагчийн албан ёсны эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь нөлөөлөх зорилгоор ихээхэн хэмжээний шан харамж өгөх, авах, зуучлах авлигын хэлбэр юм. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 15, 16 дугаар зүйлд төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан хаагчдад албан үүргээ зөрчин аливаа үйлдэл хийлгэх, эс хийлгэхгүйн тулд өөрт нь, эсвэл өөр этгээд буюу байгууллагад шууд болон шууд бусаар хууль бус давуу тал олгохыг амлах, санал болгох, эсвэл олгохыг хээл хахууль гэж тодорхойлсон байна.¹⁰

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын олон улсын төрийн албан хаагчдын хээл хахуулийн эсрэг конвенцид мөн хээл хахуулийг

тодорхойлохдоо олон улсын бизнесийн харилцаанд хууль бус давуу нөхцөл олж авахын тулд албан үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчдад шууд болон зуучлагчаар дамжуулан өөрт нь, эсвэл гуравдагч талд давуу байдал олгохыг амлах, санал болгох, эсвэл олгохыг хээл хахуульд хамруулахаар тодорхойлжээ.¹¹ Эдгээр тодорхойлолтуудаас үзвэл хээл хахууль нь уг үйлдэлд оролцогч хоёр талын үйлдлээр илэрдэг, хээл хахууль өгч байгаа нь тухайн этгээдийг албаны эрх ашгаас нь урвуулах, авч байгаа нь түүний төлөө албан эрх ашгаасаа урвах агуулгатай байна.¹²

Шан харамж, бэлэг: Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө иргэн, байгууллага, бизнесийн нэгжээс нэмэлт төлбөр, үнэ бүхий зүйл авах хэлбэр¹³ бөгөөд хээл хахуультай харьцуулахад нийгэмд учруулах хор аюулын зэрэглэлээр харьцангуй бага хэлбэр гэж тооцогддог.

Эд хөрөнгө завших: Албан үүргийн дагуу хариуцаж буй эд хөрөнгийг өөрийн, эсвэл өөр бусад этгээд, байгууллагын ашиг тусын тулд завших, зориулалтын бусаар зарцуулах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг авлигын гэмт хэрэгт тооцдог.¹⁴

Эрх мэдэл, чиг үүргээ урвуулан ашиглах: Албан тушаалтан шийдвэр гаргах эрх мэдлээ ашиглан бусдад давуу байдал олгох болон харилцаанд оролцогч талуудад тэгш бус хандсанаар ашиг хонжоо олох үзэгдэл, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх буюу гүйцэтгэхгүй байхыг мөн авлигын гэмт хэрэгт тооцно.¹⁵

Ах дүүсэх, найзархах: Албан тушаалтан аливаа асуудлаар найз нөхдөдөө, эсвэл төрөл садан, ах

10 НҮБ, Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенци, http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf

11 OECD, Convention on combating bribery of foreign public officials in international public transactions, 2011, in <http://www.oecd.org/dataoecd/4/18/38028044.pdf>

12 Зүмбэрэлхам, Д., "Авлигын гэмт явдал: сургалтын гарын авлага", USAID, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2007, 13-р тал

13 Авлигатай тэмцэх газар, "Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага" УБ, 2011, 6 дахь тал

14 НҮБ, Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенци, 17-р зүйл http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf

15 Авлигатай тэмцэх газар, "Төрийн байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гарын авлага" УБ, 2011, 6 дахь тал

дүү нартаа илүү ашигтай шийдвэр гаргах, албан тушаалд томилох зэрэг байдлуудаар илэрдэг авлигын хэлбэр.¹⁶

Гэмт хэргээс олсон орлогыг угаах: Гэмт хэргээс олсон орлогын хууль бус гарлыг нуун дарагдуулах, хууль бусаар олсон эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх санаатай гэмт үйлдлийг авлигад тооцдог байна.¹⁷

Хөнгөлөлт үзүүлэх: Төрийн байгууллага, албан тушаалтан зарим иргэн, байгууллагад тусгайлан дэмжлэг үзүүлэх хэлбэрээр илэрдэг авлигын төрөл. Албан тушаалтан бизнесийн аль нэг бүлэг, эсвэл байгууллагыг онцгойлон авч үзэж дэмжсэнээр улс төр, бизнесийн авлигын сүлжээ үүсэж энэ нь цаашид эрх мэдлийн монополь үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг, чөлөөт өрсөлдөөнийг хязгаарладаг сөрөг үр дагавартай.

Тал тохой татах: Танил тал, хамаатан садан, нэг нам, бүлэглэлийн гишүүддээ давуу эрх олгох, албан тушаалд томилох, нөөц хуваарилахтай холбоотой илэрдэг авлигын хэлбэр бөгөөд ажил хэргийн мэдлэг, чадварын шалгуур хангасан хүмүүс төрийн албанд шударгаар дэвшин ажиллах боломж хаагддаг сөрөг үр дагавартай.

Авлигын гэмт хэргийн илрэх хэлбэрээс хамааруулан гэмт хэрэгт тооцох шалгуурыг тодорхойлж авлигатай тэмцэх аргаа тодорхойлдог байна.

Авлига үүсэх нийгэм, эдийн засгийн үндэс

Аль ч нийгэмд бүтээсэн зүйлээсээ илүү ихийг авах, өглөг буян, хандив тусламж авах, сохор азаар хоромхон зуур баяжих хүсэл сонирхол нь нийгмийн сэтгэлгээг ядууруулж, авлига үүсэх гол

нөхцөл болж байна. Авлигын судалгааны нэг үндсэн чиглэл нь авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлс, авлигын нийгэм, эдийн засгийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох асуудал байна. Улс орны эдийн засгийн хөгжил, нэг хүнд ногдох орлого ба хөрөнгө оруулалтын хэмжээ бага байх нь авлига үүсэхэд нөлөөлөх гол хүчин зүйл¹⁸ болохыг тодорхойлжээ.

Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөллийн эрэмбийг тодорхойлсон Роб МакКускерийн судалгаанд иш татсанаар¹⁹ улстөрчид ба төрийн албан хаагчдын баримтлах үнэт зүйлс, хэм хэмжээ, хяналт, аудитын үр нөлөө, улс төр, төрийн албан хаагч, бизнесийн бүлгүүдийн хэт хамаарал нь авлига үүсэх гол нөхцөл болж байгаа бөгөөд энэ үзүүлэлт хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудад ижил гарсан нь сонирхолтой байна. (Хүснэгт 1-ийг үзнэ үү)

Судлаач Хубертын үзэж байгаагаар өндөр хөгжилтэй орны 190 эксперт, хөгжиж буй орны төлөөлөл болох 67 экспертийн үнэлгээгээр дээр дурдсан үр дүн батлагдсан байна. Хөгжиж буй орнуудад төрийн албан дахь ажил хэргийн зохион байгуулалт, удирдлагын чадавхийн асуудал авлига үүсэхэд нөлөөлөх дараагийн хүчин зүйл болж байгаа бол өндөр хөгжилтэй орнуудад энэ үзүүлэлт долдугаарт эрэмбэлэгдсэн байна. Хөгжиж буй орнуудад төрийн албан хаагчдын цалин бага байгаа нь авлига үүсэхэд нөлөөлөх нэг гол хүчин зүйл болж наймдугаарт эрэмбэлэгдсэн байна бол өндөр хөгжилтэй оронд энэ үзүүлэлт ач холбогдлоороо хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна.

16 Зүмбэрэлхам, Д., "Авлигын гэмт явдал: сургалтын гарын авлага", USAID, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2007, 16 дахь тал

17 НҮБ, Авлигын эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын конвенци, 23-р зүйл http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf

18 Mauro, "Corruption and Growth" Quarterly Journal of Economics, Vol 110, August, pp 681-712

19 Rob McCusker, "Review of anticorruption strategies", Australian Institute of Criminology, 2006

Хүснэгт 1. Авлига үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Авлигад нөлөөлөх хүчин зүйлс	Өндөр хөгжилтэй орнууд		Хөгжиж буй орнууд	
	Хувь	Эрэмбэ	Хувь	Эрэмбэ
Улс төрч, төрийн албан хаагчдын үнэт зүйлс, хэм хэмжээ	88.4	1	98.4	1
Хяналт, аудитын үр нөлөө сул	87.2	2	93.3	2
Бизнес, улс төр, төрийн салбарын хамаарал өндөр	86.6	3	92.9	3
Засгийн газар, төрийн албаны үнэт зүйлс, хэм хэмжээ	84.6	4	79.7	11
Төрийн салбарын соёл	83.3	5	76.8	12
Манлайлах чадвар сул	82.2	6	90.2	5
Зохион байгуулалт, удирдлагын чадвар сул	80.7	7	91.9	4
Зохион байгуулалттай гэм хэргийн өсөлт	79.3	8	90.0	7
Хувийн хэвшлийн болон олон нийтийн мөрдөх хэм хэмжээ, үнэт зүйлс	78.0	9	73.7	14
Лобби бүлгийн нөлөө	76.5	10	72.9	15
Улс төр ба гүйцэтгэх засаглалын харилцан хамаарал	67.0	11	86.4	9
Нийгмийн тэгш бус байдал	66.7	12	90.2	6
Төрийн салбарын цалин бага	56.9	16	87.1	8
Эдийн засгийн хүндрэл (инфляци гэх мэт)	62.2	14	85.2	10

Эх сурвалж: Rob Mc Cusker, "Review of anticorruption strategies", Australian Institute of Criminology, 2006

Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлж судлахаас гадна авлигын шалтгаант нөхцөлийг тодорхойлоход судлаачид мөн анхаарлаа хандуулжээ. Тухайлбал, Миянт²⁰ авлига нь дараах үндсэн нөхцөлтэй холбоотойгоор илэрдэг үзэгдэл гэж үзсэн байна. Үүнд:

Засгийн газрын гэрээ: Авлигач нь засгийн газрын гэрээний тал, гэрээний нөхцөл, цаашилбал, төсөл хэрэгжих үед дэд гэрээлэгч талуудад нөлөө үзүүлж өөрт эсвэл гуравдагч талд давуу эрх олохыг эрмэлздэг.

Засгийн газраас олгож байгаа давуу нөхцөл: Авлигач нь Засгийн газраас

хуваарилж буй мөнгөн хэлбэрийн хөнгөлөлтийг хүртэх тухайлбал, хөнгөлөлттэй зээл, үнийн зөрүүгийн татаас, патент, лиценз эзэмших эрх зэргийн хуваарилалтад нөлөө үзүүлдэг.

Засгийн газрын орлого: Авлигын асуудал нь хувийн хэвшил, бизнесийн байгууллагаас хураах гаалийн болон орлогын татвараас чөлөөлүүлэх, бууруулах, цахилгаан, ус ашигласны төлбөрийг хямдруулах гэх мэт тохиолдлуудтай холбогдож үүсдэг.

Хуулийн зохицуулалтаас зайлсхийх, цаг хэмнэх: Хуулийн хүрээнд явагдаж байгаа лиценз, тусгай зөвшөөрөл, зээл

20 Myint, U., Corruption: Causes, Consequences, and Cures, Asia-Pacific Development Journal, 2000, Vol. 7, No.2, pp. 33-58

тусламж олгох зэрэг үйл ажиллагааг тогтоосон хугацаанаас өмнө өөрт ашигтайгаар гүйцэтгүүлэх зорилгоор авлигыг ашигладаг. Бизнесийн хүрээнийхэн төрийн салбарт байх зохицуулалтын олон шат дамжлагаас зайлсхийх зорилгоор ерөнхийдөө авлигыг ашигладаг байна.

Хууль эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтөд нөлөө үзүүлэх. Бизнесийн хүрээнийхэнд үйлчилж байгаа эрх зүйн актуудыг өөрийн эрх ашигт нийцүүлэх шаардлагаар хууль тогтоогч, эрх зүйн хэм хэмжээ тогтоогчдод нөлөө үзүүлэх тохиолдолд авлига үүсдэг.

Авлига үүсэх нийгэм, эдийн засгийн үндсийг тодорхойлохдоо ихэвчлэн улс орнуудын авлигын нөхцөл байдлыг харьцуулан судлах арга зүйг судлаачид ашигладаг байна. Тухайлбал, Г.Р.Монтинола²¹ нар авлига үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох судалгаануудыг харьцуулж үзээд 1990-ээд он хүртэл хийгдсэн харьцуулсан судалгаануудаар авлигад нөлөөлдөг гол хүчин зүйлс нь эдийн засгийн хөгжил буюу хүн амын түүний дотор төрийн албан хаагчийн орлогын түвшин байна гэх дүгнэлтэд гол төлөв хүрснийг тэмдэглэжээ.

Авлигын үндсийг судлах харьцуулсан судалгааны энэхүү үр дүнг тэд өргөжүүлэн, авлигад нөлөөлөх гурван гол хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж таамаглал дэвшүүлэн судалгаа хийж баталжээ. Үүнд:

1. Өрсөлдөөнт улс төрийн бүтэц авлигыг бууруулдаг. Өөрөөр хэлбэл ардчилсан сонголт хийх эрх чөлөөг иргэдэд олгох нь авлигыг бууруулдаг.
2. Засгийн газрын бүтэц авлигад нөлөөлөх нэг хүчин зүйл бөгөөд Засгийн газрын хэмжээ том байх нь авлигад шууд нөлөөлнө.

3. Эдийн засгийн хөгжил сул байх нь авлига үүсэх нөхцөл болдог.

Монголын судлаачдаас Д.Зүмбэрэлхам²² авлигын шалтгаан, нөхцөлийг олон улсын түвшинд даяарчлал, социалист систем задран унасны дараах социалист орнуудад явагдсан хувьчлал, улсын баялгийг хуваах ажиллагаатай холбон авч үзсэн байна. Монгол Улсад ч мөн өмч хөрөнгөний төлөөх өрсөлдөөн, богино хугацаанд хөлжин хөрөнгөжих, ил далд бүхий л аргыг ашиглан өмчтэй болох өрсөлдөөнд хүмүүс авлигыг ашиглаж эхэлсэн гэж дүгнэжээ.

Авлигын нөхцөл, авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаануудын үр дүнг нэгтгэвэл хөгжиж буй орнуудын хувьд авлигын гол шалтгаан, нөхцөлд дараах хүчин зүйлсийг нэрлэж болохоор байна. Үүнд:

1. Төрийн албаны чадавх, бүтэц зохион байгуулалтад холбогдох хүчин зүйлс:
 - a. Төр, захиргааны байгууллагын соёл, үнэлэмж, үнэт зүйлс, хэм хэмжээ төлөвшиж тогтоогүй байдал;
 - b. Төрийн албаны хүнд суртал, олон шат дамжлага;
 - c. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй бус байдал;
 - d. Төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын чадавх сул;
 - e. Хууль, дүрэм журмын давхцал, зөрчил, ойлгомжгүй байдал.
2. Улс төрийн тогтолцооны гажуудалд хамаарах хүчин зүйлс:
 - a. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хуваарилалт оновчгүй;
 - b. Улс төр, гүйцэтгэх засаглал,

21 Montinola, G.R., Sources of Corruption: Cross country study, B.J.Pol.S. 32, Cambridge University Press, 2002

22 Зүмбэрэлхам, Д., "Авлигын гэмт явдал: сургалтын гарын авлага", USAID, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2007, 18-19 дэх тал

- бизнесийн хүрээний хамаарал өндөр;
- c. Төрийн аудитын болон дотоод хяналтын үр нөлөө сул;
 - d. Улс төрийн намуудын сонгох, сонгогдох эрх, албан тушаалын томилгоон дахь нөлөөлөл өндөр;
3. Эдийн засгийн хүчин зүйлс:
 - a. Нэг хүнд ногдох орлого бага ба эдийн засгийн хөгжил сул;
 - b. Цалин хөлс бага, амьжиргааны өртөг өндөр;
 - c. Орлогын хуваарилалт оновчгүй байх;
 4. Нийгмийн сэтгэл зүйн хүчин зүйлс:
 - a. Иргэдийн төрд итгэх итгэл сулрах;
 - b. Албан бус харилцааг чухалчлах хандлага;
 - c. Бизнесийн болон бусад хүрээн дэх ёс зүйн зөрчил, мөрдөх хэм хэмжээ тодорхойгүй зэрэг нь авлига үүсэж дэлгэрэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Авлигад нөлөөлөх зарим хүчин зүйлс, авлигын нөхцөл, үр дагаврын гинжин хамаарлыг дараах зургаар харуулж болно.

Зураг 1. Авлигад нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан нөлөөлөл, гинжин холбоо



Ийнхүү авлигын шалтгаан, нөхцөлийг тодорхойлж тэдгээрийн харилцан шүтэлцээт зарчмыг ойлгох нь авлигаас урьдчилан сэргийлэх арга, авлигатай тэмцэх тэмцлийн стратегийг оновчтой сонгоход чухал нөлөөтэй.



АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛИЙГ ОЛОХ НЬ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар

Дэлхийн улс орон бүр авлигатай тэмцэх хүсэл сонирхлоо хүн төрөлхтөнд зарлаж мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх сүлжээг байгуулсаар байна. Цагийн аясаар тун удахгүй хулгайлагдсан хөрөнгө байрших газаргүй, хулгай хийсэн этгээд орогнох газаргүй болох цаг айсуй гэдэгт би итгэдэг.

“Шударга байдал ба олон нийтийн итгэл” хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнд оролцож тулгамдсан асуудлаа хэлэлцэн ярилцаж, гарах гарц боломжийг эрж байгаа Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсье.

“Монгол бол Түвд биш” гэсэн нийтлэлд дурдсан “Хүүхэд насанд айлын хоол амттай ч ээжийн хийсэн хоол илүү сайхан, хүний нутгийн хөгжил, өнгө үзэмж нүд унагам сайхан ч миний эх орон түүнээс ч илүү сайхан. Тийм ээ, монголчууд бид ардчилсан нийгэмд эрх, эрх чөлөөгөө бүтэн эдэлж яваа хөгжиж буй орны иргэд” гэсэн ишлэлээр илтгэлээ эхэлье.

Бүх зүйл болохгүй, бүтэхгүй байгаа юм биш, болж байгааг ярихгүй, харин

болохгүй байгаа хийдэл, үгүйсгээд байгаа нөхцөл байдал, хийдлийг засаж залруулах нь бидний үүрэг юм.

Зарим хүмүүний хууль бус, амар хялбар аргаар хөрөнгө мөнгөтэй болж тансаг амьдрах гэсэн аминч үзэл, нийтийн албан тушаалтны бусадтай барьцах сэтгэлгээ, эрх мэдэлд хүрэх гэсэн харалган зорилго, өргөсөн тангаргаа умартсанаар Монгол хүний эрх ашиг, улсынхаа үндэсний аюулгүй байдалд бодит хохирол учруулж байгааг баримтаар нотлох, гэмтэй бол зэмтэй байх ардын сургаал, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдаад байгаа нөхцөл байдалд дүгнэлт хийхийг хичээлээ.

Нэг. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн гэж тодорхойлсон

хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, гэмт үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэдий ч хүссэн үр дүн гарахгүй, авлигын индекс сүүлийн арван жилд 36-39 гэсэн оноогоор нэг л байрандаа байсаар байна. Бид социалист онолоор хүмүүжиж, төлөвшсөн, одоо цагт либерал онол гэсэн шүтээнтэй. Энэ хоёр онол нь харшлаад урагш хоёр алхаад буцаж нэг алхаад байгаа нь улстөрчдийн төлөвшил, авлигатай тэмцэх хүсэл сонирхолтой нь шууд хамааралтай.

Хууль тогтоох байгууллагаас тодорхойлсон ялын хэт хөнгөн бодлого, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэлтэй зохицуулалт нь гэмт этгээдүүдэд давуу байдал олгож, улс төрийн сонголтын онол цэцэглэн хөгжиж эдийн засгийн онолын хэтийдсэн дүр төрх илэрч (төрийн алба, бизнес хэмээх ойлголтууд тус тусдаа ойлголт бөгөөд зоосон мөнгөөр төсөөлбөл зоосны хоёр тал гэж тодорхойлж болох боловч манай улсын хувьд зоосны хоёр талдаа бус нэг талдаа багтаж), улстөрч бүхэн бизнес эрхлэгч, баялаг бүтээгч бүр улстөрч болсон. Ялагч бүхнийг авах сэтгэлгээ давамгайлж, төрийн үйлчилгээ ялсан намын өнгөөр сүлрээд, намын томилгоотой нийтийн албан тушаалтнууд иргэндээ бус намдаа, гишүүддээ үйлчилдэг, баялгийн тэгш хуваарилалт алдагдаж, шударга ёс сүүмийсээр байна гэж хувьдаа дүгнэн хардаг.

Баялаг бүтээгч нараа дэмжиж байна гээд өршөөл, уучлал үзүүлдэг, баялаг бүтээгч нь бараа бүтээгдэхүүнээ борлуулах үедээ татвараа тооцоолж өртөг тодорхойлоогүй, татвараа хасаад арилжаа хийсэн гэж бодож байна уу? Татвар шингээсэн өртгөөр борлуулалт

хийчихээд байхад ялаа гэж өршөөл, уучлал үзүүлээд байгаа юм бэ?

Монгол Улсын дархан хил Замын-Үүд дэх гаалийн хяналт шалгалт хийдэг гаалийн улсын байцаагч нарын судалгааг авч танилцахад жижиг 76, төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий хүмүүс ихэвчлэн томилогдон ажиллаж байгаа нь тодорхой ажиглагдсан. Томоохон гэж нэрлэгдээд, иргэдийг бухимдуулаад байгаа хэргүүдийн ил эх сурвалжаас нь Та бүхэн татан авч судалгаа хийгээд үз. Улстөрчдийн эрх ашиг шингэсэн, улс төрийн шийдлүүд байх нь элбэг.

Гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг олон нийтэд таниулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, гэм буруутай этгээдүүдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах, нийтийн албан тушаалтнуудыг улстөрчдийн нөлөөллөөс ангид байх соёл төлөвшүүлэх, төрийн алба хаагчдын чадавхийг нэмэгдүүлэх, өмгөөлөгч нар хуулийн дагуу хууль, эрх зүйн туслалцаа үзүүлдэг, ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан хүмүүст хариуцлага тооцдог механизм бүрдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх чадавхид суралцуулах, хууль сахиулагч нарын үр чадварыг нэмэгдүүлж, ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан тогтоосноор гэмт үйлдлийг бүрэн илрүүлэх, хариуцлагыг шударгаар оногдуулах, шударга ёс тогтох үндэс бүрдэнэ.

Хуулийн хийдэл бүхий зохицуулалт бүрийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл, судалгаа, танилцуулга хүргүүлсээр байгаа хэдий ч засаж залруулах ажилд ахиц дэвшил гарсангүй ээ. Бид дотоод нөөц бололцоогоо ашиглан судалгаа явуулж

бодит нөхцөл байдлыг тодорхойлохоор эрх мэдэл булаацалдсан, буруугаа бусдад нялзаасан, эрх хэмжээ нь хязгаарлагдаад ирэхээр матрын нулимс унагалаа, ашиг сонирхлын зөрчил бүхий дүгнэлт хийсэн гэх мэтээр шүүмжлэл өрнүүлж мохоодог. Авлигатай тэмцэх газарт хуулиар харьяалал тогтоож өгсөн нийтийн албан тушаалтнуудын үйлдсэн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг болохоор эрх мэдэлтнүүд өөрсдийнхөө хууль бус үйлдлийг шалгах ажиллагаанд саад хийх зорилгоор хийдэл бүхий зохицуулалтыг хуульчлан өгч өөртөө, нөхдөдөө дархлаа тогтоосон гэж үзэхээс өөр тайлбар олдсонгүй ээ.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлсэн, хүний эрхийг баталгаатай эдлүүлэх оролдлого хийсэн гэж зарим хүмүүс тайлбар хийж байгаа. Энэ бол төөрөгдөл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бол оролцогч, тэдний өмгөөлөгч, прокурор, шүүх гээд хангалттай олон хүний хяналт доор явагддаг ажиллагаа.

Төсвийн үргүй зарлагыг бууруулах, авлигын хэрэгт холбогдсон төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцохыг иргэд хүсэмжилж буй энэ цаг хугацаанд бидний тулгамдсан асуудлыг Азийн хөгжлийн банкнаас анхааран үзэж, авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх үйлсэд зориулан техникийн туслалцаа үзүүлэх, бодит нөхцөл байдлыг судлан, урхаг байгаа газар, үндэс суурийг олж тогтоохоор судалгааны ажлаа эхлүүлсэн явдалд талархаж байгаагаа илэрхийлье.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ, Дубуйн гэрээ, Утаа, Асем, ЖДҮ, Эрдэнэтийн үйлдвэрийн 49% гэж нэрлэгдсэн нийтийн эрх ашгийг илтэд хөндсөн үйлдлүүдийг иргэд шүүн ярилцаж байхад нөлөө бүхий этгээдүүд энэ цаг хугацаанаас хойш төрийн хөрөнгөөр

бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг нь нэг жилээр ухрааж, хахууль өгсөн гэмт үйлдлээ илчлэн ирсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтыг үгүй хийж, хэд хэдэн удаа Өршөөл үзүүлэх тухай хууль батлан, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж амжив.

Монгол Улсад бүртгэгдэж байгаа нийт гэмт хэргийн 0,6 хувийг эзэлдэг албан тушаалтнаас албан тушаалын байдлаа ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүдийн шийдвэрлэлт үнэхээр учир дутагдалтай байна. Эдийн засгийн эрх чөлөөнд хүрч чадсан, улс төрд нөлөө тогтоосон хүмүүсийн үйлдэл нь урхагтай, хохирол нь их хэдий ч хуулийн хийдэл, гадаад оронд гарч амьдрах зэрэг ядмагхан аргачлалаар ял завших, олж авсан хууль бус давуу байдлаа хадгалах, шударга ёс тогтоох гэсэн нийтийн албан тушаалтнуудад өш хонзон санадаг, элдвээр гүтгэн доромжилдог нөхцөл байдал үүсээд удлаа.

Дэлхийн улс орнуудын төр нь ард иргэдээ аз жаргалтай амьдруулж чадаж байгаа эсэхийг “АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС”, “АВЛИГЫН ИНДЕКС” гэсэн хоёр судалгааны үзүүлэлтээр тодорхойлдог. Бид сүүл мушгисаар явааг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Францын нийслэл Парис хотод болсон FATF-ийн хурлаар тодорхойлж, Монгол Улсыг *саарал* жагсаалтад бүртгэсэн шийдвэрээ дэлхий нийтэд зарлав.

Монгол Улсад авлига газар авсан, албан тушаалтны дур зорго нэмэгдсэн гэдгийг ард иргэд хүлээн зөвшөөрч, судалгааны дүнгээр баталгааждаг байгаа нь энэ. Азийн сангийн 2019 онд хийсэн судалгаагаар Монгол Улс дахь авлигын хэрэг шийдвэрлэлт 23.89 хувьтай байгаа нь Япон, БНСУ зэрэг

өндөр хөгжилтэй улсууд болон БНХАУ-ын онцгой бүс Хонконгтой харьцуулахад харьцангуй бага байгааг тодорхойлжээ. Тэд шалгасан бүх хэргийн тоогоо бус зөвхөн мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтээр судалгаа тайлангаа гаргадаг бол бид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргээс тоон үзүүлэлтээ гаргаж буй асуудал нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын түвшинд унагах, иргэдийн итгэлийг бууруулах итгэлцүүр болсон байх үндэслэлтэй, бас анхааран үзэх өнцөг гэдгийг дурдаж байна.

Хүссэн үр дүн гарахгүй, нийгмийн бүхмдал газар авсаар байгааг судлан үзэх нь шаардлага, тулгамдсан асуудал. Дэлхийн олон улсын судлаачид бидэнд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг сонсоод гайхсан, шоолсон дүр төрхийг харуулдаг (хээл хахууль авч байгаа фактыг дуу-дүрс бичлэгээр бэхжүүлээд шүүхэд хүргүүлэхээр яг хэдэн төгрөг хахуульд өгч байгааг тогтоо, тэр даруй үйлдлийг таслан зогсоох үүргээ хэрэгжүүлсэнгүй..., хахууль өгөгч нь авагч талынхаа дарамтад ороод шүүх хурал дээр мэдүүлгээсээ буцахаар мэдүүлгийг үнэлэх, дүгнэлт өгөх боломжгүй гэж дүгнэж шийдвэр гаргаж байгаа асуудал, хахууль өгсөн, авсан этгээдүүд шүүх дээр үгсээд худал мэдүүлэг өгөхөөр цагаатгасан шийдвэр гаргасан) бөгөөд би одоо ч тэр төрхийг мартаж чадаагүй явна. Бурууг бусдаас хайх, бусдад нялзаах нь цагаа олсон зүйл биш.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэл, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй орнуудтай харилцах, мэдээлэл солилцох, нотлох баримт гаргуулан авах гээд ярилцвал барагдахгүй хүндрэл бэрхшээл байгаа бөгөөд хүнээс

хамааралтай олон асуудал ч бий.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан "... гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх зорилт"-ийг хангахад хуулийн зарим зүйл заалтууд харшилж зөвшөөрлийн зохист харилцаа алдагдсан, зарим процессийг хуульчлаагүй байдал нь мөрдөн шалгах ажиллагаа удаашрах, гэм буруутай этгээдүүд ял завшиж, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд бодит хүндрэлүүд болоод байна.

Эдгээрээс хамгийн их анхаарал татаж байгаа асуудлын нэг нь "бүрэн эрх, халдашгүй байдал" улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн тухай асуудал болж байна. "Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, адил байна, хүний эрхийн байдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй шалгууруудыг "үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол" гэж Монгол Улсын Үндсэн хууль¹-д хуульчилж өгсөн атлаа хүний эрхэлж байгаа ажил, албан тушаал зэргээр ялгаварлаж, аль нэг хэсэгт нь давуу эрх олгох, илүү үүрэг хүлээлгэх буюу үүргээс чөлөөлсөн хууль байсаар байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн², Төрийн албаны зөвлөлийн гишүүд, шүүгч нар гээд халдашгүй байдал, бүрэн эрхтэй олон хүн байна. Шүүх засаглал ажлаа хийж, шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа яагаад тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, удирдлагаас зөвшөөрөл хүсэх ёстой юм бэ. Азийн иргэдийн

¹ Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үзэх. 1992 он

² Комиссын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Комиссын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар Зөрчийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно

онцлог бол “элэгний онол”-ын илрэл ихтэй. Нэг нэгнээ хамгаална, нөгөө эрх тэгш байх зарчим алдагддаг, мөрдөн шалгах шуурхай ажиллагаа удааширч бодит нөхцөл байдлыг тогтоох баримт сэлт үрэгдэх, оргон зайлах нөхцөл болж байгааг өнөөдөр өрнөж байгаа олон улсад эрэн сурвалжлах ажиллагаа явуулж байгаа баримтаас харагдана. Эрх зүйн хэм хэмжээний эрэмбэ талаас нь авч үзвэл салбарын хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тодорхой зохицуулалтыг хязгаарласан ноцтой зөрчил юм.

Тухайн төрлийн гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг бүрэн ойлгож таньж чадаагүй байдал, гэмт хэргүүдтэй тэмцэх эрх зүйн орчин хязгаарлагдмал, оногдуулах ял шийтгэл хэт хөнгөн байгаагаас үүдэн тухайн тэмцэл тодорхой үр дүнд хүрэхгүй байна гэж үзэх үндэслэл тодорхойлогдож байна.

Хоёр. Монгол Улсын Авлигатай тэмцэх газар байгуулагдаад 13 дахь жилтэйгээ золгож байна. Энэ цаг хугацаанд олон тооны хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, олон хүнд холбогдох хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэдий ч хуулийн хийдэл, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх чадвар, эдийн засгийн эрх чөлөөнд хүрсэн, улс төрд нөлөөгөө тогтоосон зарим хүмүүсийн овжин үйл ажиллагаанаас үүдэн олон хүн ял завшиж нийгэмд бухимдал төрүүлсэн, нийтийн албан тушаалтнуудыг авлигач, 60 тэрбумынхан гэсэн ерөнхий нэрээр тодорхойлсон он жилүүд байлаа.

Улстөрч бүр авлигатай тэмцэх ажлыг №1 гэж тодотгон түүнтэй тэмцэхээ лоозогнож байгаа хэдий ч Монгол Улсад хар тамхи, авлига хэмээх сөрөг үзэгдэл газар авч байгааг доорх тоон үзүүлэлтээс харж болно. Тэмцээд байгаа хэрнээ эерэг хандлага илрэхгүй байгаа

хоёр асуудал нь нийгмийн хор аюул ихтэй, улс үндэстнийг мөхөөдөг аюултай тул жишин ярих болно. Өнөөдөр яригдаж байгаа тоо бол бүртгэгдсэн хэргийн тоо, илрээгүй болон нуугдмал хэргийн статистик мэдээлэл ямар түвшинд байгааг таах, тооцоолох боломжгүй.

Сүүлийн таван жилийн дотор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 617 бүртгэгдэж, 1337 хүн холбогдон шалгагдсан, албан тушаалтнаас албан тушаалын байдлаа ашиглан үйлдсэн гэмт хэргийн талаар 3518 гомдол, мэдээлэл иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн, 1823 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3077 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 553 хэргийг шүүхэд шилжүүлэх санал гаргаж 1079 хэргийг хаах санал прокурорт гаргасан. Шүүхэд шилжүүлсэн хэргээс 229 хүнд холбогдох 216 хэрэг шийдвэрлэгджээ.

Олон тооны хэрэг хэрэгсэхгүй болж цагаадаж байгаа үндэслэл нь 2006, 2009, 2015 онд батлагдсан Өршөөл үзүүлэх тухай хууль, 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, 2008, 2009, 2012, 2014 онд батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2015 онд батлагдаж 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм. Эдгээр хуулийн зарим тодорхойлолт, нэр томъёо оновчтой бус, олон зохицуулалт хийдэлтэй, хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх боломжгүй, олон салаа утга агуулгатай байдал, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлага хөнгөн, хөөн хэлэлцах хугацаа хэт богино байгаа нь шууд нөлөөлсөн гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн хийдэл, Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд байгаа олон хийдэл, хуулийг нэг мөр ойлгох нэгдмэл ойлголт алдагдсан, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын боловсон хүчний нөөц хангалтгүй байдал мөрдөн шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлж гэмт этгээдүүд зэм хүлээхгүй байгаа өнөөгийн бодит дүр төрх нийгэмд бухимдал төрүүлж, олон нийтийн төрд итгэх итгэл буурсаар байна. Өнөөдөр бид энэ үйл явцын ирээдүйн хор уршгийг яагаад урьдчилан тооцохгүй байна вэ?

Нийгмийн толь болох сэтгүүл зүйн салбарт зарим сэтгүүлч “хаалтын гэрээ” гэх нэртэй өвчин тусаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дүрд хувирч, нийгмийн эмч болсон шүүх засаглал ялзарч, өвчнийг анагаагч эмч нар атлаа бизнес эрхлэгч болж хувирлаа. Энэ бүхний буруутан нь НАМ төвтэй улс төрийн тогтолцоо, хэтийдсэн ардчилал буюу ялагч бүхнийг авдаг тогтолцооны гажгаар тайлбарлагдана. Эрх мэдэл олж авах, эрх мэдлээ хадгалах гэсэн аминчхан үзэлтэй хүмүүс сонгуульд ашиглах мөнгө, хөрөнгө бий болгох ажилдаа нийтийн албан тушаалтнуудыг татан оролцуулж намын санхүүжилт нэрээр, хандив нэрээр авлига нэхдэг буруу жишиг гэмт хэргийн шалтгаан болсон байхыг үгүйсгэхгүй.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь гаалийн газрын ганцхан гарц дээр 30 хоног хяналт тогтооход 60 тонн даацтай машинд ачсан цахилгаан бараа нэг айлын хэрэгцээний аяга таваг болж, суудлын авто машинд ачсан 1500 ширхэг гар утас хоосон машинаар тоологдож, татвар төлөгдөөгүй, гаалийн бүрдүүлэлт хийгдээгүй барааг гаалийн улсын байцаагч нар алба хаагчдын гарцаар зөөвөрлөж, хахууль аваад ажлаа зохих ёсоор хийхээс татгалзсан хүмүүс үйлдэл дээрээ баригдсан даруйдаа халаасан дахь мөнгөөрөө бороо оруулж, эрх мэдэл

танилгүй иргэд 14 хоногоор бараагаа шаглуулж, аргаа бараад хахууль өгдөг, танил талтай хүмүүсийн бараа гэрлийн хурдаар нэвтэрнэ. Тухайн гэмт үйлдлийг газар дээр нь илрүүлээд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байхад маргааш өдөр нь томилогдон ажиллаж байгаа этгээд үйлчилгээ авч байгаа иргэнээс хахууль аваад, мөрдөгчийн байгаа газрыг зааж тойрч явахыг зөвлөж байгаа нь бэхжүүлэгдсэн баримтаас харж болно.

Эрүүгийн хариуцлага хүлээсэн хэдхэн хүн нь хөнгөн ял шийтгэл хүлээгээд хуулийн дагуу ажлаа хийсэн төрийн албан хаагчдын нэр төрд халдах, гутаан доромжлох, биед нь халдахыг завдана. Ял шийтгэгдсэн этгээдүүд нийтийн албанд дахин томилогдоод байгаа асуудал өнөөдөр бидний ярьж байгаа бухимдалд хүч нэмсээр байна.

Хууль сахиулах чиг үүргийг ял шийтгүүлсэн хүмүүс гүйцэтгэж, тангарагтаа үнэнч байх амлалтаа зөрчсөн, улс үндэстнийхээ эрх ашгийг умартаж хувийн эрх ашгаа тэргүүндээ тавьсан хүмүүс хүний эрх ярьж, өмөөрөгчийн дүрд хувирч, бусдын өмнөөс ярих боллоо. Энэ бүхний үр дүнд гэмт этгээдийг ял завшуулах, хууль бус үйлдлийг дэмжих, хөгжин цэцэглүүлж хувийн эрх ашигтаа баригдсан хүмүүс Монгол Улсын тусгаар тогтнол, монгол хүний эрүүл мэндээр дэнчин тавьж төрөөс, төсвөөс хөрөнгөжсөөр байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан бол 18.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг

жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял” оногдуулахаар хуульчилсан.

Мөн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гэсэн бүлгийн 24.1 дүгээр зүйлд Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн “Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж хуульчилсан сонгох санкц нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Хүнийг хордуулсан этгээд хөнгөн ял шийтгэл хүлээх, зүйлчлэлийн маргаан өрнүүлэх боломж үүсэж байгаа нь энэхүү жишгээр илрэн гарна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн иргэний учруулсан хохирол, албан тушаалтан албан тушаалаа ашиглан үйлдсэн гэмт хэргийн хохирол, нийгмийн хор аюул ижил байхад оногдуулах ял нь ялгамжтай байна.

Иймд Эрүүгийн хуулийн хариуцлагын

хэм хэмжээг эргэн харж Эрүүгийн хуулийн зорилгод нийцүүлэх шаардлага тулгараад байна. Энэ бүхнийг ярихаар ажлаа хийж чадахгүй шалтаг хайлаа, эрх мэдэлд дурлагсад, матрын нулимс унагалаа, батлагдсан хуулийг шүүмжлэхгүй хэрэгжүүл гэсэн шаардлага тавьж бичдэг. Энэ бүхэн иргэдийн итгэлийг үгүй хийж байгаа юм.

Аливаа зүйлийн мөн чанарыг харж дүгнэж байх нь зайлшгүй, гэтэл өнөөдөр бид уран цэцэн үгэнд итгэдэг, харагдах байдалд итгэдэг. Цалингаас суутгаж байгаа татвараа хараад би ямар олигтойхон татвар төлөх биш гэж итгэнэ, гэтэл танаас ус рашаан ашигласан, хотын иргэний татвар, НӨАТ гэх мэтээр алхам тутамдаа татвар төлж байгаагаа мэддэггүй. НӨАТ бол бүртгэл, хяналтын систем байхаар бүтээгдсэн болохоос шууд татвар биш шүү дээ.

Баялаг бүтээгч нараа дэмжиж байна гээд өршөөл, уучлал үзүүлдэг. Нөгөө баялаг бүтээгч нь бараа бүтээгдэхүүнээ зарах үедээ татвараа тооцож өртөг тодорхойлоогүй, татвараа хасаад арилжаа хийсэн гэж бодож байна уу. Татвараа шингээсэн өртгөөр борлуулалт хийчихээд байхад өршөөл, уучлал үзүүлээд байгааг үндэслэлийг зөвтгөх үндэслэлгүй асуудал. Томоохон хэргүүдийг Та бүхэн судлаад үз. Улстөрчдийн эрх ашиг шингэсэн, улс төрийн шийдлүүд байх жишээтэй.

Авлига бүх нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлдөг байхад өгөгч, авагч хоёрын асуудал гэж ойлгоно, хахууль өгч байгаа нэгнийг хараад, хахууль өгчихөөд баярлаад байгаа асуудал.

Утаатай тэмцэнэ гэсэн лоозон бүх нийтэд илээр 20 жил амь бөхтэй байж олон албан тушаалтан хөрөнгөжсөн, утаатай тэмцэх мөнгөөрөө шинэ жил тэмдэглэнэ, хөрөнгө худалдаж авна,

гадаад улсад томилолт нэрээр зугаацна, хариуцлага тооцно гэхээр гэмт хэргийн шинж оновчтой бус байгаа байдал нөлөөлнө. Хууль тогтоогчид гэмт хэргийн шинжийг ойлгомжтой болгоод шударгаар хариуцлага оногдуулаад ирэх цагт бүрэн эрх, халдашгүй байдал гэсэн нөмрөгтэй, нам бүлэглэлийн эрх ашиг шингээсэн “Хамтын шийдвэр” нэртэй том хамгаалалтын бамбайг үгүй хийснээр иргэд төрд итгэх итгэл нэмэгдэж, монгол хүн, монгол гэр бүл аз жаргалтай амьдрах нөхцөл бүрдэнэ гэж үзнэ.

Энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор хөнөөлийг олон нийтэд таниулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, гэм буруутай этгээдүүдэд оногдуулах ял шийтгэлийг чангатгах, нийтийн албан тушаалтнуудыг улстөрчдийн нөлөөллөөс ангид байлгах эрх орчин бий болгох, төрийн албан хаагчдын чадавхийг

нэмэгдүүлэх, өмгөөлөгч нарын хуулийн дагуу өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг, ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан хүмүүст хариуцлага тооцдог механизм бүрдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх чадавхид суралцуулах, хууль сахиулагчдын үр чадварыг нэмэгдүүлж, ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан тогтоосноор гэмт үйлдлийг бүрэн илрүүлэх, хариуцлага шударгаар оногдуулах, шударга ёс тогтох үндэс бүрдэнэ.

Гутранги хүн бэрхшээлийг даван туулах сонирхолгүй, шалтаг хайдаг, чин хүсэлтэй хүн гарц хайдаг гэсэн тайлбар ихээр хийх боллоо, эрүүгийн эрх зүйн харилцаа бол төсөөтэй хэрэглэгддэггүй, гарц хайж хүний эрхийг зөрчиж, бусдын эрхэд шууд халдах нь гарц биш. Тиймээс хийдэлтэй эрх зүйн хэм хэмжээг өөрчлөн оновчтой болгох ёстой гэсэн шаардлага тавьж байгааг тунгаан бодно буй за.



АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ХОР УРШИГ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч А.Мөнхбаяр

“Та хэсэг хүмүүсийг цаг үргэлж, бүх хүмүүсийг зарим үед хуурч болох ч бүх хүмүүсийг цаг үргэлж хуурч чадахгүй” Америкийн ерөнхийлөгч Абрахам Линкольн

Өнөөгийн даяарчлагдсан дэлхийд, тэр дундаа Монгол Улсын хувьд ардчилсан нийгэм, үгүйдээ л ардчиллыг уриа тугаа болгосон хүрээ давамгайлж байгаа энэ цаг үед улс үндэстний нийгэм, эдийн засаг, түүх, соёл, зан заншил, олон улсын болон үндэсний аюулгүй байдал зэрэг бусад хүчин зүйлүүдэд нөлөөлөхүйц буюу улс үндэстнийг мөхөлд ч хүргэх аюултай гэмт хэргүүдийн нэг нь авлигын гэмт хэрэг билээ.

Авлигатай тэмцэх газар нь 2007-2017 онд 4450 эзэн холбогдогчтой, нийт 470,5 тэрбум төгрөгийн хохирол бүхий гэмт хэргийг илрүүлээд зогсохгүй, мөрдөн шалгах ажиллагааны явцад 31 тэрбум, шүүхийн шатанд 39,1 тэрбум төгрөгийг тус тус нөхөн төлүүлсэн ба 108,4 тэрбум төгрөг бүхий эд хөрөнгийг битүүмжилсэн байдаг. Мөн 2018, 2019 оны байдлаар нийт 2438 эрүүгийн хэрэг шалгаснаас

нийт хохирол 12786.4 тэрбум/12.7 их наяд/ төгрөг байх ба үүний 11.3 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн бөгөөд 9736.8 тэрбум төгрөг бүхий хөрөнгийг битүүмжилсэн байдаг.

Харин дэлхий даяарх авлигын мөнгөн дүн амьсгаа давхцам их бөгөөд авлигын талаар мэргэшсэн Германы шинжээч Вольфганг Шаупенштейн үзэхдээ 18 их наяд доллар (18,000,000,000,000) гарна¹ гэж тооцоолжээ.

Энэхүү асуудлаас урьдчилан сэргийлэх, нийгэмд учруулах хор хөнөөлийг арилгах, шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох, шударга ёс, тэгш байдлыг хангах гол арга механизм нь хууль, эрх зүйн төгс зохицуулалт байх учиртай.

Гэвч шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийг эрх зүйн үндсэн болон тусгай зарчим, онол арга зүйд нийцүүлэн хуульчлаагүй байх бөгөөд үүний улмаас энэ гэмт хэргийн үйлдэгдэх шалтгаан нөхцөл, нийгэмд учрах хор аюулын шинж байдал, хэр хэмжээ нэмэгдсэнээр Монголын нийгэм, эдийн засаг болоод бусад байдалд сөргөөр нөлөөлж хүн амыг ихээхэн хохироож байна.

¹ <http://publicwatch.mn/reports/view/212>

Өөрөөр хэлбэл ардчиллын амин сүнс болсон шударга ёс, тэгш байдлын тулгуур илэрхийллийн нэг нь иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, гэм буруутанд гэм буруугийнх нь хэр хэмжээнд нийцсэн ял шийтгэл хүлээлгэж, хохирогчийн хохирол, гомдлыг зүй ёсоор барагдуулах явдал билээ. Ингэснээр нийгэмд гарах гэмт хэргийн тоо буурч, авлига, албан тушаалын гэмт хэргийн хохирол, хор уршиг багасах учиртай.

Эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчмын ойлголт

Хууль зүйн хувьд авч үзвэл: Монгол Улсын Эрүүгийн хуулийн Авлигын гэмт хэрэгт тусгасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах /Эрүүгийн хуулийн 22.1/ гэмт хэрэгт оногдуулах ял, шийтгэл нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байгаа бөгөөд Үндсэн хуулийн 1.2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”² гэж заасан байдаг. Мөн Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйл /Шударга ёсны зарчим/-ийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”³ гэж шударга ёсны зарчмын талаар тус тус хуульчилсан байдаг.

Онол ба зарчмын хувьд мөн хууль зүйн хувьд шударга ёсны зарчимтай зөрчилдөж буй гэмт хэргийн үндсэн шинж, түүний гэм буруугийн хэлбэр, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлуудыг түүнд оногдуулах хариуцлагатай нь хамт дахин

харгалзан үзэж эрх зүйн хувьд эрэмбэ дараалалтайгаар маш нарийн судлан тогтоож, шударга ёсны зарчимд нийцүүлэн хуульчлах шаардлагатай байна.

Онолын хувьд авч үзвэл: Эрх зүйн философиин хувьд “Шударга ёс нь эрх зүйн мөн чанар, эрх зүйн бүх нийтийн тэгш байдлын зарчим, эрх чөлөөний утга учрыг илэрхийлдэг.”⁴ Өөрөөр хэлбэл “эрх зүйн шударга ёс нийгмийн харилцааны бүх субъектийн хувьд түгээмэл шударга хэмжүүр болдог” гэж заажээ. Гэтэл энэ гэмт хэрэг /эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-ийн хувьд “шударга ёсны эрх зүйн чанарыг үгүйсгэснээр мөнөөхөн эрх зүйн тэгш байдлын түгээмэл зарчмыг үгүйсгэсэн шиг байдал үүсэж, зөвхөн эрх зүйн эсрэг шинжтэй шударга ёсыг хүлээн зөвшөөрөхөд”⁵ хүрээд байна.

Эрүүгийн эрх зүйн онолын хувьд авч үзвэл: Эрүүгийн эрх зүйн онолын хувьд шударга ёсны зарчмын үндсийг дараах 3 шалгуур бүрдүүлдэг. Үүнд:

- Үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж байдал, хэр хэмжээ
- Гэм буруугийн хэлбэр, хэр хэмжээ
- Хувь хүний нийгмийн хор аюул, хэр хэмжээ зэрэг орно.

Үүнээс үзэхэд шударга ёсны зарчим нь эрүүгийн хариуцлага болон ял шийтгэлийг тодорхой этгээдийн хувийн онцлогийг харгалзан ялгамжтай оногдуулах ойлголт юм. Өөрөөр хэлбэл учирсан хор уршигт үл тохирох хэтэрхий хатуу арга хэмжээ нь шударга бусад тооцогдохын зэрэгцээ хэтэрхий зөөлөн арга хэмжээ ч шударга бус байж болно.⁶ гэж тодорхойлсон байдаг.

2 Монгол Улсын Үндсэн хууль. ТМ №1, Улаанбаатар хот, 1992он

3 Монгол улсын Эрүүгийн хууль. ТМ №7, Улаанбаатар хот, 2017он

4 Д. Лүндээжанцан Н. Жалбажав нарын “Эрх зүйн философи” 49 дахь тал, УБ хот, 2014 он.

5 Д. Лүндээжанцан Н. Жалбажав нарын “Эрх зүйн философи” 48 дахь тал, УБ хот, 2014 он.

6 Эрүүгийн эрх зүй, Жигжидсүрэнгийн Болдбаатар, Улаанбаатар хот, 2016он

Гэтэл өнөөгийн бидний дунд хэрэглэгдэж, хүчин төгөлдөр даган мөрдөгдөж буй Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн хувьд Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийн үндсэн болон тусгай зарчимтай зөрчилдөж байна. Үндсэндээ бол энэ зарчим Эрүүгийн хуулийн шударга байдал, шүүгдэгчид оногдуулж буй ял оновчтой шударга байхын бодит илэрхийлэл юм. Өөрөөр хэлбэл “гэмт хэрэгт оногдуулах хэм хэмжээ нь нийгэм, эдийн засаг, эрх зүйн /криминологи/ хувьд хангалттай үндэслэлтэй, амьдралын шаардлагад бүрэн нийцсэн байвал сая шударга сайн хууль болно”⁷ гэж ойлгож болно.

Гэтэл Эрүүгийн хуулийн Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн хувьд шударга ёсны зарчмын үндсэн шалгууруудыг зөрчсөн хэлбэртэй байх буюу тухайн гэмт хэрэгт оногдуулсан хариуцлага болох ялын

хэм хэмжээ нь зарчимтайгаа ноцтой зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл тухайн гэмт хэргийн нийгэмд учирч буй нөхөн барагдуулах боломжгүй бодит хохирол, хор уршигт оногдуулах ял нь дүйцэх ёстой юм.

Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт тулгамдаж буй асуудал

Нэг. Дээрх тодорхойлолтуудаас харахад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй эрүүгийн хариуцлага, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх ёстой боловч хулгайлах гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөлтэйгөөр үйлдсэн этгээдүүдэд оногдуулж буй эрүүгийн хариуцлага (хүснэгт 1), авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэлүүдээс харьцуулан харахад шударга ёсны зарчимд нийцэхгүй байгаа практик жишээ (хүснэгт 2) олон байна.

Хүснэгт 1. Хулгайлах гэмт хэрэгт оногдуулж буй эрүүгийн хариуцлага.

Д/д	Он,сар,өдөр	Дугаар	Шүүгдэгч	Хохирол	Ял
1	2018.02.21	35	Т.О, Б.Х	90,000₮	1 жил
2	2018.03.20	51	Т.О	162,800₮	1 жил 1 хоног
3	2018.04.24	59	М.М	25 кг банш	1 жил

Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн цахим сан⁸

7 Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол 2р боть, Суурийн Жанцан, 2014он

8 1.Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 сарын 21-ны өдрийн 35 дугаартай шийтгэх тогтоол/Монгол улсын шүүхийн цахим сан/

2.Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 сарын 20-ны өдрийн 51 дугаартай шийтгэх тогтоол/Монгол улсын шүүхийн цахим сан/

3.Ховд аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 04 сарын 24-ны өдрийн 59 дугаартай шийтгэх тогтоол/Монгол улсын шүүхийн цахим сан/

Хүснэгт 2. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт оногдуулж буй эрүүгийн хариуцлага

Д/д	Он, сар, өдөр	Дугаар	Шүүгдэгч	Хохирол	Ял
1	2019.09.23	279	Б.Б	4,098,720₮	-2 жил эрх хасах -1 жил тэнсэх
2	2019.08.28	256	Г.Ц	185,000₮	-2 жил эрх хасах -1 жил тэнсэх
3	2019.08.28	94	А.Э	9,679,000₮	-2 жил эрх хасах -1 жил тэнсэх
4	2019.10.14	152	Х.Х	2,000,000₮	-2 жил эрх хасах -1 жил тэнсэх

Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн цахим сан

Тухайлбал, Хулгайлах гэмт хэргийн хувьд үндсэн нөхцөл нь хохирлыг бага хэмжээний буюу 300,000 төгрөгийн хохирол учирсан байхыг шаарддаг ба учирсан тохиолдолд гэмт хэрэг⁹ болдог. Гэтэл энэ зүйлийн хүндрүүлэх нөхцөл буюу 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдалтайгаар гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд үндсэн нөхцөлд заасан 300,000 төгрөгийн хохирлыг шаардахгүйгээр 2-8 жилийн хорих ялыг шууд оногдуулдаг¹⁰ ба гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлж мөн гэмт хэрэгтээ гэмшсэн тохиолдолд хамгийн багадаа нэг жилийн хорих ял оногдуулдаг.¹¹ Энэхүү гэмт хэргийн хувьд оногдуулсан ял шийтгэлийг тэнсэх, хойшлуулах боломжгүй.¹²

Харин Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн хувьд үндсэн нөхцөлд хохирол шаардахгүйгээр 1-5 жилийн хорих ял оногдуулахаар¹³ заасан боловч энэхүү гэмт хэргийн гаралтаас авч үзвэл нийгэмд учруулсан хохирол нь хулгайлах гэмт хэрэгтэй харьцуулбал маш өндөр

байгаа бөгөөд энэхүү гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг арилгах, нөхөн төлөх боломжгүй байдаг. Мөн тэнсэх, ял хойшлуулах боломжтой байдаг учир энэхүү гэмт хэргийн үйлдэгдэх шалтгаан нөхцөл болох тал бий. Үүнээс харьцуулан харахад энэ гэмт хэргийн нийгэмд учруулсан хохирол, хор уршгийг харгалзахгүйгээр харилцан адилгүй ял оногдуулж байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Хоёр. Мөн энэхүү гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг хэдий ч хоёр дахь хэсэгт их хэмжээний буюу 50,000,000 төгрөгийн хохирол шаардаж байгаа нь энэхүү гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршгийн шаардлагыг өндөр тавихын сацуу 1 дэх хэсэгт заасан хохирлын шаардлагыг хэт өндөрсгөж /50,000,000 сая хүртэл хохирол учруулах боломжтой/ байгаа юм. Мөн түүнчлэн хүндрүүлэх нөхцөл байдал бүхий их хэмжээний буюу 50,000,000 төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирлыг шаардаж байгаа хэрнээ түүнд оногдуулах ял, шийтгэл нь

9 Эрүүгийн хууль. ТМ. 2016 он, №7, ЭХ-ийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцогүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

10 ЭХ-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "... үйлдсэн бол хоёр жилээс найман/2-8/ жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ."

11 Эрүүгийн хууль. ТМ. 2016 он, №7, ЭХ-ийн 6.7-р зүйлийн 1.3 дахь хэсэг/энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш, дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах/

12 Эрүүгийн хууль. ТМ. 2016 он, №7, ЭХ-ийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт "энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш, дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах"

13 Эрүүгийн хууль. ТМ. 2016 он, №7, ЭХ-ийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. "... эсхүл нэг жилээс таван/1-5/ жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

үндсэн нөхцөлд оногдуулахаар заасан ял, шийтгэлтэй адил буюу мөн 1-5 жилийн хорих ял оногдуулахаар¹⁴ заасан нь энэхүү гэмт хэргийн гарах шалтгаан, нөхцөл болж байгаа юм. Зарчмын хувьд гэмт хэргийн нөхцөл байдлыг хүндрүүлсэн тохиолдолд түүнд оногдуулах ял шийтгэл нь дагаад хүндрэх ёстой байдаг.

Дээрх харьцуулалтаас харахад эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн улмаас нийгэмд учрах хохирол, хор уршиг их байхад оногдуулах ял шийтгэл нь бага байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл нийгмийн хор аюулын шинж байдал, хэр хэмжээ, үйлдэгдсэн нөхцөл байдал зэргийг харгалзан оногдуулж буй хариуцлага нь тохирохгүй байна.

Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн олон улсын жишиг

Энэхүү судалгаагаар Япон улс, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн авлигын болон хулгайлах гэмт хэргүүдийг харьцуулан үзэв.

Япон улсын Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн гол онцлог нь үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж байдал, хэр хэмжээнд дүйцүүлэн ял оногдуулах ба авлигын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтанд учруулсан хохирлын шаардлагыг үл харгалзан тухайн төрлийн албан

тушаалд ажиллах эрхийг бүх насаар нь хасах бөгөөд энэ нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөлийг хуулиараа хязгаарлаж байгаагаараа онцлог давуу талтай.¹⁵

Эрүүгийн хуулийн 193 дугаар зүйл. Албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашигласан бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

194 дүгээр зүйл. Тусгай албан тушаалтан буюу шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан бол доод тал нь 6 сар, дээд тал нь 10 жилийн хорих ял оногдуулна.

Үүнээс үзэхэд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд оногдуулах ял шийтгэл нь чанга, гэмт хэргийн хохирол, хор уршигт дүйцсэн байх нь энэхүү гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршигийг багасгаж байна.

БНХАУ-ын Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн гол онцлог нь энэ гэмт хэргийн улмаас нийгэмд учруулсан бодит хохирол, хор уршигт дүйцүүлэн ял оногдуулдаг. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуульдаа хохирлын шаардлагыг таван хэсэгт хуваан оногдуулах хариуцлагыг тодорхой заасан байдгаараа онцлогтой. Мөн тухайн гэмт хэргийн үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөл, гэм буруугийн хэлбэр, нөхцөл байдлуудыг харгалзан торгох, хорих, цаазаар авах хүртэл ял оногдуулдаг байна. (Хүснэгт 3)

¹⁴ Эрүүгийн хууль. ТМ. 2016 он, №7, ЭХ-ийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. "... эсхүл нэг жилээс таван/1-5/ жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

¹⁵ Япон улсын Эрүүгийн хуулийн XXV бүлэг. Авлигын гэмт хэрэг. 193-р зүйл. Төрийн албан хаагч албан тушаалын байдлаа урвуулан ашиглах. 235 дугаар зүйл. Хулгай

Хүснэгт 3. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 383 дугаар зүйл

Д/д	Хохирлын хэмжээ	Үндсэн нөхцөл /хорих ял/	Хүндрүүлэх нөхцөл
1	5000 юаниас доош/2сая ₮/	0-2 жил	
2	5000-10000 юань/2-4сая ₮/		
3	5000-50000 юань/2-20сая ₮/	1-7 жил	7-10 жил
4	50000-100000 юань/20сая-40сая/	5-аас дээш жил	Бүх насаар хорих, цаазаар авах
5	100000 юаниас дээш/40сая ₮-с дээш/	10-аас дээш жил	Бүх насаар хорих, цаазаар авах

Эх сурвалж: БНХАУ-ын Эрүүгийн хуулиас¹⁶

Хэрэв 5000 юань ба 10,000 юань-аас доош юанийг шамшигдуулсан этгээд, гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа үйлдсэн хэрэгтээ гэмшсэн, өөрийн өмчийн хөрөнгийг хураалгасан бол түүнд хөнгөрсөн шийтгэл оногдуулж, эсхүл хэргээс чөлөөлөгдөх боломжтой боловч эрх бүхий байгууллагаас захиргааны шийтгэл хүлээнэ.¹⁷

Үүнээс дүгнэн үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн хувьд “албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон бол... 1-5 жилийн хорих ял шийтгэнэ” гэж заасан нь үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж байдал, хэр хэмжээ, гэм бүрүүгийн хэлбэр зэргийг харгалзан үзэхгүй байгаа бөгөөд энэ гэмт хэрэг нь “Хулгайлах” гэмт хэрэгтэй харьцуулбал нийгмийн хор аюулын шинж байдал, хохирол, хор уршгийн хэр хэмжээ нь илүү байхад оногдуулах хариуцлага, хорих ялын хэм хэмжээ нь бага байгаа¹⁸ нь шударга ёсны зарчмыг ноцтой зөрчиж байна.

Мөн Эрүүгийн хариуцлагын үндсэн зорилго болох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан

хохирлыг арилгах, гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой байдаг байтал энэхүү гэмт хэргийн хувьд хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг арилгах бус эсрэгээрээ дэмжих хандлагатай байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол /50000 нэгж, түүнээс дээш/ учруулсан бол... 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан нь энэ гэмт хэргийг үйлдэгдэх боломжийг хязгаарласан өөрөөр хэлбэл хохирлын шаардлагыг хэт өндөр тавьсантай шууд холбоотой.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, мөн хүндрүүлэх нөхцөл байдал бүхий 2 дахь хэсэгт оногдуулсан хариуцлага, хорих ялын хэм хэмжээ нь нэгэн ижил байгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг үгүйсгэж байна, мөн эрүүгийн эрх зүйн “Шударга ёсны зарчим”-д гэмт хэрэг үйлдэгдэх үеийн нөхцөл байдал, нийгмийн хор аюулын шинж байдал, хувь хүний нийгмийн хор аюул, хохирол, хор уршгийн хэр хэмжээг харгалзан үзэхгүй байна. Гэтэл БНХАУ-ын Эрүүгийн хуульд

¹⁶ БНХАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 382, 383 дугаар зүйл.

¹⁷ БНХАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 383 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

¹⁸ Хүснэгт 2.

авлигын гэмт хэргийн 383 дугаар зүйлд “Албан тушаалаа урвуулан ашиглах” гэмт хэргийн заалт бүрд хохирол, хор уршгийн хэр хэмжээг тусгаж өгсөн байдаг¹⁹ ба энэ нь гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх давуу талтай байдаг байна.

Иймд судлаач миний зүгээс авлигын гэмт хэргийг бууруулах, гарах шалтгаан, нөхцөлийг арилгах, таслан зогсоохын тулд онол, арга зүйн болон олон улсын жишигт суурилсан дараах саналыг дэвшүүлж байна:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн талаар. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүлээлгэх хариуцлага, 2 дахь хэсэгт заасан хариуцлагыг ялгамжтай байдлаар оногдуулах

/22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсгийн хариуцлагууд яг адил 1-5 жилийн хорих ялтай байна/

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хохирлын шаардлагыг багасгах буюу “Их хэмжээний хохирол” гэж заасныг “Үлэмж хэмжээний хохирол” болгон өөрчлөх.

Ийнхүү олон улсын жишигт суурилан, өөрийн улс орны зан заншилд нийцүүлэн авлигын гэмт хэргийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор энэ төрлийн гэмт хэргийн нийгэм, эдийн засаг болоод байгалийн нөөц, улс төр, эрх зүйн тогтолцоо, гадаад, дотоод аюулгүй байдал зэрэгт учруулах хохирол, хор уршгийг бууруулах, эзлэх байр суурь зэргийг хязгаарлах үр дүнтэй төгс алхам болох бүрэн боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Эрх зүйн акт:

Монгол Улсын Үндсэн хууль. ТМ. 1992он, №1

Эрүүгийн хууль. ТМ. 2002он, №5

Эрүүгийн хууль. ТМ. 2016он, №7

Авлигын эсрэг хууль. ТМ. 2006он, №35

БНХАУ-ын Эрүүгийн хууль

Японы Эрүүгийн хууль

Хоёр. Ном, сурах бичиг:

С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол” I боть (Гэмт хэргийн тухай сургаал). Улаанбаатар хот. 2009 он

С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” II боть (Ялын тухай сургаал) Улаанбаатар хот. 2014 он

С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” (Ерөнхий ба тусгай анги) схемчилсэн тайлбар, зүйлчлэл. Улаанбаатар хот. 2012 он

Ж.Болдбаатар. “Эрүүгийн эрх зүй”(Ерөнхий ба тусгай анги). Улаанбаатар хот. 2017 он

Х. Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” /Ерөнхий анги/ (Онол практикийн асуудал). Улаанбаатар хот. 2019 он

Гурав. Бусад материал:

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан

Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын Шүүхийн тайлан. УБ хот. 2017 он

Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын Шүүхийн тайлан. УБ хот. 2016 он

Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын Шүүхийн тайлан. УБ хот. 2015 он

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээ, 2017.02 сар

Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2016 он, Улаанбаатар хот, 229 дахь тал /дам ишлэл/

Дөрөв. Сайт:

WWW.legalinfo.mn

www.shuuh.mn

<http://www.parliament.mn/>

<http://www.legalinstitute.mn/>

<http://publicwatch.mn/reports/view/212>

¹⁹ БНХАУ-ын Эрүүгийн хууль /Хүснэгт 3/



ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Тэмүүжин

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 120 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 дахь бүлгийн 307 дахь хэсэгт тусгагдсан “Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулахтай уялдуулан прокурор, өмгөөлөл, мөрдөх албаны зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх” зорилтын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулахаар төлөвлөгдсөний дагуу хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн билээ.

Шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэг дэх “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны гол дэвшил нь хуучин хууль /Эрүүгийн байцаан шийтгэх хууль/-иас Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргээс бусад гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхээр заасанд

оршино. Өөрөөр хэлбэл хуучин хуульд зөвхөн тодорхой төрлийн гэмт хэргүүдэд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг байсан нь шинэ хуулиар хорих ялын хэмжээнээс нь хамаарч илүү далайцтай тусгагдсан нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг дэх авлигын гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болдог болсноороо мөрдөх байгууллагын болон хуульчдын ажлын ачааллыг бууруулах, хэргийн оролцогчдод хүндрэл, чирэгдэл бага учруулах, цаг хугацаа болон зардлыг хэмнэх зэрэг олон талын эерэг үр нөлөөтэй болсон.

Ял наймаалцах буюу Plea Bargain нь Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад, ялангуяа АНУ-ын эрүүгийн эрх зүйн тогтолцооны хамгийн чухал хэсэг нь болдог. АНУ-д эрүүгийн хэргийн дийлэнх (ойролцоогоор 9 хувь) хэргийг шүүн таслах ажиллагаанаас бус шүүхийн хэлэлцээрээр, ял наймаалцах хүрээнд шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл Америкийн хувьд прокурор, өмгөөлөгчийн хооронд хийгдэх тохиролцоог эрхэмлэдэг. Энэ нь материаллаг үнэн бодит зүйлийг тогтооход гол анхаарлаа төвлөрүүлэхгүй ба гол зарчим нь прокурор, өмгөөлөгчийн хооронд тохиролцоо хийгдэхэд оршино гэсэн үг.

АНУ-ын шүүхийн тогтолцоо нь өөрийн шүүхийн хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, АНУ-ын эрүүгийн шүүхийн тогтолцоо нь хэргийн шийдвэрлэлтэд шүүгч идэвхгүй үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэснээр шүүгдэгчийн эсрэг хэргийг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй нотлох баримт, мэдээллийг бие даан олж авах эрхгүй байдаг. Харин прокурор ял наймаалцах замаар хэргийн үр дагаврыг хянаж, шүүх нь тухайн шүүхийн шийдвэрийг шударга ёсны ашиг сонирхолд нийцүүлэн батлах замаар хэрэгждэг.

Гэвч ингэж асуудалд хандах нь онолын хувьд зөрчилтэй, дутагдалтай байдаг тухай судлаачид үздэг байна. ХБНГУ-ын Людвиг Максимилианы нэрэмжит Мюнхений их сургуулийн профессор, доктор Бернд Шюнеманн хэлэхдээ “Тохиролцоо бол иргэний эрх зүйд л байдаг асуудал. Яагаад гэвэл тэнд одоо хувийн эрх чөлөө, иргэний хуулийн субъект болж илэрдэг. Нэхэмжлэгч хариуцагч 2 тохиролцож болдог заалт Иргэний хуульд байдаг. Харин Эрүүгийн хуульд тийм зүйл заалт байхгүй. Төрийг төлөөлж байгаа прокурорт ч байх ёсгүй зүйл. Онолын хувьд яагаад болохгүй вэ гэхээр Иргэний хуулийн зарчмыг Эрүүгийн хуулийн зарчимтай холиод байдаг. Зүгээр Америк /Англи/-ийн эрх зүйн системийн хувьд бол энэ нэг их зөрчилддөггүй. Тэр системд эрүүгийн болон иргэний гэмт хэрэг гэж хооронд нь айхтар ялгаа байдаггүй. Үүнээс гадна практик дээр их хэрэглэх нь ноцтой буруу зүйл юм. Шүүхийн хүрээнд яллагдагчид “хэрэв чи хэргээ хүлээчихвэл чамд өгөх ялыг багасгана шүү” гэж прокурорын зүгээс амладаг. Тэгэхээр тэр хэрэгтэн энэ асуудлыг ингэж шийдүүлэх сонирхолтой байдаг. Асуудлыг ингээд шийдээд байх юм бол хууль ямар хэрэгтэй гэж. Хэрэв хэрэг хийсэн бол эрүүгийн хуулиар төдөн жил хоригдоно гэсэн заалт

байсаар байтал тэр тохиролцооны дагуу шийдээд, өөр ял өгнө гэдэг чинь үнэн хэрэгтээ Эрүүгийн хуулийг доромжилж байна гэсэн үг” гэжээ.

Судлаачид энэ мэтчилэн дээрх асуудалд өөр өөрийн өнцгөөс эерэг болон сөрөг байр сууринаас ханддаг боловч нэгэнтээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд энэхүү зохицуулалт хуулиараа баталгаажиж, холбогдох харилцааг зохицуулсан байх тул хууль хэрэгжүүлэгчид дээрх бүлгийг байх ёстой, эсхүл ёсгүй гэдэг байдлаар шүүмжлэлтэй хандахаасаа илүүтэй энэхүү хуулийг нэг мөр зөв хэрэглэхэд ач холбогдлоо өгөх нь зүйтэй.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэсэн 48 дугаар бүлгийг 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт болгон оруулж, дээрх бүлгийн хүрээнд 41 төрлийн хөнгөн гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой байсан.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-г 17 дугаар бүлэгт хуульчилж Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 8 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргээс бусад бүх гэмт хэрэгт яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт гаргасан, хохирлоо нөхөн төлсөн бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар зохицуулжээ.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь угтаа

тухайн үйлдэгдсэн гэмт хэрэгт яллагдагч нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч, учруулсан хохирол, хор уршгаа арилгасан тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг түргэсгэж ажлын ачааллыг бууруулах, хэргийн оролцогчдод хүндрэл чирэгдэл учруулахгүй байх, тэдгээрийн цаг хугацаа болон зардлыг хэмнэх зэрэг олон талын эерэг үр нөлөөтэй бөгөөд үйлдсэн гэмт хэрэгтэй шийтгэл хүлээх нь тодорхой гэж үзэж байгаа шүүгдэгчийн хувьд ялын хөнгөлөлт нь цагаатгах магадлалаас илүү ашигтай байдаг бөгөөд нөгөө талаас прокурорын хувьд гэмт хэрэгт шийтгэл оногдуулах нь баталгаатай байдлаар харилцан нөхцөлддөг хуулиар зохицуулагдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа билээ.

Гэвч хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд шүүгдэгч нь ял завших, хорих ялаас мултрах, хилсээр ял эдлүүлэх зэрэг бодит боломжийг агуулж хүний эрхийн эрх тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, Эрүүгийн хууль дахь шударга ёс, гэм буруугийн зарчим алдагдаж улмаар нийгмийн шударга ёсны ойлголт гажуудах, хуульчид, хуулийн байгууллагад итгэх иргэдийн итгэл үгүй болох зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй тул ямар хүрээнд, ямар нөхцөлд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах вэ гэдгийг нийгмийн хөгжил, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нарийн тодорхойлж зохицуулах нь юу юунаас илүү чухал юм.

Жишээ нь албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт хамтран үүрэг гүйцэтгэгчээр оролцсон нийтийн албан тушаалтнууд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1

дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлэх”-ээр, мөн хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд бусдаас хахууль өгөхийг шаардаж, авсан этгээд нь мөн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлэх”-ээр тус тус заагдсан байтал яллагдагч нар нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөр Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс торгох ялаар тус тус шийтгэсэн.

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэдийгээр мөрдөх байгууллага, прокурор, шүүхийн ажлын ачааллыг бууруулж, хэргийн оролцогчдод хүндрэл, чирэгдэл бага учруулж, цаг хугацаа болон зардлыг хэмнэх эерэг үр нөлөөтэй ч бусад төрлийн гэмт хэргээс онцлог, ялгагдах шинж чанартай, тодорхой нэг этгээдэд бус нийгэмд хохирол, хор уршиг учруулдаг авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхдээ нийтийн албанд томилогдох эрх болон торгуулийн ялын хугацаа, хэмжээг дээд түвшинд нь тулгаж ял шийтгэх нь зүйтэй.

Ном зүйн жагсаалт

Эрүүгийн хууль, шинэчилсэн найруулга

Эрүүгийн байцаах шийтгэх хууль

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Гантулгабатын 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн нийтлэл "<https://www.prokuror.mn/a/2293>"

Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэг, 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр, "<https://www.mglbar.mn/news/3311>"

<https://www.shuukh.mn/>



ЭД ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ, ХӨРӨНГИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ, ХЯЗГААРЛАХ ТУХАЙ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Ц.Золзаяа

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зүгээс гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ явуулахад саад болох, учруулсан хохирол, хор уршгаа барагдуулахгүй байх болон гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, гэмт хэрэг үйлдэж олсон байж болох эд хөрөнгөө нүүх, устгах санаа зорилгоор эд хөрөнгөө бусдад худалдан борлуулах, шилжүүлэх үйлдэл гаргах явдал цөөнгүй тохиолддог бөгөөд үүнээс сэргийлж мөрдөн шалгах ажиллагааны явцад эд хөрөнгө битүүмжлэх болон хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг явуулах шаардлагатай болдог ба мөрдөгч эдгээр ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулна.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2 дугаар зүйлд заасны дагуу “Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор” яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэж

байгаа ажиллагаа юм. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа явуулж байгаа мөрдөгч тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд хуульд заасан хариуцлагыг сануулж, гарын үсэг зуруулна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 28.2 дугаар зүйлд зааснаар эд хөрөнгө битүүмжлэх мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа гэрэл зураг, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлсэн байвал зохино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хүний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй бөгөөд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийх ажиллагаатай хамт явуулж болно.

Урьд үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар “Эд хөрөнгө битүүмжлэх” ажиллагааг тус хуулийн 134 дүгээр зүйлд зааснаар “Иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний эд хөрөнгийг битүүмжлэх, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг нотлох хангалттай үндэслэл байгаа бол уг хөрөнгө, орлогыг битүүмжлэх”

ажиллагаа явуулдаг байсан бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулан, битүүмжилж байгаа эд хөрөнгийг бүртгэж данслах ажиллагааг хөндлөнгийн гэрч, бусад хүмүүсийг байлцуулан тэмдэглэл үйлдэн явуулж, тэмдэглэлийн хуулбарыг эд хөрөнгөө битүүмжлүүлсэн этгээд, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгчийн аль нэгэнд заавал гардуулан өгч гарын үсэг зуруулан, улмаар уг хөрөнгийг эзэмшигч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн болон бусад боломжтой этгээдэд хадгалуулахаар өгч, эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах хариуцлагыг тайлбарлан өгч энэ тухай гарын үсэг авах хэлбэрээр гүйцэтгэж байжээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулж байсан энэ зүйл, заалтаар хэргийн сэжигтэн, яллагдагчийн өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний буюу эцэг, эх, үр хүүхдүүд, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгийг битүүмжлэн, хурааж, улмаар бусдад учруулсан хохирлыг нь тэдний хөрөнгөөр төлүүлж болохоор байсан нь “гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх” зарчмыг алдагдуулж, гэр бүлийн гишүүд, бусад этгээд нь эрүүгийн хэрэгт эд хөрөнгийн хариуцлага хүлээж, ял шийтгэлийг давхар эдэлж, хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөх үр дагавар бий болж байсан сөрөг талтай байжээ гэж үзэж байна.

Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2 дугаар зүйлд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хор үршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын

шийдвэрээр битүүмжилнэ” гэж тухайлан заасан нь мөн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй” гэсэн шударга ёсны зарчимд нийцсэн буюу гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаа өөрөө хүлээх, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол, хор үршгаа өөрийн хөрөнгөөр өөрөө арилгах, гэм буруугийн хариуцлагаа өөрөө хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн заалт болсон байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгчийн эзэмшил, өмчлөлд ямар төрлийн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байгаа болох, уг хөрөнгө ямар үнэлгээтэй болох, хэрэв гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд хөрөнгө байвал хэний эзэмшил, өмчлөлд байгаа болохыг тогтоох зэрэг ажиллагаанууд зайлшгүй хийгдэх ёстой бөгөөд тухайн эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдсэнээс хойш бусдад шилжүүлсэн, дамжуулсан, худалдан борлуулсан, нуусан эсэхийг давхар шалгаж, холбогдох баримт мэдээллийг хэрэгт хавсаргах шаардлагатай юм.

Эрүүгийн хэрэгт битүүмжилсэн эд хөрөнгийг 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 246, А80 дугаартай Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаалд заасан “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

Мөрдөгч болон прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан онцлог шинж бүхий хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг зохих байгууллагад шилжүүлэх, хадгалуулах, худалдан борлуулж орлогыг

тусгай дансанд хадгалах, устгуулах талаар мэргэжлийн байгууллагын болон шинжээчийн дүгнэлт гаргуулж, бусад холбогдох баримт нотолгоог бүрдүүлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагаа явуулах журмыг заасан бөгөөд мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр:

1. Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;

2. Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах ажиллагааг явуулна.

Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэрийг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзвэл уг шийдвэрийг хүчингүй болгож, хязгаарлалт хийлгэсэн тухайн байгууллагад шийдвэрийн хувийг хүргүүлж байх, эсхүл тухайн эд хөрөнгийг хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулахаар хураан авах ажиллагааг явуулах нь зүйтэй.

2002 оны Эрүүгийн хуульд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг тусад нь нарийвчлан тогтоогоогүй, “эд хөрөнгө битүүмжлэх”

ажиллагааг зохицуулсан журмаар мөнгөн хадгаламжийг битүүмжлэх, гүйлгээ хийхийг зогсоох ажиллагааг гүйцэтгэж байсан. Мөн хуулийн 134 дүгээр зүйлийн 134.9 дэх хэсэгт “Мөнгөн хадгаламжийг төлөх төлбөрийн хэмжээгээр битүүмжилж, байгууллагын санхүүгийн дансны гүйлгээ хийхийг зогсооно”.

2015 оны Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Харин тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.

2002 оны Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана” гэсэн заалт хэрэгжиж байжээ.

Иймд эд хөрөнгө битүүмжлэх болон хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааны ялгамжтай байдлыг ойлгож, зорилгод

нь нийцүүлж явуулах нь мөрдөгч, прокурор, шүүхийн үүрэг бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэх явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан, битүүмжилсэн эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөгчийг хэн болохыг заавал тогтоож, улмаар хохирол нөхөн төлүүлэх боломжтой эсэхийг нотолсон байвал зохино.

Эд хөрөнгө хураах, битүүмжлэх ажиллагаа хуулийн шаардлага хангахгүй байх, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй, шаардлагатай хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаагүй зэргээс түүнийг шалгах, үнэлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоход учир дутагдалтай байдал үүсэх, цаашлаад хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй байдал бий болох зэргээр хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын ажлын чанарт сөргөөр нөлөөлөх, улмаар ялтанд ял эдлүүлэх ажиллагаа хангалтгүй хийгдэх, ял завших, хариуцлагаас мултрах, хохирол төлүүлэх боломжгүй болох, хохирогчийн зөрчигдсөн эрх ашиг сэргээгдэхгүй

байх нөхцөл байдал бүрдэх зэрэг олон муу сөрөг нөлөөтэй тул энэ төрлийн ажиллагааг гүйцэтгэхдээ цаашдын үр дагаврыг тооцож хариуцлагатай, чанартай явуулах шаардлагатай юм.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа байдлыг судлахад мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг бүрэн тогтоодоггүй, гэмт этгээдийн хөрөнгийг цаг тухайд нь битүүмжилдэггүй, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаа хийгддэггүй, гэмт хэргийн замаар олж авсан хөрөнгө байгаа эсэхийг бүрэн судалдаггүй байна.

Түүнчлэн холбогдох хүмүүст иргэний нэхэмжлэл гаргах эрхийг бүрэн тайлбарлаж нэхэмжлэлийг хуульд заасан журмын дагуу гаргуулдаггүй, нэхэмжлэл гараагүй нөхцөлд хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг өөрийн санаачилгаар шийдвэрлэх тухай хуулийн шаардлагыг хэрэгжүүлэхгүй байгаа зэргээс улбаалан "Иргэний нэхэмжлэл гаргаагүй" гэсэн шалтгаанаар бодит учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэхгүй орхих тохиолдол цөөнгүй байна.



ХУЛГАЙЛАГДСАН ХӨРӨНГИЙГ ЦАРЦААХ, БУЦААН АВАХ АСУУДАЛ

АТГ-ын Мөргөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Эрдэнэсайхан

“Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох” асуудал нь манай орны хувьд шинэ судлагдахуун тул судалгаа, үнэлгээний ажлын практик хэрэглээний өгөөжийг бодолцон танин мэдэхүйн асуудлыг дэлгэрэнгүй оруулж, нэр томъёо, шинэ ойлголт, улс орон, байгууллагуудын тухай аль болох сайтар тайлбарлаж, эх сурвалжийг тухай бүр дурдсан болно.

“Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох талаар Авлигатай тэмцэх газар, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Гадаад харилцааны яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн Ерөнхий Газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Эд хөрөнгийн бүртгэлийн газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар), Гаалийн ерөнхий газрууд хамтран судалгаа, үнэлгээний ажил явуулсан.

Авлига нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд аюул занал учруулах, улмаар ардчиллын тогтолцоо, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулах, тогтвортой хөгжил, хуульд захирагдах

ёсонд хохирол учруулахуйц гэмт үзэгдэл болохыг дэлхийн улс орнууд онцолж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц (АЭК) нь авлигатай тэмцэх олон улсын анхны баримт бичиг болно. Зарим тохиолдолд Merida Convention буюу АЭК-ийг хэлэлцсэн анхны хуралдаан болсон Мексик улсын хотын нэрээр нэрлэдэг.

АЭК-ийг хууль бусаар олсон мөнгийг угааж, авлигын эх үүсвэртэй нуун дарагдуулсан хөрөнгийг буцаах процессийг өөрийн үндсэн зарчимд тооцож хуульчилж өгсөн цорын ганц конвенц гэж судлаач, мэргэжилтнүүд олонтаа тэмдэглэсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн АЭК-ийг соёрхон батлах тухай 58/4 тоот тогтоол гарч, улмаар 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон байна. Эдүгээ энэхүү конвенц нь дэлхийн 170 оролцогч улстай. АЭК нь Хүүхдийн эрхийн конвенцийн дараах хамгийн хурдан батлагдсан конвенц юм. Энэ конвенцид дэлхийн олон улс орнууд нэгдэж орсны шалтгаан нь “Хөрөнгө буцаан олгох арга хэмжээ”-ний зохицуулалт гэж үздэг.

Конвенцийг байгуулах хэлэлцээрийн үед хийсэн судалгаанд 1995-2001

онд Гаити, Иран, Нигери, Пакистан, Филиппин, Перу, Украин зэрэг орнуудын авлигач- албан түшаалтнууд 500 саяас 35 тэрбум ам.доллар хүртэлх хөрөнгийг гадаад орны банкуудад байршуулсан тухай дурджээ.

Авлигын эсрэг конвенц, түүний хэрэгжилтийн үнэлгээний механизм

АЭК-ийн хэрэгжилтийг тогтворжуулан баталгаажуулах, хянах чиг үүрэг бүхий гишүүн улсуудын бага хурал байгуулагдаж, 2006-2013 онд зургаан удаа хуралджээ. Эдгээр хурлуудаас АЭК-ийн хэрэгжилтийг хянах, үнэлэх, хөхиүлэн дэмжих, нэгдэн орсон орнууд хоорондын мэдээлэл солилцохыг дэмжих, конвенцийн хэрэгжилтийн талаар зөвлөмж, зөвлөгөө өгсөн байна.

Иордан улсад 2006 оны 12 дугаар сард хуралдсан анхдугаар бага хурлаар АЭК-ийн 63 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу “тус бага хурал шаардлагатай гэж үзвэл конвенцийн хэрэгжилтийг хангах байгууллага буюу механизм бий болгох” үүргийнхээ дагуу конвенцийн хэрэгжилтийг хянах үр нөлөөтэй механизм бий болгох шаардлага хэдийн үүссэнтэй санал нэгдэж энэ тухай 1/1 тоот тогтоолыг гаргажээ.

Бага хурал нь өөрийн үнэлгээний мэдээлэл цуглуулах, тайлагнах, конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийхэд нь оролцогч улсуудад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт тавьсны дүнд хэд хэдэн улс орон конвенцийн хэрэгжилтийн үнэлгээний механизмд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.

Манай улс хэрэгжилтийг үнэлэх эхний мөчлөгт хамрагдаж 2011 онд Конвенцийн III ба IV хэрэгжилтийг үнэлүүлсэн. Мөн төрийн бус байгууллагын зэрэгцүүлсэн үнэлгээг “Транспэрэнси Интернэшнл”

байгууллагаас хийсэн байна.

Иордан улсын Амман хотод 2006 оны 12 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд хуралдсан бага хурлаар “Хөрөнгө буцаан олгох” асуудлыг хариуцсан Засгийн газрын хоорондын ажлын хэсэг байгуулах тухай тогтоол гаргасан юм.

Ажлын хэсэг нь Австри улсын Вена хотноо 2007-2013 онд нийт долоон удаа хуралдаж хөрөнгө буцаан олгох үйл ажиллагаанд гарч буй бэрхшээл, тэдгээрийг шийдэх арга зам, хөрөнгө буцаан олгох салбарт гарч буй дэвшил, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зэрэг асуудлаар зөвлөлдөн ярилцжээ. Тухайлбал, 2010 оны 8 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд хуралдсан ажлын хэсгийн долдугаар хуралдаанаар Конвенцийн 54, 55, 56, 58 дугаар зүйлийн хэрэгжилтэд гарч буй бэрхшээл, дэвшилтэт үйл ажиллагаа, тэргүүн туршлагын талаар ярилцсан байна.

Монгол Улс энэхүү ажлын хэсгийн хуралд 2008, 2010, 2013 онд төлөөлөгчдөө оруулжээ. Судалгаа, үнэлгээний явцад манай улс нь хөрөнгө буцаан олгох харилцаанд хамаарах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэглээ дутмаг, нэгдсэн ойлголт хангалтгүй байгаа нь илэрхий байсныг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Өнгөрсөн он жилүүдэд АТГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан авлигын гэмт хэргүүд нь 256,5 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 39,8 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилсний 17,1 тэрбум төгрөгийн хөрөнгийг буцаасан байна.

Хөрөнгө буцаан олгосон жишээ

Филиппин улсын Ерөнхийлөгч асан Фердинанд Маркос эх орноосоо хулгайлсан олон тэрбум долларыг АНУ, Швейцарийн банкуудаар дамжуулж угааж байсан ба Филиппиний хууль

хяналтын байгууллагын төлөөлөгчид 20 гаруй жилийн турш ажилласны үр дүнд 700 орчим сая ам.долларыг эх орондоо буцааж авсан байна.

Маркос сонгогдох үедээ ард иргэдийн амьдралын нөхцөл, газрын бодлогын шинэчлэлийг амлан төрийн тэргүүн болжээ. Маркос 1969 онд дахин сонгогдож төрийн эрх барьж байх үедээ 1972 онд улс орондоо онцгой байдал тогтоож Үндсэн хуулиа өөрчилж өөрийгөө тахин шүтүүлэх замд орсон байна. 1986 онд Филиппин Улсад ерөнхийлөгчийн ээлжит бус сонгууль болж Маркосын өрсөлдөгч нь Бенино Акиногийн бэлэвсэн гэргий Корасон Акино байв. Маркосыг сонгуульд ялсан ч Акино үүнийг эсэргүүцэж католик сүмийнхний, дараа нь армийн дэмжлэг авсан. Улс орон даяар эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж төрийн эргэлт болж Маркос Хавай руу зугтсан байна.

Филиппин Улсын Засгийн газраас тооцоолсноор Маркосын хулгайлсан 600 саяас 1.5 тэрбум ам.долларыг АНУ-аас буцаан авахаар байсан боловч 1986-2006 оны хооронд АНУ-аас зөвхөн 50 сая хүрэхгүй ам.долларыг буцаан авсан байна. Швейцариас буцаан авах 1 тэрбум ам.доллараас 1986-2006 онд Швейцарийн банкуудад Маркос болон түүний хамсаатнуудын нэр дээр байршуулсан хадгаламж болох 374 ам.доллар /хүүгийн хамт 658 ам.долларыг/ буцаан авсан байна.

Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олж авахад гарсан бэрхшээлээс дурдахад:

- Маркос болон түүний тойрон хүрээлэгчдийн Филиппин улсаас нийт хулгайлж, ашиглан шамшигдуулсан хөрөнгийн хэмжээг бүрэн тогтоох мэдээлэл хомс;
- Маркосын гадаадад байршуулсан хөрөнгийн талаарх мэдээллийг

цуглуулах, баримтжуулахад гарсан хүндрэл болон гадаад улсын Засгийн газрууд хөрөнгө буцаан олгох тал дээр хойрго хандсан байдал

- Маркосын мөнгөн хөрөнгө байршиж байсан дансны мэдээллийг холбогдох банкууд нэн даруй мэдээлэх боломжгүй байсан, эсвэл мэдээлэх сонирхолгүй байсан;
- Эрүүгийн гэмт хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулаагүй;
- Хулгайлагдсан хөрөнгөөр худалдаж авсан үл хөдлөх хөрөнгө нь зээлийн барьцаанд тавигдсан;
- Банкны дансан дахь мөнгөн хөрөнгөнд гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан гэх мэт хүндрэл бэрхшээл гарсан байна.

Нигерийн Ерөнхийлөгч асан Сани Абача улс орноосоо найман тэрбум ам.доллар хулгайлж гадаадын банкуудад байршуулсан байна. “Транспэрэнси интернэшнл” байгууллагаас түүнийг орчин үеийн дэлхийн түүхэнд 4 дэх том авлигач гэж нэрлэсэн. Нигерийн үндэсний баялгийн 10 хувийг дээрэмдсэн түүнийг нас барсны дараа Нигерийн Засгийн газар 700 сая ам.долларыг нутагтаа буцаан авч чадсан байна.

Перу улс Тагнуулын ерөнхий газрын даргын албыг олон жилийн туршид хашсан Владимиро Монтесиносын хулгайлсан 174 сая ам.долларыг Швейцар, Кайман арал болон АНУ зэрэг улс орноос буцаан авсан байна.

Хөрөнгө буцаан олгосон жишээ

Монгол Улс ба БНСУ-ын Засгийн газар хоорондын “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-г үндэслэн, хоёр орны “Прокурорын байгууллага хоорондын

хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн дагуу 2011 онд БНСУ-ын шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангажээ.

БНСУ-ын дээд байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт ба тус байгууллагыг төлөөлөх итгэмжлэлийг Монгол Улсын Ерөнхий Прокурорын газарт илгээсэн.

Энэхүү итгэмжлэлийг үндэслэн Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь БНСУ-ын шүүхийн шийдвэрт заасан үл хөдлөх эд хөрөнгийг ба Монгол Улсад бүртгэлтэй холбогдох компанийн дансыг битүүмжилсэн байна. Үүний зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэж, БНСУ-ын шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд ногдох хөрөнгийн зарим хэсгийг тус улсад буцаах, ингэхдээ Монгол Улсын талаас зохих журамд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны урамшуулал болон бусад зардлыг хасаж тооцон, үлдэх хэсгийг шилжүүлсэн байна.

Гадаад улсуудын эрх зүйн туслалцаа үзүүлэх, хөрөнгө буцаан олгох үйл ажиллагааны тухай

Мексик Улсад 2012 онд хуралдсан "Их 20"-ийн уулзалт хуралдаанаас гаргасан "Их 20-ийн улс орнуудаас харилцан эрх зүйн туслалцаа хүсэх зааварчилгаа" хэмээх гарын авлага гарсан ба энэ баримт бичигт АНУ, БНХАУ-ын эрх зүйн туслалцаа үзүүлэх, хөрөнгө буцаах үйл ажиллагааг дурдсан байна.

Америкийн Нэгдсэн Улс нь НҮБ-ын Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг болон Авлигын эсрэг конвенцийг хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор 70 гаруй улс орон, газар нутагтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хэлэлцээр байгуулж хамтран ажиллаж байна.

Түүнээс гадна БНХАУ-тай Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, Их Британи, Нидерланд, Сингапур зэрэг орнуудтай "Мансууруулах бодисоос олсон хөрөнгийг хураах", "Харилцан хуваалцах гэрээ" тус тус байгуулжээ.

Мөн Канад улс, Кайманы арлууд, Колумб, Эквадор, Ямайка, Мексик болон Монако улсуудтай "Хөрөнгө хуваалцах гэрээ" байгуулаад байгаа юм байна.

АНУ-ын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ нь дэлхийн 47 улс орны СМА-тай санамж бичиг үйлдэх зэргээр хамтарч ажилладаг байна.

АНУ-ын төрийн департамент нь харилцан ашигтай байдлаар хамтран ажиллаж, мансууруулах бодисын худалдаа, мөнгө угаах ажиллагаанаас хураагдсан хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хувийг мансууруулах бодисын хууль бус худалдаатай тэмцэх, энэ талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашигладаг тухай мэдээлжээ.

АНУ-ын Засгийн газар нь 1989-2011 оны хооронд хууль бусаар олсон, хулгайлагдсан хөрөнгө буюу нийт 235,925,145.00 ам.долларыг 38 улс оронд буцаахад хамтарч ажилласан гэх бөгөөд өөрийн цахим хуудаснаа бусад орнуудад зааварчилгаа болгож "АНУ дахь хөрөнгө буцаах механизм ба процесс" гэдэг нэртэй гарын авлагыг байрлуулжээ. Уг гарын авлагад хөрөнгө буцаах ажлыг гардан хийх байгууллагуудын нэрс, эрх зүйн туслалцаа хүсэх, хөрөнгийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа хийх, хураах тухай мэдээллүүд орсон.

АНУ-ын Засгийн газар нь хулгайлагдсан хөрөнгийг илрүүлж, хууль ёсны эзэмшигчид нь буцаах сонирхол байгаа гэдгээ албан ёсоор илэрхийлэхийн хамт хулгайлагдсан хөрөнгөө нэхэмжлэхийг бусад улс орнуудын засгийн газарт уриалж байна.

Гэсэн хэдий ч нүсэр хууль тогтоомж, төрийн байгууллагуудын шат дамжлага, банк, санхүүгийн байгууллагуудын харилцагчийн нууц хадгалалтын хэт хатуу тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан хөрөнгө буцаах ажиллагаа маш их хугацаа шаарддаг болохыг Филиппин улсын огцорсон ерөнхийлөгч Фердинанд Маркос, түүний төрөл садан болон найз нөхөд, хамтран зүтгэгчдийн хулгайлсан хөрөнгийг буцаах кейсээс харж болно. Филиппиний Засгийн газар хүсэлтээ 1986 онд АНУ-ын Засгийн газарт анх гаргажээ.

БНХАУ нь хөрөнгө буцаах олон улсын ажиллагааны хүрээнд өөрийн дотоодын холбогдох хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын конвенц, олон улсын хоёр талт гэрээг баримталдаг. БНХАУ нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг дэлхийн 50 оронтой байгуулаад байгаа бөгөөд НҮБ-ын хэд хэдэн конвенц буюу НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон байна. Хөрөнгө буцаах асуудлаар дараах зарчмуудыг баримталдаг байна. Үүнд:

Эрх зүйн үндэслэл. БНХАУ-ын нэгдэж орсон олон улсын конвенц болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хөрөнгө буцаах хүсэлтийг хүсэлт гаргаж буй орон хүргүүлнэ. Дээр дурдсан нөхцөл бүрдээгүй тохиолдолд харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн гэрээ байгуулах, эсхүл дотоодын хүчин төгөлдөр хууль, дүрэм журмуудыг мөрдлөг болгоно.

Албан ёсны ажиллагаа. I алхам: Хүсэлт гаргаж буй тал нь БНХАУ-ын эрх бүхий төв байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргана.

II алхам: БНХАУ-ын эрх барих төв байгууллага нь холбогдох хууль хяналтын байгууллагуудын хамт уг хүсэлт нь БНХАУ-ын эрх зүйн зарчмууд, улс орны ашиг сонирхлыг зөрчиж буй эсэх, хүсэлтийг

хүлээж авахгүй байх үндэслэл байгаа эсэхийг шалгасны үндсэн дээр хариу тоот илгээнэ.

III алхам: Хоёр талт гэрээ, олон улсын конвенц болон өөрийн дотоодын хуулийн хүрээнд хүсэлтэд өгөгдсөн мэдээллийн дагуу холбогдох байгууллагууд нь хөрөнгийг илрүүлнэ.

IV алхам: БНХАУ-ын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу илрүүлсэн хөрөнгийг царцааж битүүмжлэх ажиллагаа хийгдэнэ.

V алхам: Нэгэнт хөрөнгийг царцааж битүүмжилсний дараа хүсэлт гаргаж буй тал хөрөнгийг хураах албан ёсны хүсэлт, шүүхийн шийдвэрийн хуулбарыг Хятадын талын төв байгууллагад илгээнэ. Төв байгууллага нь эцсийн шийдвэрийг гаргахаас өмнө уг баримтуудыг холбогдох байгууллагууд руу шилжүүлж хянуулна. Буцаах хөрөнгийг талууд харилцан хувааж хуваарилах зарчим баримтлах тохиолдолд дээр дурдсан олон улсын болон хоёр-талт гэрээ, хэлэлцээр, конвенц баримтлах эсхүл харилцан хэлэлцэсний дагуу гэрээ байгуулах боломжтой.

Бусад төрлийн ажиллагаа. Тодорхой хэргийн төрөл, хамрах цар хүрээ нээс шалтгаалан хүсэлт гаргагч тал нь илүү албан бус арга буюу цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар зэрэгт шууд хүсэлт гаргах аргаар хамтран ажиллаж болдог.

Хөрөнгийг тодорхойлох. БНХАУ-д байгаа хөрөнгийг буцааж авахын тулд юуны өмнө ямар шугамаар хүсэлт гаргах болсноо мэдээлэх шаардлагатай (албан эсхүл албан бус). Дор дурдсан механизмуудыг ашиглаж хөрөнгийг тодорхойлж болох бөгөөд эдгээр мэдээллийг олж авахын тулд цагдаагийн байгууллага, эсвэл бусад холбогдох байгууллагуудын зөвшөөрөл, туслалцааг хүсэх шаардлагатай:

- Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ;
- Үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгийн (автомашин, усан онгоц, нисдэг онгоц г.м) бүртгэл хөтөлдөг засгийн газрын байгууллагын бүртгэлийг хянах боломж хүсэх;
- Том аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг үзэх (захирал, хувьцаа эзэмшигч г.м);
- Татварын газруудаас хувь хүний, аж ахуйн нэгжийн татвар төлөлтийн тухай мэдээлэл судлах;
- Бүртгэлтэй траст болон түүний эзэмшигчдийн талаар мэдээлэл олж авах.

Хөрөнгийг буцаах. Нэгэнт хулгайлагдсан хөрөнгийг тодорхойлсны дараа БНХАУ нь дараах тусламж үзүүлэх боломжуудыг олгодог. Хүсэлт гаргагч талын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэл болгох буюу тухайн хөрөнгийг эзэмшигч нь шүүхээр ял шийтгүүлсэн байх ёстой бөгөөд хүсэлт нь зарчимд мөн нийцэх ёстой.

Хүсэлтэд дурдсан хэргийн зүйлчлэл нь зарчимд нийцэхгүй байх тохиолдолд БНХАУ-ын хүчин төгөлдөр хуулийг сайтар судалж, тэдгээрт нийцүүлэх арга хэмжээ авахыг холбогдох зааварчилгаанд зөвлөдөг.

Хөрөнгө буцаах ажиллагааг хоёр талт болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний зүйл заалтын дагуу буцаана. Ийм гэрээ хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд тухайн хэрэг бүр дээр талууд харилцан тохиролцоо боломжтой.

Хүсэлт гаргагч тал нь банкны дансны дугаар, трастын аукцион зэрэг үл хөдлөх хөрөнгийг хэрхэн шилжүүлэх талаарх мэдээллийг БНХАУ-ын эрх бүхий төв байгууллагад албан ёсоор өгнө. Энэхүү зааварчилгааны дагуу бусад орнууд

БНХАУ-д байгаа хулгайлагдсан хөрөнгийг нэхэмжлэн буцааж авах боломжтой бөгөөд БНХАУ нь өөрөө бусад улсуудаас өөрийн хөрөнгийг хэрхэн нэхэмжилж байгаа тухай мэдээлэл хомс байдаг.

Харин олон улсад нэр хүндтэй, судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг байгууллагууд, өндөр хөгжилтэй улс орнуудын төрийн тэргүүнүүд нь өөрийн тайлан, илтгэлдээ иш татдаг иргэний нийгмийн гурван байгууллагын судалгааны материалыг ашиглан БНХАУ болон АНУ-ын талаар зарим тоо, үзүүлэлтүүдийг тоймлох боломжтой. БНХАУ-ын засаг захиргааны тусгай бүс Хонконгоор дамжуулан АНУ-д нийт 115 тэрбум долларын бараа импортлогдсон тухай мэдээлэл АНУ-д байхад энэ тухай мэдээлэл БНХАУ-д байхгүй буюу “АНУ-д экспортолсон гэх бараа бүртгэгдээгүй байжээ”. Энэ нь ихэд анхаарал татсан байна.

Энэ судалгааг явуулсан иргэний нийгмийн байгууллага нь нэг зүйлд анхаарлаа хандуулахыг хүсэж байсан нь уг судалгаанд зөвхөн худалдааны тоо мэдээг ашигласан бөгөөд мансууруулах бодис бусад хил дамнасан гэмт хэргээс олдсон бохир мөнгө, том аж ахуйн нэгжүүдийн гүйлгээ, бэлэн мөнгөний гүйлгээ зэрэг нь уг тайланд тусгагдаагүй гэдгийг судалгааны тайлан, аргачлалын тухай хэсэгтээ тэмдэглэсэн байна.

АЭК-ийн хэрэгжилтийг нэг мөр хангахын тулд саад учруулж буй асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг нь тодорхойлох оролдлогыг улс орнууд, олон улсын байгууллагууд хийсээр ирсэн байна.

Манай улсын хувьд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Үүнд:

- Хөрөнгө буцаах талаар ил тод, дэлгэрэнгүй бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

- хөрөнгө буцаах мэргэшсэн тусгай агентлаг, эсхүл нэгж байгуулах;
 - шүүгч, прокурор зэрэг ажилтнуудад хөрөнгө буцаах талаар тусгай сургалт явуулах;
 - дотоодын хууль тогтоомж, олон улсын конвенцийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай явуулахыг тэргүүн зорилгоо болгон холбогдох байгууллагуудад хангалттай тооны мэргэшсэн ажилтнууд ажиллуулах боломжоор хангах;
 - томоохон хөрөнгө буцаах хэрэгт хэд хэдэн улс орон оролцох тохиолдолд хамтарсан ажлын хэсэг байгуулах, эсхүл тэдгээр улсуудын хамтарсан уулзалтуудад оролцох боломжоор хангаж олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, хулгайлагдсан хууль бус эх үүсвэртэй байж болох үндэслэл гэж үзэн аливаа хүсэлтийг хүлээн авч шалгах;
 - хулгайлагдсан хөрөнгийн үнэтэй тэнцэх хэмжээний бусад хөрөнгө, эд зүйл хурааж, хулгайлагдсан хөрөнгө үрэгдэхээс сэргийлж хүсэлтэд дурдсан хөрөнгийн үнэтэй тэнцэх хэмжээний хөрөнгө битүүмжлэх, эсхүл хураах боломжоор хангах;
 - Шүүн таслах ажиллагаанаас өмнө хулгайлагдсан хөрөнгийг буцаах, үрэгдэхээс сэргийлэх арга хэмжээ авах, битүүмжлэгдсэн хөрөнгийн менежментийг тодорхой хуульчлах, эсхүл хариуцагч нас барсан, оргон зайлсан, сураггүй болсон, дипломат эрх ямба, эсхүл халдашгүй байдал нь хуулиар хамгаалагдсан зэрэг тохиолдолд гэм буруутай эсэхийг шүүх тогтоохоос өмнө хөрөнгө буцаах боломжийг хуульчлах;
 - хөрөнгө буцаах нэхэмжлэлээр үүсгэгдсэн иргэний хэрэгт хариуцагчийг оролцох боломжоор хангах;
 - гэм буруутай этгээдийг ял үл завшуулах;
 - Мөрдөн байцаах болон тагнуулын байгууллага, прокурор, шүүх нь авлига, мөнгө угаах төдийгүй эдийн засгийн гэмт хэргүүдийг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажиллагаа явуулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих, шүүн таслах ажиллагааг тус тус эрхлэн гүйцэтгэдэг хуульчид (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч)-ыг чадавхжуулах, мэргэшүүлэх, давтан сургах;
 - нарийн мэргэжлийн хуульчид (авлига, мөнгө угаах гэмт хэргээр мэргэшсэн гэх мэт)-ыг тусгайлан бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх;
 - шинэ тутам үйлдэгдэж буй гэмт хэрэг, тэдгээрийг үйлдсэн арга техник, хамрах хүрээг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, криминологийн судалгаа хийж байх, холбогдох судалгаа мэдээллийг тухай бүр хуульчдад хүргэх шаардлагыг ханган ажиллах хэрэгтэй. Үүнийг мөн хуульчдыг бэлтгэх сургуулиуд анхаарч ажиллах нь зүйтэй юм.
- Иргэний нийгмийн байгууллагууд нөлөөллийн ажил хийх, хэвлэл мэдээллийн ажилтнууд сэжиг бүхий хэрэгт эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мэдээллийг бэлтгэж, нийтийн хүртээл болгон улс төрчдөд тодорхой арга хэмжээ авах хүсэл эрмэлзэл бий болгодог. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн ажилтнуудын авлига, мөнгө угаах тухай мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах нь ач холбогдолтой арга хэмжээний нэг болно.
- Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд хамтарсан мөрдөн шалгах нэгж байгуулах нь авлига, мөнгө угаах

гэмт хэргийг шийдвэрлэх, гэм буруутай этгээдэд ял үл завшуулах боломжийг нээж өгдөг. Хамтарсан нэгжийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулж, засаг захиргааны нэгжүүдэд байгуулдаг байна. Мөрдөн шалгах хамтарсан нэгжийг тодорхой хэрэг шийдвэрлэх ажлын хэсэгтэй адил мэт ойлгохгүй байвал зохино. Энэ нь илүү нээлттэй, хамтран ажиллах нь агентлаг хоорондын явцуу болоод жижиг эрх ашгийг хамгаалах гэсэн өрсөлдөөн, хэнээг арилган “бид нэг зорилгын төлөөх төрийн албад” болох эв санааны нэгдлийг үхамсарлуулахын хамт төрийн байгууллага-ажилтан хоорондын итгэлцлийг бэхжүүлнэ. Энэ нь авлигаас, гэм буруутай этгээд ял завшихаас сэргийлэх үйл ажиллагаанд үнэлж барамгүй дэм үзүүлнэ.

Мөнгө угаахын болон авлигатай тэмцдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгдмэл, цогц санг байгуулж, аль нэг газарт нь төвлөрүүлэх нь оновчтой. Боломжтой бүх тохиолдлуудад хуулийн болон бүтцийн давхардлыг арилгах арга хэмжээ авах нь зүйтэй болов уу.

Мөнгө угаахын эсрэг үйл ажиллагаа нь ярвигтай, ээдрээ төвөгтэй. Иймд олон улсын хөгжлийн агентлагууд нь хөгжиж буй орнуудын хууль хэрэгжүүлэх байгууллагуудын дэд бүтцийг сайжруулах, түүнчлэн хөгжиж буй орнууд өндөр хөгжилтэй орнуудын хооронд ажилтнууд солилцож ажиллах хөтөлбөрүүд хэрэгжүүлэх нь үр дүнгээ өгнө.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь эрх мэдэл бүхий хувь хүн, байгууллагын хууль бус, ёс суртахуунгүй үйл ажиллагаа, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний эсрэг үйлдлийг илчилж, олон түмэнд мэдээлж, нийгмийн хөгжлийн үнэт зүйлс болох эрх чөлөө, ардчилал, ил тод байдлыг хамгаалдаг. Мөн үл хөдлөх хөрөнгө, аж ахуйн нэгжүүдийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах, хэрэглэх, шаардлагатай мэдээлэл авах боломжтой програм хангамжийг нэвтрүүлэх нь зүйтэй.

Ашигласан материал:

- Авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын номын санд зориулж бэлтгэсэн зарим нийтлэл
- Авлигын эсрэг конвенцийн V бүлэг. (Хөрөнгө буцаан олгох тухай.)



АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД ЭРХЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦААНЫ ГЭРЭЭ БОЛОН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Б.Батбилэг

Дэлхийн улсууд авлига нь нийгмийн тогтвортой, аюулгүй байдалд бэрхшээл, аюул занал учруулж, улмаар ардчиллын тогтолцоо ба үнэт зүйлс, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулан сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулахуйц байгаад сэтгэл зовнин, авлига нь бусад гэмт хэрэг, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг ба эдийн засгийн гэмт хэрэг, түүний дотор мөнгө угаахтай холбоотой байдаг зэргийг хүлээн зөвшөөрч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор Авлигын эсрэг конвенцийг батлан гаргасан байдаг. Өнөөдрийн байдлаар тус конвенцид 183 орон нэгдэж 140 орон гарын үсэг зурж баталгаажуулсан. Манай улс 2005 оны 10 дугаар сарын 7-ны өдөр соёрхон баталж нэгдэн орж олон улсын өмнө тодорхой үүргийг хүлээсэн нь Монгол Улсын авлигын эсрэг тэмцлийн хүсэл зоригийн томоохон илэрхийлэл болсон.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үр нөлөөгөөр Монгол Улсын Их Хурал 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, уг хуулийн дагуу 2007 оны нэгдүгээр сарын 11-ний өдрөөс

эхлэн авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газар байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй.

Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүргийн нэг болох мөрдөн шалгах ажиллагаанд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, бусад эрх зүйн харилцан туслалцааны гэрээнүүдийн үүрэг ач холбогдлын талаар авч үзье.

Авлига үүссэн цаг хугацааг төрт улс үүссэн, өөрөөр хэлбэл нийтийн албан тушаал бий болсон цаг үетэй холбож ойлгож болох ч авлига нь улс нийтийн ашиг сонирхол, эд баялаг, шударга ёс, нийгмийн тогтвортой хөгжил, бүр цаашилбал хувь хүний ёс суртахуунд хүртэл асар өргөн хүрээнд ноцтой хор хөнөөл учруулах гэмт үйлдэл учраас эрт дээр үеэс хуулиар болон ёс зүйн үүднээс хориглосоор иржээ. Тухайлбал, НТӨ II мянганы үед бичигдсэн, хүн төрөлхтний

хамгийн эртний бичмэл хууль гэгдэх Вавилоны хаан Хаммурапийн хуульд нийтийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг дурдсан байдаг билээ.

Авлига нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд аюул занал учруулах, улмаар ардчиллын тогтолцоо, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулах, тогтвортой хөгжил, хуульд захирагдах ёсонд хохирол учруулахуыц гэмт үйлдэл болохыг дэлхийн улс орнууд онцолж байна.

Орчин үед хүчтэй өрнөж буй глобалчлалын нөлөөгөөр дэлхий нийтэд болон Монгол Улсад авлигын гэмт хэрэг үйлдэгдэх арга зам улам нарийн болж, эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй орнууд болон оффшор бүсэд албан тушаалаа ашиглан хууль бусаар олж авсан их хэмжээний мөнгөө хадгалах, үл хөдлөх хөрөнгө болон хувьцаа худалдан авах зэргээр эдийн засгийн эргэлтэд оруулж хууль бус хөрөнгөө хууль сахиулагчдаас нуун далдалж байна.

Монгол Улсын хувьд жил ирэх тусам авлига, албан тушаалын гэмт хэрэг нэмэгдэж илрүүлэлтийн тоо ч өссөөр байна. Авлигатай тэмцэх газар 2019 онд 1559 үйлдэлтэй, 481 холбогдогчтой, 1300 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Нийт шалгасан хэргийн 156 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 556 хэргийг хаах саналтай, 80 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 22 хэргийг нэгтгэн шалгаж, 1 хэргийг түдгэлзүүлж, хэргийн шийдвэрлэлт 62.6 хувьтай, шүүхээр 68 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 12 их наяд (12,123,202,011,893) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 11,343,770,066 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр,

орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 9.7 их наяд (9,736,776,389,079) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан нь Авлигатай тэмцэх газрын гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүн хүч, бололцоог дээрх тоон үзүүлэлттэй харьцуулан үзэхэд чамгүй их хөдөлмөрийн үр дүн хэдий ч хулгайлагдсан хөрөнгө царцаах, улсдаа буцааж авах, гадаад улс орны нутаг дэвсгэрт байршсан Монгол Улсаас гарал үүсэл бүхий хөрөнгийг олж тогтоох ажилд төдийлөн амжилт гаргаж чадахгүй байна.

Аливаа гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын хамтын ажиллагааны чухал хэлбэр бол Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудал юм. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудлыг олон улсын түвшинд хоёр талт, олон талт гэрээгээр зохицуулахын сацуу дипломат шугамаар хүсэлт тавих боломж байдаг.

Олон талт олон улсын гэрээ тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын /Палермогийн/ Конвенц түүний нэмэлт гурван протоколыг дурдаж болно. Энэхүү хоёр конвенцид Монгол Улс нэгдэн орсон. Конвенцид заасны дагуу гишүүн орнууд авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар өөрсдийн холбогдох байгууллагаараа дамжуулан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх салбарт хамтран ажиллах боломжтой болсон. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын /Палермогийн/ Конвенцид хуулийн этгээдийн хүлээх хариуцлага, албадлагын арга хэмжээ авах, хэрэг хянан шийдвэрлэх эрх, гэмт этгээдийг шилжүүлэх, эрх зүйн

туслалцаа харилцан үзүүлэх, хамтарсан мөрдөн байцаалт явуулах аргуудын талаар, гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг асуудлыг тусгасан байна.

Хоёр талын олон улсын гэрээ тухайлбал, Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ (1999 он), Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын гэрээ (1997 он), Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ (2001 он) гэх зэрэг нийт 15 улстай Монгол Улс энэ төрлийн гэрээг байгуулаад байна.

Одоогийн байдлаар Монгол Улс нь 20 улс оронтой хоёр талт 28 гэрээ байгуулсан байна. Үүнээс:

- Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ-17 улстай;
- Иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ-17 улстай;
- Гэмт этгээд шилжүүлэх тухай гэрээ-17 улстай;
- Ялтан шилжүүлэх тухай гэрээ-9 улстай тус тус байгуулсан байна.

Монгол Улс бусад оронтой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ хэлэлцээрийн дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах ажлуудыг хийсэн байна:

Хууль зүй, дотоод хэргийн яам гадаад дотоодын байгууллагаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг холбогдох байгууллагуудад нь хүргүүлэн шаардлагатай лавлагаа мэдээлэл гаргуулж, орчуулгыг хянах зэргээр дэмжлэг үзүүлсэн байна. Ихэвчлэн БНХАУ, ОХУ,

Казакстан, Турк, Польш, Чех зэрэг улсаас хүсэлт ирж байна.

Монгол Улсын хувьд сүүлийн 3 жилд гадаад улсад нийт 88 хүсэлт илгээсэн байна.

2019 оны 4 дүгээр улирлын байдлаар гадаад, дотоодын байгууллагаас нийт 50 гаруй эрх зүйн туслалцааны хүсэлт хүлээн авснаас 9 хүсэлт нь эрүүгийн хэрэгт туслалцаа хүссэн байна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэхээр хүлээн авсан, илгээсэн хүсэлтийн ерөнхий утгыг сүүлийн 3 жилийн хувьд авч үзвэл авлига, албан тушаалын шинжтэй хэргүүд, бусдыг залилан мэхлэх, ялангуяа цахим халдлагад өртсөний улмаас гадаад улсад их хэмжээний мөнгө шилжүүлэн хохирсон, бусдын амь насыг хохироосон хэргүүдийн талаар ихэвчлэн хүсэлт гаргасан байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс сүүлийн гурван жилд Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх мөрдөгчийн даалгаврыг нийт 21 удаа бичиж 14 улсад хүргүүлсэн. Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээтэй 3 улсад 7 мөрдөгчийн хүсэлтийг, Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнууд болох 9 улсад 17 хүсэлтийг хүргүүлжээ.

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд учирч буй хүндрэл, бэрхшээлүүдийг дурдвал:

1. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаанд “эрх бүхий төв байгууллага”-аар дамжуулан туслалцаа хүсдэг байна. НҮБ-аас дэлхийн улсуудад гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд “эрх бүхий төв байгууллага” нь хэд хэд бус улсын хэмжээнд нэг байвал зохистой гэж үздэг боловч Монгол Улсад Хууль зүй

дотоод хэргийн яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар зэрэг хэд хэдэн байгууллага байдаг нь тодорхойгүй байдал үүсгэж, улмаар хүсэлтийн биелэлтийг гадаад орноос шаардах ажил эзэнгүйдэхэд хүрдэг нь мөрдөн шалгах ажиллагааг удаашруулж, хүндрэл учруулдаг.

2. Зарим улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй байгаа нь авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэхэд сөрөг үр дагавартай байна. Манай улсын албан тушаалтнууд гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгөө ихэвчлэн гадаад улс орнуудад, тэр дундаа Монгол Улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй, хүний эрх, өмч хөрөнгийн мэдээллийг сайтар нууцалдаг Англи-Саксоны эрх зүйн систем бүхий улс орнуудыг сонгон байршуулж байна.
3. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авагч улсын стандартын шаардлагад нийцүүлэн явуулахгүй бол мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар гаргасан хүсэлтийг өөрийн орны стандартын дагуу ирүүлэхийг шаардаж буцаах, загварыг өөрчлөн илгээх шаардлага практикт тулгардаг.
4. Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч улсын хувьд гэмт хэрэгт тооцогддоггүй байдал.
5. Ямар нэгэн байдлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ хийсэн болон гэрээ хийгээгүй орнууд хариу өгдөггүй.
6. Дээр дурдсанчлан дипломат шугамаар даалгавар болон хүсэлт тавьж болох боловч Монгол Улсыг гадаад улсад төлөөлөн суух элчин сайдууд нь ихэвчлэн улс төрийн

томилгоогоор томилогдсон улс төрийн албан тушаалтнууд байдаг нь эрсдэл дагуулдаг.

7. Мөн дипломат шугамаар гэрээ хэлэлцээрийн бус аргаар даалгавар хүсэлтийг тавьж болох бөгөөд Консулын харилцааны тухай Венийн конвенцийн 5 дугаар зүйлийн 148-д зааснаар энэ үүргийг тухайн оролцогч улсад Монгол Улсыг төлөөлөн сууж байгаа консул хариуцан ажиллах үүрэг хүлээнэ. Тус конвенцийн дагуу олж авсан баримт материал нь шүүхийн шатанд нотлох баримтын хэмжээнд үнэлж ашиглаж болохгүй байхаар зохицуулсан нь практикт хэрэглэхэд учир дутагдалтай байна.
8. Монгол Улсын хувьд авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хөрөнгө царцаах, буцаах, эх орондоо авах, гадаад улс орны нутаг дэвсгэрт байршсан Монгол Улсаас эх сурвалж бүхий хөрөнгийг олж тогтоох ажил туйлын хангалтгүй байна. Энэ нь Монгол Улсын ЭХХШТХ-д заасны дагуу тухайн хүний гэм буруутайг шүүх тогтоосны дараа хөрөнгө хураах боломж бүрддэгтэй холбоотой.

Иймд дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна. Үүнд:

Орчин үед даяаршлын нөлөөгөөр үндэстэн дамнасан шинэ төрлийн гэмт хэргүүд олширч, эдгээр гэмт хэргүүдтэй тэмцэхэд дэлхий нийт хамтран ажиллах чухал шаардлагатай байх тул, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний үүрэг, ач холбогдлыг үр дүнтэй байлгах үүднээс Монгол Улсын хэмжээнд Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нэгдсэн төв байгууллагыг байгуулах шаардлагатай

байна. Ингэснээр гадаад улсад илгээгдэж байгаа, гадаад улсаас ирж байгаа хүсэлт, даалгаврын гүйцэтгэл, биелэлт нь хяналттай, үр дүнтэй болно.

Төрийн албан тушаалтнуудаас эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй улс орнууд болон оффшор бүс бүхий нутаг дэвсгэрт их хэмжээний мөнгө байршуулах болон үл хөдлөх хөрөнгө ба хувьцаа худалдан авах, мөн компани үүсгэн байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулахыг хориглосон заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгаж тэдэнд хариуцлага тооцох зайлшгүй эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Монгол Улсыг гадаад улсад төлөөлөн томилогдон ажиллаж байгаа консулын ажилтан, албан тушаалтнууд нь ихэнхдээ улс төрийн томилгоогоор томилогдсон, мэргэжлийн үр чадвар, мэдлэг дутмаг албан тушаалтнууд байгаа нь Эрүүгийн хэргийн талаарх хүсэлтийн гүйцэтгэл, үр дүн болон хүний эрхийг баталгаатай хангахад сөргөөр нөлөөлж байгаа тул тэдгээр албан тушаалтнуудыг улс төрийн зорилгоор бус мэргэжлийн өндөр үр чадвар бүхий хариуцлагатай албан тушаалтнаар консулын албыг хашиж гүйцэтгүүлэх нэн шаардлагатай байна.

Ном зүй:

- НҮБ-ын Авлигын эсрэг конвенц <https://www.iaac.mn/old/pdf/nub/UNCAC.pdf>
- Хууль зүй, дотоод хэргийн яамны вэбсайт <https://mojha.gov.mn/newmojha/?p=417>
- Б.Энхбаяр “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай олон улсын гэрээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” илтгэл. 2018 он. УБ хот.
- Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн сүүлийн 3 жилийн тайлан.
- Б.Батнасан нар “Монгол Улсаас олон улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” илтгэл. 2019 он. УБ хот.
- Б.Батзориг нар “Авлига, албан тушаалын гэмт хэрэг – Хуульчдад зориулсан гарын авлага” 2014 он. УБ хот.
- Азийн хөгжлийн банк “Эдийн засгийн гэмт хэрэг – II” 2018 он. УБ хот.



МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Д.Цогтоо

Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлын ойлголтын зөрүү, уг зөрүүг арилгах хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.10 дахь хэсэгт “Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг ойлгоно” хэмээн тусгагдаж батлагдсан¹.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх үед нэг хэсэг хуульч, эрх зүйч “Мөрдөн шалгах нууц ажиллагаа”-г бүхэлдээ гүйцэтгэх ажил гэж ойлгож байсан. Тодорхой хугацааны дараа энэ төөрөгдлөөс гарч хоёр өөр ойлголт болохыг ойлгосон ч өнөөдрийг хүртэл зарим субъектүүд үүнийг бүрэн ялгаж ойлгохгүй байгаа нь ажиглагдаж байна.

Гүйцэтгэх ажил нь мөрдөн шалгах нууц ажиллагаанаас цар хүрээний хувьд илүү өргөн ойлголт бөгөөд энэ хоёр нь тус бүрдээ өөр өөр хуулиар зохицуулагддаг. Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлын талаар хуулийн хүрээнд нууцад хамаарахаас бусад ил эх сурвалжийн хүрээнд судалж, судалгаа шинжилгээ хийх боломжтой бөгөөд юуны түрүүнд нууцад

хамаарах асуудлыг хөндөж, ил болгож бичих боломжгүй болохыг дурдах нь зүйтэй.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ” хэмээн тусгасан бөгөөд гүйцэтгэх ажлын тухай хууль өнөөдөр ч гэсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа, уг хуулийг хүчингүй болгосон ямар нэгэн шийдвэр байхгүй. Эрх бүхий байгууллагаас хуулийн хүрээнд гүйцэтгэх ажлыг явуулах зохицуулалт нь хүчин төгөлдөр байгаа нь Гүйцэтгэх ажлын тухай хуулиас илэрхий харагдана.

Харин ойлголтын зөрүүг тодорхой болгох хэрэгтэй. Эрх бүхий байгууллага гүйцэтгэх ажил явуулж болох ч гүйцэтгэх ажлын үр дүнд бий болсон бүх баримт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримтын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, бүх гүйцэтгэх ажлын үр дүнг ил болгох хэрэгцээ шаардлага ч байхгүй. Учир нь гүйцэтгэх ажил нь мөрдөн шалгах нууц

¹ Монгол Улсын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас...

ажиллагаанаас илүү өргөн цар хүрээтэй ойлголт юм. Харин өнөөдрийн бидний чихэнд танил болсон мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.8 дугаар зүйлд зааснаар “Нууц ажиллагааны магадлагаа” болж нотлох баримтын шаардлагыг хангах болсон.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн гүйцэтгэх ажлын талаарх заалт болон 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Мөрдөн шалгах нууц ажиллагаа”-ны талаарх ойлголт, тэдгээрийн давуу болон сул тал

Мөрдөн шалгах нууц ажиллагаа нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар бүлэгт тусгагдсан “Мөрдөн шалгах бусад ажиллагаа” гэсэн томъёололд багтаж, уг хуулийн 26.7 дугаар зүйлд “Мөрдөн шалгах нууц ажиллагааны журам”-аар зохицуулагдах болсон. Харин 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан “Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт ээлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эрх сурвалжийг нууцална²” гэх ойлголтоос нэлээд дэлгэрэнгүй тусгагдаж мөрдөн шалгах нууц ажиллагаа гэсэн нэртэй боловч олон нийтэд ил байна. Гэхдээ хуучин тогтсон ойлголтоос салж, шинэ ойлголтыг хүлээн авч хэрэгжүүлэх хэрэгтэй боловч хуучин бүхэн бас муу гэсэн үг биш гэдгийг дахин нэг эргэж харах нь зүйтэй.

Цаг хугацааны хувьд хуулийн

шинэчлэлтийн хүрээнд хүний халдашгүй эрхийн үүднээс энэ ойлголтод бага зэрэг нэмж, дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага байсныг үгүйсгэх аргагүй. Гэхдээ хүний эрхийн дээд баталгаа нь хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны бодит үр дүн байна. Хууль сахиулах байгууллагын тодорхой үйл ажиллагааны хүрэх үр дүн буюу нуугдмал гэмт хэргийн илрүүлэлт, нотлох ажиллагаа зэрэг нь “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэх шууд томъёоллыг ил байдлаар хуульчилснаас шалтгаалан сөрөг үр дүнд хүрэх эрсдэлтэй. Үүний үр дүнд хүний эрхийн баталгаа хангагдахгүй, харин хүний эрхийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх нөхцөл, үндэслэл бүрдэхгүй, нэгэнт бүрэн дүүрэн нотлогдоогүй хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болж гэмт хэрэг үйлдэгсдэд давуу байдал бий болохуйц нөхцөл бүрдсэн байна. Энэ нь албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдалд нэгэн адил хамаарна. Учир нь цагаан захтнууд ихэвчлэн хуулийн аливаа боломжтой нөхцөл байдлыг бусдаас түрүүнд судалж мэдсэн байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй” гэх заалт бий. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно” гэх заалт өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Мөрдөгч нь хуульд заасан бүх ил арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч гэмт хэрэг бүрэн дүүрэн нотлогдохгүй байх

² Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулиас

тохиолдол нэлээд бий. Энэ тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулж эхэлнэ. Гэвч гэмт хэрэг үйлдэгсэд уг ажиллагааны талаар уг хуулиас судалж урьдаас сайтар мэдэх боломж нь нээлттэй болчихсон байна. Ер нь бүдүүлгээр, ойлгогдохоор тайлбарлавал боксчин өрсөлдөгчөө цохихдоо “Одоо чиний цээжний баруун хэсэгт цохилоо шүү” гэж урьдчилан хэлээд цохихтой нэгэн адил гэсэн үг. Мэдээж түүнийг сонссон өрсөлдөгч уг довтолгооноос зайлсхийх бүрэн боломжтой. Тэгэхээр “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж хуульд ил оруулсан нь мөрдөгчийн нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлж, нотлох аргыг илчилж гар мухардуулсан ажиллагаа юм.

Нууц далд аргаар үйлдэгдээгүй гэмт хэргийг ердийн мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэх боломжтой. Харин нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг ихэвчлэн нууц далд аргаар л илрүүлэх боломжтой. Өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэгтэй илчлэгдсэн аргаар тэмцэхээс өөр аргагүй байдалд хүргэж байна.

Үүнийг нэг мөр болгож хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй, аль болох нууц гэсэн үгийн утганд нийцэж байх боломжийг бүрдүүлэх ёстой. Ингэснээр хүний эрхийг зөрчих нөхцөл байдал бүрдэж байна гэхээсээ илүүтэйгээр хүний эрхийг зөрчигч этгээдийн эрхэнд хуулийн дагуу халдаж бусдын зөрчигдсэн, хууль ёсны эрхийг сэргээн эдлүүлж байна гэж ойлгох нь илүү эрүүл ойлголт юм. Энэ нь ч шударга ёсонд нийцнэ. Гүйцэтгэх ажлын тухай хуульд ямар нэгэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлгүйгээр

хэн дуртай нь хүний эрх, хувийн нууцад халдаад байх зохицуулалт байхгүй. Үүнийг харин гүйцэтгэх ажлын талаар тодорхой ойлголтгүй хүмүүс л хэт дэвэргэн ярьж байгаа өнөөдрийн нөхцөл байдалд хүргэсэн. Үүний цаана ямар ч далд зорилго байж болох юм.

Нууц мөрдөн шалгах ажиллагаа гэж ил бичих боломжгүй, харин нууц гэсэн үгийн утганд нийцүүлж хөгжүүлж болох юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсгийг бага зэрэг хөгжүүлэн өөрчилж болох байсан. Түүнээс биш зарчмын хувьд нууц гэсэн нэртэй ил ажиллагаа байх ямар ч боломжгүй. Шинээр хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас илүү ололттой тал нь мөрдөн шалгах нууц ажиллагааны журам, нууц ажиллагааны магадлагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналт зэрэг ойлголтууд юм. Гэхдээ үүнд нууц гэдэг үг илүүц юм. Магадгүй мөрдөн шалгах бусад ажиллагааны магадлагаа ч гэж нэрлэж болохоор байсан.

Нууц ба ил

“Нууц” гэх үг нь олонд задруулахгүй, үзүүлэхгүй, далдалбол зохих юм³ гэсэн утгатай үг юм. “Ил” гэх үг нь далд биш, далдлагдсан биш, нууц биш, илэрхий, тодорхой, нээлттэй⁴ гэсэн утгатай үг юм.

Нэгэнт “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж хуульд ил тусгасан нь “нууц” гэх үг зүйн утгын хувьд нийцтэй зүйл байна гэдэг нь дээрх тайлбар толиос илэрхий харагдаж байна. Нууц гэж бичсэн ил зүйлийг хэн ч гэсэн уншина, ойлгоно, далдлагдсан биш, илэрхий байна. Үүний үр дүнд мэдээлэлд ойрхон субъектүүдийн үйлдсэн гэмт хэргийг нотлох ажиллагаанд сөргөөр нөлөөлж цаг хугацааны

3 toli.query.mn, Монгол хэлний тайлбар толиос., Я.Цэвэл.,

4 toli.query.mn, Монгол хэлний тайлбар толиос., Я.Цэвэл.,

хувьд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа сулран доройтох үндэс суурь ч болж болзошгүй. Эцэстээ хууль сахиулах байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлж чадахгүйд хүрнэ. Үүнийг дагаад гэмт хэрэгтний сэтгэлгээ нийгэмд газар авч болзошгүй.

Харин тэр цаг хугацаанд үүнийг залруулах гэж оролдох боловч аль хэдийн бүх зүйл оройтсон байна. Бичиг үсэг мэдэх хэн ч гэсэн “Мөрдөгч нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг тогтоох зорилгоор прокурорын зөвшөөрлөөр ...үзлэгийг нууцаар хийх, ...нууц туршилт хийх, нууцаар таньж олуулах ажиллагаа хийх, ...нууцаар харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, ...орон байранд нэвтэрч хяналт тогтоох, орон байрнаас бусад газарт нэвтэрч, хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд нэвтэрч, хяналт тогтоох, ...тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газар, объектод нууц ажиглалт явуулах хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих, ... бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан эсхүл худалдан авахаар хэлцэл хийх” зэрэг ажиллагааг нууцаар хийж болно гэдгийг аль хэдийн мэдсэн байх болно. Эдгээр ажиллагаанаас мөрдөгчид үр дүн хүлээх хэрэггүй болох цаг хугацаатай бид нүүр тулж, биеэр туулж болох юм.

Хэрэв хуулийн энэ хэсэг нь уг хуульд ил тусгагдаагүй бол мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжиглэгдэн шалгагдаж буй субъект мөрдөн шалгах нууц ажиллагааны талаар ойлголт авах боломжгүй, үүний үр дүнд мөрдөн

шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг бүрэн дүүрэн нотлох боломж их байна. Энэ нь ил байсаар байвал аливаа гэмт үйлдэл, гэмт хэрэг бүрэн дүүрэн нотлогдох боломж багасна. Гэмт хэрэг бүрэн дүүрэн нотлогдоогүй тохиолдолд хэргийг эцэслэн шийдвэрлэж чадахгүй, шийдвэрлэлээ гэхэд сэжигтэн, яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэнэ. Харин хохирогч болон эрх нь зөрчигдсөн хүн дахин хохироод л үлдэнэ. Үр дүнд хуулийн дархлаа үгүй нийгэм бий болно.

Хүний эрхийг хангах баталгааны тухай

Хувийн нууцтай байх нь бидний хамгийн чухал эрхүүдийн нэг, угаас заяасан үнэт зүйлсийн нэг төдийгүй үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шилжин суурьших, эвлэлдэн нэгдэх, сэтгэлгээний эрх чөлөө болон шашин шүтэх гэх мэт бусад үндсэн язгуур эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэс суурь нь болдог. Хувийн нууцтай байх эрх нь олон улсын конвенциудаар хүлээн зөвшөөрөгдсөн, олон тооны улс орнуудын Үндсэн хууль болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Олон улсын хуулийн дагуу хувийн нууцтай байх эрх нь “түүний хувийн нууцлал, гэр бүл, орон гэр, захидал харилцаанд хууль бусаар буюу дур мэдэн халдах”-гүй байх эрх гэж томъёологддог⁵.

Энэхүү эрхийг баталгаатай хангахын тулд уг эрхийг зөрчигсөдтэй хийх тэмцэл, арга, зохицуулалтын хүрэх үр дүн тодорхой байх ёстой. Уг эрхийг зөрчигсөдөд хүлээлгэх хариуцлага гарцаагүй байх ёстой. Хариуцлага хүлээлгэхийн тулд бүрэн дүүрэн нотлогдсон байх ёстой. Бүрэн дүүрэн нотлохын тулд гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Энэ цаг үед

5 Access байгууллагаас эрхлэн гаргасан “Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд хүний эрхийн олон улсын зарчмыг баримтлах талаарх бүх нийтээр хэрэгжүүлэх удирдамж”-ийн 6-7 дахь тал...

эрх нь зөрчигдсөн хүнийхээ эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх нь чухал уу, эсвэл бусдын эрх зөрчигчийн эрхийг хамгаалах нь илүү чухал уу гэдгийг бодож тунгааж шийдвэрлэх түүхэн цаг үе ирсэн. Сэжигтэн, яллагдагчид ашигтай бус харилцан тэнцвэртэй шударга ёсонд нийцүүлж хохирогчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэх зарчимтай байх ёстой. Ингэж байж хүний эрхийг утга, мөн чанарын хувьд хэрэгжүүлж байгаа явдал юм.

Гүйцэтгэх ажлыг хэн дуртай хүнийхээ нууцад халддаг ойлголт гэж буруу ойлгож ад үзэхээс илүүтэйгээр бусдын эрхийг зөрчигдсөдтэй хийх тэмцлийн нэг хэлбэр гэж ойлгох нь эрүүл ойлголт юм.

Санал

1. Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж тусгасан хэт дэлгэрэнгүй ойлголтыг товч бөгөөд далд утга бүхий бусад үгээр орлуулах, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулах зарим ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар давхар зохицуулагдаж байгаа эсэхийг судалж, зарчмын хувьд зөрчилдөж байгаа эсэхийг нягтлах, эрх зүйн зохицуулалт хийх;

2. ...үзлэгийг нууцаар хийх, ...нууц туршилт хийх, нууцаар таньж олуулах ажиллагаа хийх, ...нууцаар харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, ...орон байранд нэвтэрч хяналт тогтоох, орон байрнаас бусад газарт нэвтэрч, хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд нэвтэрч, хяналт тогтоох, ...тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газар, объектод нууц ажиглалт явуулах хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг

дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих, ... бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан эсхүл худалдан авахаар хэлцэл хийх” зэрэг ажиллагааг нууцаар хийж болно гэх ойлголтыг “нууц” гэх үгийн утганд нийцүүлэн өөрчлөх, тодруулбал үзлэгийг нууцаар хийх гэх ойлголт нь “ил” гэх үгийн утгатай нийцэхгүй нийтэд ил болж байгаа нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч тодорхой эрх бүхий байгууллагаар судлуулж, зохицуулалт хийх;

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах нууц ажиллагааны журам, нууц ажиллагааны магадлагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналт зэргийг “нууц” гэх үгийн утганд нийцүүлж зохицуулан хэвээр үлдээж, шинэчлэлтийн эерэг өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх. “Нууц” гэх үг нь Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар толинд “олонд задруулахгүй, үзүүлэхгүй, далдалбол зохих юм” гэсэн утгатай байх тул утга, агуулгын хувьд нийцэх өөр үгийг орлуулан хэрэглэх. “Нууц” гэх үгийг нийтэд ил байгаа хуулийн нэр томъёонд оруулан хэрэглэхгүй байхаар зохицуулах нь зүйтэй.

Ашигласан материалын жагсаалт

1. Гүйцэтгэх ажлын тухай хууль
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
3. Монгол хэлний тайлбар толь, Я.Цэвэл
4. Харилцаа холбоог мөрдөн тагнах ажиллагаанд хүний эрхийн олон улсын зарчмыг баримтлах талаарх бүх нийтээр хэрэгжүүлэх удирдамж
5. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль-2002 он,
6. www.query.mn



ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ АСУУДАЛ

АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч Б.Балгандорж

Монгол Улсад жил ирэх тусам гэмт хэргийн тоо хурдацтай өсөж байгаа энэ цаг үед дэлхийн улс оронд ашиглаж буй дэвшилтэт, шинэлэг технологи, арга хэрэгслийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, хэрэглэх, хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх шаардлага гарч ирж байгаа билээ. Өнөө цагт шүүх эмнэлгийн хэрэгсэл, арга техник нь гэмт хэрэгтэй тэмцэх, нотлоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Үүний нэг адил мөрдөгч өөрөө бие даан ашиглаж, шинжлэн судалж болохуйц бөгөөд дэлхийн цөөнгүй улс оронд ашиглаж буй хэрэгсэл нь химийн урхи (“химические ловушки”) будаг юм. Химийн урхи будгийг алдагдсан эд хөрөнгийг олж илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох зэрэг арга хэмжээний нэг хэрэгсэл болгон ашиглах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд тусалдаг.

Химийн урхи хэрэгслийг олон улсын гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд ашиглах шаардлагатай байгаа ч практикт өргөн тархаагүй байна. Химийн бүтээгдэхүүний эргэлтийг зохицуулах хууль, эрх зүйн орчин хангалтгүй, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж болох талаар хуульчлаагүй байгаа тул хууль хүчний байгууллагууд ашиглахгүй байна. Химийн урхи будаг гэж юу вэ? Тэдгээрийн

үйлдвэрлэлийг тус улсад хуульчилсан уу? Химийн урхи будгийг хаана ямар үед хэрхэн ашиглах вэ? Ийм хэрэгслийг ашиглах нь хүний эрхийг зөрчиж байна уу? гэх зэрэг асуултууд гарч ирж байна. Энэ удаагийн илтгэлийн гол сэдэв бол химийн будгийг хэрхэн мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах, гэмт хэргийг халуун мөрөөр нь хэрхэн илрүүлэх талаар тусгахад оршино.

Химийн урхи будаг гэдэг нь янз бүрийн объектийн гадаргуу дээр өнгөлөн далдлагдсан, тусгай химийн бодисоор (будах, гэрэлтүүлэх, эсвэл үнэрээр) бүрхэгдсэн энгийн нүдээр үл харагдах будгийг хэлнэ.

Химийн урхи будгийг хоёр бүлэгт хуваадаг бөгөөд

- 1) тэмдэглэгээ хийх;
- 2) материаллаг үнэт зүйл бүхий объектууд дээр түрхэх зориулалттай гэж хоёр ангилна.

Дэлхийн цөөнгүй хэдэн улс оронд дараах төрлийн химийн урхи будгийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж байна. Үүнд:

“Rhododendron” буюу үзгэн тодотгогч будаг нь мөнгөн тэмдэгт дээр тэмдэглэх зориулалттай. Гэмт хэргийн замаар олсон мөнгийг тэмдэглэх, бусад

мөнгөнөөс ялгахад энэ тодотгогчийг ашиглаж байна. Энэ будаг нь мөнгөн дээр ямар нэгэн тэмдэглэгээ хийхэд энгийн нүдээр үл харагдах бөгөөд тусгай зориулалтын гэрлийн тусгалтайгаар харагдах боломжтой. (Зураг №1)



Зураг №1

“Firefly” буюу түрхлэг химийн будаг нь мөнгөн дэвсгэрт, бичиг баримт болон бусад объектуудад тодорхой хэмжээнд түрхсэнээр тухайн объект дээр хүрэлцсэн зүйлд наалдаж 2-3 хоногийн хугацаанд арилахгүй үлддэг. (Зураг №2)



Зураг №2

“Fudge” буюу гарын мөр хадгалах будгийг янз бүрийн гадаргуутай эд зүйл дээр нимгэн түрхэж гэмт этгээдийн хурууны хээ уг гадаргуу дээр хүрэлцэхэд хурууны хээ нь үлдсэнээр тодорхой хугацаанд

гэмт этгээдийн хурууны хээг арилгахгүй хадгалах чадвартай химийн будаг юм. Уг будаг нь хүний нүдэнд үл харагдах бөгөөд хэт ягаан туяаны нөлөөн дор харагддаг. (Зураг №3)




Зураг №3

Практик дээр ихэвчлэн химийн урхи буюу тэмдэглэгээний бодис гэж нэрлэгддэг тусгай химийн нэгдлүүдийг ОХУ, Казакстан, Беларусь зэрэг улсад гэмт хэргийг илрүүлэх зорилгоор ашиглаж байгаа юм. Зарим эрдэмтэд, судлаачид уг химийн урхи будаг хэрэгслийг “Шүүхийн маркер” гэсэн нэр томъёогоор нэрлэх санал гаргасан байдаг юм.

Сүүлийн үед Монгол Улсад хахууль авах, өгөх гэмт хэрэг хурдацтай өсөж байгаа энэ цаг үед илрүүлэх арга техник дутмаг, ирүүлсэн хэдий ч нотлох асуудал дээр цөөнгүй хүндрэл бэрхшээл учирч байгаа билээ.

Хахууль авагч этгээд нь бусдаас хахууль авахыг байнга шаардаж хахууль авахдаа ихэвчлэн бэлнээр, биет хэлбэрээр мөнгө авч байдаг. Иймээс хахуульд өгч байгаа мөнгийг нь химийн урхи буюу энгийн нүдээр үл харагдах будгаар будаж, уг будсан мөнгийг барьсан этгээдийн гарын гадаргуу дээр тухайн будаг нь тогтсноор тусгай гэрлийн тусламжтайгаар мөнгө болон гар дээр байх будгийг харах, илрүүлэх боломж бүрдэж байдаг юм. Ингэж хахууль авсан этгээдэд химийн будгаар будсан будагтай

мөнгө өгснөөр хахууль авагч этгээд гараараа барих, хувцас хэрэгслийнхээ халаасанд хийх, бусад эд зүйл хогшилдоо хийж нуун далдлахад химийн будаг нь тухайн эд зүйлийн гадаргуу дээр үлдэж тусгай гэрлийн тусламжтай харагддаг буюу уг мөнгийг хахууль авсан этгээд хүлээн авсан гэдгийг тогтоох боломжтой юм. ОХУ-д энэ химийн будгийг ихэвчлэн шүгэл үлээгч нар эрх бүхий байгууллагын тусламжтай ашиглаж хахууль авагч этгээдийг хөдөлшгүйгээр нотолж өгч байна.



Энэхүү илтгэлийн хүрээнд зөвхөн зарим төрлийн химийн урхи будгийг авч үзсэн боловч химийн будгийн төрөл, ангилал олон төрөл байдаг ба нарийвчлан судалж мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах боломжтой. Химийн будгийн өртөг бага тул маш олон

төрөл байдаг. Энэ төрлийн химийн будаг нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтооход зарим улс оронд багагүй хувь нэмэр оруулж байна.

Монгол Улсад химийн урхи будгийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт байхгүй хэдий ч цаашид химийн урхи будгийг ашиглах хууль, тогтоомжийг зайлшгүй бий болгох шаардлагатай.

Ном зүйн жагсаалт

<http://www.spuhit.ru/pages/category25.html>

<http://www.cobra.net.ua/catalog/ximicheskie-lovushki.html>

<https://pipl.ua/ru/khimicheskaya-lovushka-so-slezotochivym-veshhestvom-uro>

http://savehome.ru/category_197.html



АВЛИГЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн
ахлах ажилтан Н.Дамдинсүрэн*

Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох, эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нүүж, шилжүүлсэн бусад этгээдийг шийтгэхийг “мөнгө угаах” гэж томъёолж, олон улсад ашигладаг. Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой.

Авлигын эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэрэг

Хүмүүс хайр дурлал, үзэн ядалт, өш хонзон, согтуурхал, мансуурал, шунал тачаал, бизнес, улс төр гээд маш олон шалтгаанаар нийгмийн хар тал болох гэмт хэрэг гээч зүйлийг үйлдсээр ирсэн. Гэвч дийлэнх гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нь мөнгө л байдаг.

Гэмт этгээдүүд гэмт хэргийн замаар олсон бохир мөнгөө хэрхэн нуух, түүнийгээ

зоволтгүйгээр үрэх, гэмт үйлдлийнхээ улмаас хэрхэн торны цаана суухгүй байх талаар минут, цаг, өдөр, жил, бүр хэдэн жилээр тооцоолсоор ирсэн гэхэд хэн ч маргахгүй байх. Өөрөөр хэлбэл, хууль бусаар олсон бохир мөнгийг цэвэр мөнгө буюу хууль ёсны орлого мэт болгон харагдуулж түүнийг зарцуулах шаардлага гарна.

Мөнгө угаах гэх нэршил анх 1930-аад оны үед АНУ-ын Төрийн сангийн ажилтнууд Аль Капонег эдийн засгийн гэмт хэрэгт сэжиглэн нотлох баримт цуглуулсан үеэс эхлэлтэй гэж үздэг. Тухайн үед маш цөөхөн хүн төвлөрсөн усан хангамжийн ус хэрэглэдэг байсан тул айлуудад угаалгын машин бараг байдаггүй байсан бөгөөд Чикаго хот дотор хэдэн зуун угаалгын газар ажилладаг байсан байна. 1920-1933 онд АНУ-д архины төрлийн бүтээгдэхүүнийг худалдах, савлах, гаднаас оруулж ирэх, тээвэрлэхийг хориглодог байсан ба Аль Капоне хууль бус согтууруулах ундааны бизнесийг хийж түүнээсээ олсон орлогоо өөрийн эзэмшдэг олон тооны угаалгын газруудын ашиг хэмээн халхавчилдаг байжээ. Тухайн үед мөнгө угаах гэмт хэргийн ойлголт муу, Америкийн хууль тогтоомжид тухайн төрлийн гэмт хэрэгт

оногдуулах ял шийтгэлийг тусгасан заалт байгаагүйгээс түүнийг татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн шийтгэж байсан байна.¹ Үүнээс “суурь гэмт хэрэг” буюу “нуугдмал гэмт хэрэг”-ийн талаарх ойлголт гарч ирнэ.

Тухайн улс орны нийгэм, эдийн засгийн онцлог, хүн амын бүтэц, боловсрол, эрх зүйн ухамсрын түвшингээс хамаарч, суурь гэмт хэрэг нь мөнгө угаах гэмт хэрэгтэй өөр өөр байдлаар холбогддог байна. Тухайлбал, АНУ-д хар тамхины наймаа, мөнгө угаах гэмт хэрэгтэй зайлшгүй холбогдож байдаг бол Энэтхэг улсад татвараас зайлсхийх гэмт хэрэг нь мөнгө угаах гэмт хэрэгтэй хамтдаа үйлдэгддэг байна. Харин Монгол Улсын тухайд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй мөнгө угаах гэмт хэрэг шууд холбогдож байна.

Мөнгө угаах олон хэлбэр байдаг бөгөөд түүний нэг хэлбэр нь авлигатай шууд холбоотой буюу албан тушаалтнуудад хахууль өгөх, үүнд улс төрийн нөлөөтэй хүмүүсийн боломжит нөлөөлөл, оффшор банкууд /бизнесүүд, тухайлбал, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч компанийг ашиглан хөрөнгийг хянаж буй этгээдийг таньж мэдэхээс сэргийлэх, дотоодын эрх бүхий байгууллагын хориг хязгаарлалтаас зайлсхийхийн тулд мөнгийг шилжүүлэх явдал юм.

Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас 2017 онд хийсэн “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний тайлан”-д Монгол Улсын өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига багтаж байгаа бол дундаж эрсдэлтэй гэмт хэрэгт хар тамхи, контрабанд

буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай, гадаадад үйлдсэн гэмт хэргийн хөрөнгө мөнгөтэй холбоотой хэрэг багтаж байна” гэжээ.

Авлигатай тэмцэх газрын хувьд 2008 оноос хойш жил тутам “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулж ирсэн. Уг судалгаа нь авлигын хандлага, авлигад өртөмтгий ажил, албан тушаал, авлигад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд чиглэж байна.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа, Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг 2018 оноос тусад нь явуулж эхэлсэн бөгөөд улс төрийн хүрээн дэх авлигын түвшин 2019 онд 3.93 пункт гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.15 пунктээр өссөн, харин шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин 2019 онд 3.86 пункт гарсан нь өмнөх онтой харьцуулахад 0.18 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.²

Улс төрийн хүрээн дэх авлигын хувьд улс төрийн намын санхүүжилтийг өөрөөр зохицуулах, сонгуулийн тогтолцоог өөрчлөх, сонгуулийн ажиллагааг аль болох ил тод болгох, томилгооны асуудлыг зохицуулах, улс төрийн албан тушаалтан төрийн жинхэнэ албан хаагчийг томилох боломжийг хаах, улс төрийн болон төрийн албаны хариуцлагын үр дүнтэй тогтолцоотой болохын зэрэгцээ

¹ Крис Матерс., Гэмт хэргийг танихуй: Мөнгө угаах., 13 дугаар тал

² Авлигатай тэмцэх газраас хийсэн судалгааны дүнгээс.

авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг дэлгэрүүлэх шаардлагатайгаас гадна Шүүх, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны хувьд юуны түрүүнд улс төрийн нөлөөнөөс ангижруулах, албан тушаалын томилгоог гагцхүү мэргэжлийн шалгуураар хийдэг болгох, үйл ажиллагааг ил тод болгох шаардлагатай гэсэн дүн гарчээ.

Дээр дурдсан дүгнэлтээс үзэхэд өнөөдөр Монгол Улсад авлигын эрсдэл ямар түвшинд байгааг харж болохоор байна.

Мөн олон улсын “Транспэрэнси интернэшнл” байгууллагаас 24 дэх удаагийн Авлигын төсөөллийн индексийн 2019 оны үр дүнг зарласан. Энэ оны судалгаанд нийтдээ 180 улс орныг хамруулсан бөгөөд Монгол Улс 2018 онд 93 дугаар байр буюу 37 оноотой үнэлэгдсэн нь 2019 онд даруй 2 оноогоор буурч 106 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. 2012 онд 36 оноо (94 дүгээр байр), 2013 онд 38 оноо (83 дугаар байр), 2014 онд 39 оноо (80 дугаар байр), 2015 онд 39 оноо (72 дугаар байр), 2016 онд 38 оноо (87 дугаар байр), 2017 онд 36 оноо (103 дугаар байр)-ыг тус тус эзэлж байсныг дурдах нь зүйтэй байх.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа”-ны эрх зүйн үндэслэл, зохицуулалтыг тодорхойлсон бөгөөд хуулийн 42.1.1-д “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, түршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ” гэж хуульчилсан.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс 19 улстай 28 төрлийн иргэний болон эрүүгийн хэргийн асуудалд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар гэрээ байгуулснаас 1960-2000 онд 18 гэрээ, 2000-2016 онд есөн гэрээг байгуулсан байна.

Авлигатай тэмцэх газрын хувьд үүсэн байгуулагдсан цагаас хойш олон улсын хамтын ажиллагааг чухалчилж ирсэн бөгөөд үүний үр дүнд бид өнөөдрийн байдлаар гадаадын дөрвөн улсын авлигатай тэмцэх байгууллагатай хамтын ажиллагаатай, олон улсын таван байгууллагатай “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, олон улсын 24 байгууллагатай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж ирлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйл /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар/-ийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана”, мөн хуулийн 42 дугаар бүлэгт “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, түршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ” гэж хуульчилсан. Үүнээс үзэхэд бид олон улсын бусад гэрээ хэлэлцээрийг үндэслэн мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх зүйн боломж

нээлтэй байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чиглэсэн хэм хэмжээг тогтоосон Авлигын эсрэг конвенцийг баталсан ба найман бүлэг, 71 зүйлтэй олон улсын эрх зүйн томоохон баримт бичиг баталсан. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 183 орон нэгдэж 140 орон гарын үсэг зурж баталгаажуулсан. Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 7-ны өдөр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталж нэгдэн орсон юм.

Авлигатай тэмцэх газраас /2019 оны 1 дүгээр улирлын байдлаар/ сүүлийн гурван жилийн байдлаар Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй гурван улсад долоон мөрдөгчийн хүсэлтийг, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнуудад болох есөн улсад 17, нийт 24 хүсэлтийг хүргүүлсэн боловч үр дүн хангалттай гэж хэлэхээргүй байна. Энэ нь нэг талаар олон улсын гэрээ, конвенцийг дотоодын хууль тогтоомжийн хэмжээнд үйл ажиллагаанд хэрэглэх, мөрдөх ажиллагаа хангалтгүй, нөгөө талаар дээрх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох шаардлагыг нөхцөлдүүлж байгаа юм.

Бидний хөрш БНХАУ-д авлигатай хийх тэмцлийн долоон зарчмыг тодорхойлсны дотор төрийн аж ахуйн нэгж болон төрийн үйл ажиллагааг хариуцдаг албан тушаалтнуудын үйл ажиллагааг хянах, авлигын гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдүүдийг эх оронд нь буцаан авчрах, улсад учруулсан хохирлыг эргүүлэн

төлүүлэх, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг багтжээ.

Тэд 2012 оноос хойш “Үнэгний ав”, “Тэнгэрийн сүлжээ” нэртэй ажиллагаануудын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон, өөрийн хил хязгаараас аль хэдийн гараад байсан төрийн өндөр албан тушаалтнууд, бизнес эрхлэгчид болон тэдний хууль бус хөрөнгийг эрэн хайх, гэмт хэрэгтнийг шилжүүлэн авах ажлыг олон улсын түвшинд явуулсны үр дүнд 2018 оны 8 дугаар сарын байдлаар 4500 гаруй авлига, албан тушаалын гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдүүдийг 120 гаруй улс, бүс нутгаас буцаан авч ирсэн. Тэдний 900 гаруй нь төрийн албан хаагч болон намын гишүүн байсан ба нийтдээ 10 тэрбум юаньтай тэнцэх хэмжээний хулгайлагдсан хөрөнгийг буцаан авсан дүн мэдээг дэлхий нийтэд мэдээлжээ.³

БНХАУ-ын эрх зүйн орчныг судалж үзвэл:

- Олон талт хамтын ажиллагааны хүрээнд: НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон улс орнууд, Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа /АПЕК/-ны орнууд, Их-20 орнуудтай хийх хамтын ажиллагааны хүрээнд,
- 2 талт хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-АНУ-ын хооронд байгуулсан Авлигын эсрэг асуудлаарх ажлын хэсэг /JLG,ACWG/, БНХАУ-АНУ-ын хооронд байгуулсан Хууль сахиулах болон Кибер аюулгүй байдлын хэлэлцээр, БНХАУ-АНУ-ын хооронд байгуулсан 5 том хэргийн хэлэлцээр,
- Гэрээ, хэлэлцээрийн хүрээнд: Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг дэлхийн 63 оронтой, Гэмт хэрэгтэн шилжүүлэх гэрээг 53 улстай, Авлигын эсрэг асуудлаар хамтран

3 National Supervisory Commission of the People's Republic of China-с гаргагдсан судалгаанаас.

ажиллах санамж бичиг, гэрээг /MOU/ 90+ улстай хийсэн байна.

Авлига нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд аюул занал учруулах, улмаар ардчиллын тогтолцоо, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулах, тогтвортой хөгжил, хуульд захирагдах ёсонд хохирол учруулахуйц гэмт үзэгдэл юм. Төрийн эрх бүхий өндөр албан тушаалтнууд албан тушаал хашиж байхдаа албан тушаалаа ашиглан хууль бусаар олсон их хэмжээний орлого, мөнгөө гадаад улсад тэр тусмаа эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулагдаагүй улс орнуудад болон оффшор бүс бүхий нутаг дэвсгэрт шилжүүлэн байршуулах, үл хөдлөх хөрөнгө болон хувьцаа худалдан авах, компани үүсгэн байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр хууль бус орлогоо нууж байна.

Бид авлига, албан тушаалын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг зохих журмын дагуу явуулж суурь гэмт хэрэг үйлдсэнийг тогтоож байгаа боловч уг гэмт хэргийг үйлдэх замаар олсон хууль бус орлогыг гадаад улс оронд байршуулсныг илрүүлэх, тогтоох, царцаах, битүүмжлэх, буцаан авчрах асуудал хууль сахиулах, прокурор, шүүхийн аль ч түвшинд мухардмал байдалд орсон гэхэд хилсдэхгүй болоод байна.

УИХ-ын чуулганы 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар 2006 онд батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2004 онд батлагдсан Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2003 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тус тус баталсан зэрэг мөнгө угаах ажиллагааны эсрэг хууль,

эрх зүйн орчныг бүрдүүлж, өөрийн орны санхүүгийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг дотоодын дэглэмийг бий болгосон, тухайн үйл ажиллагааны эсрэг судалгаа, шинжилгээ, мэдээ мэдээлэл, баримт сэлт судалж, бэлтгэдэг тусгай бие даасан алба болох Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хууль сахиулах эрх бүхий байгууллагуудад мэдээлэл хүргэн ажилласаар ирсэн ч өнөөдөр манай улсын дээд шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл буюу Мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж, хэрэг хянан шийдвэрлэсэн практик шүүхэд байхгүй байна.

Дараах саналыг дэвшүүлж байна:

1. Авлигын эсрэг конвенцийг удирдлага болгон гадаадын тодорхой улс орнуудын Засгийн газар, эсхүл тэдгээрийн хууль хяналтын байгууллагатай харилцан тохиролцож конвенцийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд нийцүүлэн гэрээг бүрдүүлэгч баримт бичгийг солилцох, хүлээн зөвшөөрөх, эдгээртэй адилтгах бусад аргаар мэдээлэл харилцан солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад харилцан дэмжлэг үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулан хамтран ажиллах;

2. Авлигын эсрэг конвенцийн 49 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон эрх зүйн харилцан туслалцааны гэрээ, хэлэлцээр байхгүй бол тухайн улс орны мөрдөн шалгах байгууллагатай хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа /гадаад улсад байгаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх, хураан авах, хөрөнгө буцаах ажиллагаа/-г тухай бүр тохиролцон явуулж байх зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах, энэ чиглэлд санал, санаачилгатай ажиллах;

3. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай зарчим, гэрээг агуулгын хувьд шинэчлэх, хамрах хүрээг өргөтгөх, Монгол Улс болон харилцагч гадаад улс орны эрх зүйн тогтолцооны шинэчлэлт, онцлогийг тусгах, нэмэлт өөрчлөлт оруулах талаар санаачилга гарган ажиллах;

4. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улс орнуудтай гэрээг шинээр байгуулах, авлига, мөнгө угаах, терроризм, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис наймаалах зэрэг гэмт хэрэгт мэдээ, мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиглэлээр хоёр болон олон талт гэрээ байгуулж нэгдэн орох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

5. Эрх зүйн туслалцаа харилцан

үзүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллага /ХЗДХЯ, УЕПГ, ГХЯ, УДШ, хууль сахиулах байгууллага/-уудын харилцан хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээ, хэлэлцээр, эх сурвалж, хүсэлттэй холбогдсон тоо баримтуудын талаарх мэдээллийн нэгдсэн баазыг бий болгож, үйл ажиллагаанд ашиглах;

6. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын аливаа конвенцийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, баримтыг нотлох баримтаар үнэлэх практикийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвшүүлэх арга замыг бий болгох;

7. Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, сурган дадлагажуулах, харилцан мэдээлэл солилцох.



ӨВСӨН ДОТРООС ЗҮҮ ЭРЭХ НЬ

АТГ-ын хэвлэлийн ажилтан Т.Мөнхтунгалаг

АТГ-ын мөрдөн шалгах ажиллагаа хэрхэн хийгддэг тухай ярихаас өмнө авлигын гэмт хэрэг ямар онцлогтой талаар хэдүүлээ эхлээд ойлгоё.

Ахуйн хүрээнд үйлдэгддэг бусад төрлийн гэмт хэргээс тэс өөр. Авлигын гэмт хэргийг эрх мэдэлтэй, хөрөнгө мөнгөтэй, тусгай мэдлэг бүхий өндөр боловсролтой этгээдүүд үйлддэг. Ийм хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлж мөрдөн шалгаж нотлох нь мөрдөгчөөс үр чадвар, цаг хугацаа, зардал шаарддагаараа бусад төрлийн гэмт хэргээс онцлог ялгаатай. Хоёр этгээдийн хооронд гэрчгүй хийгддэг үйлдэл. Авсан, өгсөн талуудын аль алиных нь хэрэг бүтэх тул сэтгэл ханамжтай үлддэг. Ил биш далд үйлдэгддэг гэмт хэрэг. Ихэвчлэн зохион байгуулалттай хийгддэг.

“Авлигын гэмт хэрэгт шалгагдаж байгаа нэг этгээдийн ар талд 2-3 өмгөөлөгч, санхүүгийн өндөр боловсролтой зөвлөхүүд гэх мэт бүхэл бүтэн баг ажилладаг. Зарим тохиолдолд авлигын гэмт хэрэгт шалгагдаж байгаа нэг этгээдийн цаана бүхэл бүтэн улс төрийн нам, нэг байгууллага ажилладаг. Мөрдөгч энэ хэмжээний хүчтэй тулж, авлигын гэмт хэргийг илрүүлж, мөрдөн шалгаж нотлоод прокурор, шүүх рүү

шилжүүлж шийдвэрлүүлдэг” гэж АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга М.Даваатогтох ярилаа.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 11 төрлийн гэмт хэргийг АТГ харьяалан шалгадаг. Тухайлбал, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэрэг болон өөрсдийн илрүүлсэн мөнгө угаах гэмт хэрэг, цагдаагийн байгууллагын албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдсэн гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

*АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс нь 11 төрлийн гэмт хэргийг харьяалан шалгадаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэргийг дотор нь хэрэг бүртгэлтийн хэрэг, мөрдөн байцаалтын хэрэг гэж хоёр ангилдаг. Хэрэг бүртгэлтийн хэрэг гэдэг нь энгийн үгээр тайлбарлавал гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаа гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл

шалгагдаж байгаа асуудал нь авлигын гэмт хэргийн шинжтэй байна гэж үзээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, хэн гэж этгээд авлигын гэмт хэргийг хэзээ, ямар аргаар үйлдсэн, уг үйлдлийн улмаас хэдэн төгрөгийн хохирол учирсан гэдгийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа ажиллагаа юм. Хэрэг бүртгэлтийн шатанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг нарийвчлан тогтоогоод түүнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах санал үйлдэж прокурорт шилжүүлнэ. Прокурор мөрдөгчийн уг саналыг хянан үзээд үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол гаргамагц хэрэг бүртгэлтийн хэрэг нь мөрдөн байцаалтын хэрэг болдог.

Мөрдөгч нар хэрхэн ажилладаг вэ?

АТГ-ын мөрдөгч гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээж аваад гурван төрлийн шийдвэр буюу санал гаргадаг. Нэгдүгээрт, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, хоёрдугаарт хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, гуравдугаарт харьяаллын дагуу шилжүүлэх. Мөрдөн шалгах хэлтэс 2019 онд гэмт хэргийн шинжтэй 894 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан байна. Энэ нь өмнөх оноос 4.2 хувиар өссөн үзүүлэлт. Хүлээн авч шалгасан гомдлын 489-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 362-т нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргаж, 34-ийг нь харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэжээ.

*Авлигын гэмт хэрэгт цугларч байгаа нотлох баримт нь дунджаар 20-300 хавтас болдог. Нэг хавтсанд 250 хуудас нотлох баримт цугларч боогддог. Үүнийг нарийвчлан авч үзвэл нэг авлигын хэрэгт 5000-75000 хуудас цугларч, тухайн хэргийг шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлдэг.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн аваад хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан санал гаргаж байгаа хэдий ч тухайн асуудалд хууль зөрчсөн зөрчлийн шинжтэй нөхцөл байдал тогтоогдсон бол АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс эрх бүхий албан тушаалтанд зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авахыг даалгасан албан бичиг хүргүүлдэг. Уг албан бичгийн биелэлтэд Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс хяналт тавьж хэвшсэн.

Мөрдөн шалгах хэлтэс 2019 онд нийт 1300 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх оныхоос 162-оор илүү байна. Нийт шалгасан хэргийн 156-г шүүхэд шилжүүлэх саналтай, 556-г хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай, 80-ыг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлжээ.

1300 хэргийг жилийн өдрүүдэд хувааж энгийн арифметик үйлдэл хийж үзвэл баярын болон амралтын өдрүүдийг оруулж тооцоод АТГ нэг өдөрт гурван хэрэг дээр ажилласан гэсэн үг. АТГ нь 30 орчим мөрдөгчтэй. Дунджаар авч үзвэл нэг мөрдөгч жилдээ 25 гомдол, мэдээлэл дээр ажиллаж, 37 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Энэ бол их ачаалал, маш том даац. АТГ-ын мөрдөгч хэд байвал зохист харилцаа үүсэх вэ гэдэг дээр Хонконгийн Авлигатай тэмцэх бие даасан комиссын бүтцээр жишээ авч болох юм. Хонконг нь 6 сая хүн амтай, авлигатай тэмцэх байгууллага нь 1500 мөрдөгчтэй. Нутаг дэвсгэрийн хувьд Хонконгийн нэг захаас нөгөө зах руу явахад ердөө 2 цагийн хугацаа зарцуулдаг. Ийм нөхцөлд 1500 мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааг хурдан шуурхай явуулах боломжтой гэж үздэг байна. Харин манай улсын хувьд баруун

хязгаараас зүүн хязгаар луу явахад хэдий хэрийн цаг хугацаа зарцуулахыг Та бодоод үзээрэй. “Үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн статистик ба мөрдөгчдийн тоог харьцуулж үзвэл энэ нь чамлалттай. Хонконг гурван сая хүн амтай байх үед 800 мөрдөгч ажиллаж байсан” гэж АТГ-ын ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар онцлон хэлсэн. Мөрдөн шалгах хэлтэс сард дунджаар 450-500 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа.

*Мөрдөн шалгах хэлтэс нь 2019 онд нийт 1300 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх оныхоос 162-оор буюу 14.2 хувиар өссөн байна.

Монгол Улсын АТГ нь бүс нутагтаа өндөр түвшинд ажилладаг хэмээн олон улсын шинжээчид дүгнэдэг ч авлигын гэмт хэргийг мөрдөн шалгадаг мөрдөгчдийн тоог нэмэгдүүлэх, хангалттай байлгах ёстой гэж бас зөвлөдөг.

АТГ-ын даргын тушаалаар 2019 онд АТГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа мөрдөгчдийн орон тоог тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж, тэр дундаа санхүүгийн мөрдөгч нарыг томилон ажиллуулж байгаа. АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга М.Даваатогтох “Авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлж нотлоход санхүүгийн тусгай мэдлэг бүхий мөрдөгчдийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай. Санхүүгийн мөрдөгчдийг томилсон нь цаг үеэ олсон, авлигын гэмт хэргийг илрүүлж нотлоход тустай арга хэмжээ болсон” хэмээн яриу.

Мөрдөн шалгах ажиллагаа хугацаа шаардахын учир

АТГ-ын шалгаж байгаа хэргүүдийн шийдвэрлэлт удаан байна гэдэг талаар

шүүмжлэл гардаг. Энэ нь хэд хэдэн бодит шалтгаантай.

*Мөрдөгч нарын ажлын ачааллыг дунджаар авч үзвэл 1 мөрдөгч 25.5 гомдол мэдээлэл, 37.1 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Тус газрын Хэвлэл, олон нийттэй харилцах ахлах ажилтан Т.Баярхүү хэлэхдээ “Манай улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагааны явцад цуглуулж байгаа нотлох баримтыг ихэвчлэн цаасан суурьтай бэхжүүлж авдаг. Авлига, албан тушаалын гэмт хэргүүд дээр ихэнх тохиолдолд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шинжээчийн дүгнэлт гардаг, компанийн үйл ажиллагаа, тайлан баланс гэх мэт маш олон төрлийн бичиг цаас, архивын баримт дээр ажилладаг, үүний дээр эдийн засгийн харилцаа өргөжсөн өнөөгийн цаг үед гадаад, дотоодын мөнгөн гуйвуулга, шилжүүлэг хийгддэг, энэ бүхнийг нотлох баримтын хэмжээнд үнэлэхийн тулд тодорхой ажиллагаа хийдэг. Гадаад олон улсын байгууллагад мөрдөгчийн даалгавар хүргүүлж хариу авдаг. Энэ утгаараа мөрдөн шалгах ажиллагааны явц удааширдаг. Үүнээс гадна нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагаанд тодорхой саад учирдаг” гэсэн юм.

*МШХ сард дунджаар 450-500 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа.

Авлигын гэмт хэрэгт цугларч байгаа нотлох баримт нь дунджаар 20-300 хавтас болдог. Нэг хавтсанд 250 хуудас нотлох баримт боогддог. Үүнийг нарийвчлан авч үзвэл нэг авлигын хэрэгт 5000-75000 хуудас цугларч, тухайн хэргийг шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлдэг. Мөрдөн шалгах ажлын үндсэн өвөрмөц онцлог

нь хэрэг шалгалтын хугацаанд нөлөөлдөг байж болох. Цаас буюу нотлох баримт цугларах хэрээр цаг хугацаа төдий хэмжээгээр шаардагдана гэсэн үг.

Гэхдээ хууль эрх зүйн хийдлээс үүдэлтэйгээр мөрдөн шалгах ажиллагааг зориуд сунжруулах явдал давамгайлж байна. Албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүмүүс мөнгөө гадаад улсад байршуулдаг тул эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгүй улс орнуудтай харилцаж улс дамнасан санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад маш их хугацаа шаарддаг. Түүнээс гадна өндөр албан тушаалтнуудын холбогдсон хэргийг шалгахад халдашгүй бүрэн эрх нь бодит саад тотгор болсоор байна.

Гадаадад хөрөнгөө аваачаад нуучихсан албан тушаалтнуудын хөрөнгийг буцаан татаж авчирч чаддаг байхын тулд улс орон бүртэй эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах ёстой. Гэтэл Монгол Улс одоогоор 20 гаруй улс оронтой эрүүгийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулсан. Зарим улс орны хувьд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалздаг. Оргон зайлсан этгээдийг тухайн улс оронд нь буцаан өгөхтэй холбоотой удаашрал үүсэж байна. Энэ нь хэргийг удаашруулдаг, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг бөгөөд хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ч сунжруулдаг.

*2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн 156 авлигын хэргийн 68 нь шүүхээр шийдвэрлэгджээ.

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зөвшөөрлийн зохистой харьцааг авч үзэх ёстой. Зарим төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад зөвшөөрөл шаарддагаас

үүдэн нотлох баримт үрэгдэх, устгагдах, мөрдөн шалгах ажиллагааны явцад хурааж авах боломжгүй болох нөхцөл байдал үүсдэг. Сүүлийн хоёр жилийн хугацаанд нэлээд ажиглагдаж байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцээд байгаа ч гэсэн хүссэн үр дүнд хүрэхгүй байгаагийн нэг шалтгаан нь энэ” хэмээн ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар ярьж байна.

Түүнээс гадна шалгагдаж байгаа этгээд АТГ-ын үйл ажиллагааг харлуулахын тулд өөрсдийгөө хэлмэгдсэн мэтээр буруу ташаа мэдээллийг зориуд тараадаг, хөөн хэлэлцэх хугацааг хүлээн цаг хождог, гэм буруугийн асуудал яригдаагүй байхад мөрдөн байцаалтад буцаасан шүүхийн шийдвэртэй заргалдаж хугацаа сунжруулах нь олонтаа. Тэр ч бүү хэл 8-9 сарын туршид яллагдагч талын хүсэлтээр хэргийг шүүхийн шатанд уясан тохиолдол ч бий. Ингэх нөхцөл боломжийг хуулиар нээгээд өгчихсөн учраас энэ нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаанд болон хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлж байгааг АТГ-ын мөрдөгчид харамсан өгүүлж байв.

*Авлигын гэмт хэргийн улмаас 2019 онд 12.1 их наяд төгрөгийн хохирол учирсан.

Авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчин дутмаг, хийдэл ихтэй

АТГ-ын ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар “Шударга ёсны зарчимд нийцэхгүй байгаа, ял шийтгэлийг ялгавартайгаар оноож байгаа энэ асуудлыг хуульд тусгаж өгөх ёстой. Албан тушаалын гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсон. Хохирол, хор уршиг шаардахгүйгээр хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт оногдуулж байгаа ял, их хэмжээний хохирол учруулсан албан тушаалтанд оногдуулж

байгаа ялын санц нь ижил байгаа. Тэгэхээр энэ хийдлүүдийг засах зайлшгүй шаардлагатай” гэж ярилаа.

Тэрээр БНСУ-ын хоёр Ерөнхийлөгч асанд тус улсын шүүхээс нь 15 ба 24 жилийн хорих ял оноосон талаар яриандаа дурдав. Улс орнуудын эрүүгийн эрх зүйг судалж үзэхэд авлигатай хийж байгаа тэмцэл нь өвөрмөц. Өөрөөр хэлбэл, оногдуулах ялын бодлогын хувьд нийгмийн хор аюул нь ойролцоо тохиолдолд шийтгэл нь хатуу байдаг. Бусад улс орнуудад 8-12 жил хорих ял оноож байхад манай улсад 1-3, 1-5, 2-8 жил хорих ял оноож байгаа нь шийтгэлийн хувьд хамаагүй хөнгөн гэж үзэх боломжтой. “Тэгэхээр авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд ял шийтгэл хатуу чанга байх ёстой. Энэ нь нөгөө талдаа урьдчилан сэргийлэх бодлого болно. Аливаа ял шийтгэлийн эцсийн зорилго нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ л юм шүү дээ” гэж ахлах мөрдөгч Ч.Жаргалбаатар хэлэв.

*АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс 2019 онд 9.7 их наяд төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө, бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан, 11.3 тэрбум төгрөгийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн.

АТГ нь хууль хэрэгжүүлэгч байгууллага. Батлагдсан хуулийн хүрээнд ажиллана. Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд хийдэлтэй, зохицуулагдаагүй орхигдсон асуудлууд байна. Үүнээс болж тодорхойгүй байдал үүсдэг,

процесийн алдаа гарсаар байгаа. Үүнийг засаж залруулах чиглэлээр холбогдох байгууллагуудад АТГ-аас ажлын хэсэгт орж тодорхой саналуудыг өгдөг. Тус газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням “Бидэнд хуулийг шүүмжлэн, үл дагах эрх байхгүй боловч хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл, хийдэл бүрийг засах, өөрчлөх, боловсронгуй болгох, өмнөө тулгамдсан асуудлыг хамтдаа ярилцан шийдвэрлэх боломж бий” гэж хэллээ.

*АТГ 2020 онд хохирол нөхөн төлүүлэх асуудалд онцгой анхаарч байгаа. Энэ оны эхний 3 сарын байдлаар 5.7 тэрбум орчим төгрөгийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

Эрүүгийн хуулийн зүйл, заалтууд нь нэг мөр болоогүй, авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зоригтой эсэх нь ойлгомжгүй, эрх зүйн орчин нь хийдэл ихтэй манайх шиг улс оронд авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах нь “өвсөн дотроос зүү эрэх”-тэй адил ярвигтай. Хуулийн хийдлийг даруй засах, залруулахын тулд юун түрүүнд улстөрчдийн авлигатай тэмцэх хүсэл зориг маш их ач холбогдолтой. Улстөрчид хүсэл зоригийн бодит илэрхийлэл болгон авлигатай тэмцэх эрх зүйн орчныг АТГ-ын хүсэж буй хэмжээнд хуульчлаад өгөх юм бол авлигын гэмт хэрэг олноороо шийдэгдэнэ, улмаар авлигын гэмт хэрэг үйлдэх хүний тоо цөөрнө.

Эх сурвалж: “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгээс ашиглав.



“СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ГУРАВДАГЧ ОРОН”-Ы ЖАГСААЛТ БА МОНГОЛ УЛС

АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан
Б.Баярсайхан

Европын комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд стратегийн дутагдалтай өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтын төслийг гаргаад байгаа билээ. Уг жагсаалтын төсөлд Монгол Улсыг багтаасантай холбоотойгоор уг жагсаалтыг гаргахад баримталсан шалгуур, түүний үндэслэл, жагсаалтад ороход үүсэх үр дагаврын талаар энд авч үзнэ. Мөн түүнчлэн энэхүү жагсаалтын талаарх талуудын байр суурь, бусад ижил төстэй жагсаалтын талаар энэхүү нийтлэлд авч үзэх болно.

НЭГ. ЕВРОПЫН КОМИССЫН ШИЙДВЭР

Европын комиссоос 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг бэхжүүлэх зорилгоор дараах гурван шийдвэр гаргаад байна. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар ЕХ-ны цогц бодлогыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Өндөр эрсдэл бүхий гуравдагч улс

орныг тодорхойлох шинэчилсэн аргачлал;

- Өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалт (үүнд Монгол Улс багтсан). Өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтын талаарх шийдвэрийг Европын комиссоос боловсруулсан бөгөөд улмаар эцэслэн батлуулахаар Европын Парламент болон Европын Зөвлөлд шилжүүлээд байна.

Дээрх байгууллагууд нэг сарын хугацаанд, амжихгүй бол хоёр сарын хугацаанд хянан хэлэлцээд дэмжвэл уг шийдвэр албан ёсны сэтгүүлд хэвлэгдэж, мөрдөгдөх болно.

Өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтыг гаргахад баримталсан шалгуур

Өндөр эрсдэл бүхий гуравдагч улсыг тодорхойлох техникийн шалгуурыг Европын холбооноос 2015 онд баталсан Мөнгө угаахтай тэмцэх 4 дүгээр удирдамж¹-аар тодорхойлсон. Улмаар шалгуурыг илүү боловсронгуй болгон шинэчилж Мөнгө угаахтай тэмцэх 5 дугаар удирдамжийг 2018 онд баталжээ. Гишүүн улс орнууд уг удирдамжид 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр гэхэд

1 4th Anti-Money Laundering Directive

шилжсэн байх ёстой.²

Удирдамжийн дагуу Европын комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, институцийн хүрээнд стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улсыг тодорхойлохдоо дараах шалгуурыг баримталсан байна.

Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцож буй байдал;
- Санхүүгийн систем дэх хэрэглэгчийн талаарх мэдээллийг нягтлан шалгах болон холбогдох бүртгэлд тавигдаж буй нөхцөл шаардлагын түвшин;
- Сэжигтэй гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаа;
- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл авах, солилцох байдал;
- Холбогдох байгууллагуудын эрх хэмжээ, процедур;
- Олон улсын хамтын ажиллагааны туршлага;
- Шийтгэл, хариуцлагын тогтолцооны үр дүнтэй байдал.

Үнэлгээг гаргахдаа холбогдох олон улсын байгууллагаас гаргасан үнэлгээ, тайлан болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан стандартуудыг баримталсан байна.³

Жагсаалтыг шинэчлэн гаргах давтамж

ФАТФ-ын жагсаалтыг Европын комиссын хувьд суурь түвшин гэж үздэг тул Европын холбооны жагсаалтыг ФАТФ-ын жагсаалт шинэчлэгдэн гарснаас хойш нэг сарын дараа шинэчлэн гаргадаг.

Үүнээс гадна одоо гарч буй

шинэчилсэн аргачлалын дагуу Европын комиссоос өөрийн бие даасан үнэлгээнд үндэслэн гуравдагч улсыг тодорхойлно.

Мөн Европын комиссоос өөрийн стратегийн дутагдалтай байдалд анхаарал хандуулах амлалтаас татгалзсан, эсхүл эрсдэлийн түвшин өндөр байгаа улс орнуудыг нэн даруй жагсаалтад оруулна.

Европын холбооны бие даасан үнэлгээний хүрээнд өөрийн асуудалдаа анхаарал хандуулах амлалт өгсөн гуравдагч улс орон ажиглалтын 12 сарын хугацааг авах боломжтой. Харин дээрх хугацаанд амлалтаа биелүүлээгүй бол жагсаалтад оруулна.

ФАТФ болон ЕХ-ын жагсаалтын уялдаа

Зарчмын хувьд ФАТФ-ын эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад орсон улсыг Европын холбооны жагсаалтад оруулна.

Харин ФАТФ-ын жагсаалтаас хасагдаж байгаа улсыг Европын холбооны жагсаалтаас хасах эсэхийг Европын комиссоос үнэлж шийдвэрлэнэ.

Европын комиссоос гаргасан жагсаалтын үндэслэл

Европын Холбооноос баталсан Мөнгө угаахтай тэмцэх 4 болон 5 дугаар удирдамжид зааснаар Европын холбооны санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү жагсаалтыг гаргадаг.

Үүний дагуу өндөр эрсдэл бүхий гуравдагч улсыг тодорхойлох чиг үүргийг Европын комисс гүйцэтгэдэг. Европын комиссоос энэ жагсаалтыг анх 2016 онд гаргаж байсан бөгөөд үүнээс хойш удаа

² https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counter-terrorist-financing_en

³ https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/qanda_20_821

дараа шинэчилж ирсэн.

Мөнгө угаахтай тэмцэх 5 дугаар удирдамж 2018 онд батлагдсанаас хойш гуравдагч улсыг тодорхойлох шалгуурыг ихээхэн хэмжээгээр өргөжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Европын комиссоос хараат бус үнэлгээг зохион байгуулах, шинэчилсэн аргачлалын дагуу жагсаалт үүсгэх үе шатыг зохион байгуулах шаардлага үүссэн. Мөн Европын парламентаас бие даасан жагсаалт гаргахыг шаардсан юм.

ФАТФ-аас гаргасан жагсаалтад илүү нийцүүлэх зорилгоор Европын парламентаас эрх шилжүүлсний хүрээнд энэ удаа Европын комиссоос өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулав.

ФАТФ-аас 2018 оны 10 дугаар сард хамгийн сүүлийн жагсаалт гаргасан ч Европын холбоо үүнтэй уялдуулан жагсаалтаа өөрчлөөгүй байсан тул энэ удаагийн өөрчлөлт зайлшгүй хийгдэх байсан ажил байв.

Коронавируст хямралын нөхцөл байдалтай уялдуулан энэхүү жагсаалтыг ашиглах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх хугацааг 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр тогтоод байна. Энэ нь нэг талаар цар тахлын

нөхцөл байдалтай холбоотой боловч нөгөө талаас холбогдох талуудад бэлтгэл хангах хугацаа болж байна.

Жагсаалтад орсон улсууд

Европын комисс жагсаалтыг гаргахдаа ФАТФ-аас гаргасан хамгийн сүүлийн жагсаалтыг харгалзан үзсэн. Үүний үр дүнд ЕХ-ны жагсаалтад шинээр 12 улсыг нэмж, зургаан улсыг хасах шийдвэр гаргасан байна (Хүснэгт 1).

ФАТФ-ын “Compliance documents”-д үндэслэн Европын комиссоос Европын Холбооны 2015/849 дугаар Удирдамжийн 9(2) дүгээр зүйлийн дагуу Багамын Арлууд, Барбадос, Ботсвана, Камбож, Гана, Ямаик, Мавритан, Монгол, Бирм, Никарагуа, Панам, Зимбабве улсуудыг жагсаалтад оруулжээ.

Эдгээр улс орнууд өөрийн стратегийн дутагдалтай байдлаа арилгахаар ФАТФ-тай тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, үүнийгээ хэрэгжүүлэх талаар өндөр түвшинд улс төрийн үүрэг амлалтаа өгөөд байсан.

Европын комиссын зүгээс эдгээр орнуудад урьд нь өгсөн энэхүү амлалтыг нь эргэн сануулж шуурхай хэрэгжүүлэхийг уриалж байгаа ажээ.

Хүснэгт 1. ЕХ-ны өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтад орсон, гарсан улсууд

Д/д	Өндөр эрсдэл бүхий гуравдагч улс	Орсон огноо					Гарсан огноо
		2016/09/20	2018/01/24	2018/02/14	2018/10/02	Алба-жаагүй	Алба-жаагүй
1.	Афганистан	+					
2.	Барбадос					+	
3.	Босни Герцеговин	+					+
4.	Ботсвана					+	
5.	Камбож					+	
6.	Хойд Солонгос (БНАСАУ)	+					
7.	Этиоп		+				+

8.	Гана					+	
9.	Гайана	+					+
10.	Иран	+					
11.	Ирак	+					
12.	Ямайка					+	
13.	Лаос	+					+
14.	Мавритани					+	
15.	Монгол					+	
16.	Мьянмар					+	
17.	Никарагуа					+	
18.	Пакистан				+		
19.	Панам					+	
20.	Шри Ланк			+			+
21.	Сири	+					
22.	Багамын Арлууд					+	
23.	Тринидад Тобаго			+			
24.	Тунис			+			+
25.	Уганда	+					
26.	Вануату	+					
27.	Иемен	+					
28.	Зимбабве					+	

https://ec.europa.eu/finance/docs/level-2-measures/aml-delegated-act-2020-2801_en.pdf

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:02016R1675-20181022>

Жагсаалтаас гарах улсууд

Тодорхой хэмжээнд ахиц гаргаж стратегийн дутагдалтай байдлаа залруулсан гэж үзээд Босни-Херцеговина, Гайана, Лаос, Этиоп, Шри Ланк, Тунис улсуудыг жагсаалтаас гаргаад байна. Энэхүү шийдвэр нь албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш 20 хоногийн дараа хүчин төгөлдөр мөрдөгдөх юм.

Жагсаалтад орсны үр дагавар

Мөнгө угаахтай тэмцэх 4 дүгээр удирдамжийн дагуу холбогдох банк, бусад санхүүгийн байгууллагуудын зүгээс жагсаалтад багтсан өндөр эрсдэл бүхий гуравдагч улстай холбоотой гүйлгээнд нэмэлт хяналт тавьж мониторинг хийнэ.

Мөнгө угаахтай тэмцэх 5 дугаар удирдамжид зааснаар дээрх нэмэлт хяналтын хүрээнд хэрэглэгч, ашиг

хүртэгч эздийн талаарх нэмэлт мэдээлэл, бизнесийн харилцаа тогтоохтой холбоотой эрх бүхий этгээдийн зөвшөөрөл зэрэг мэдээллийг шаардах боломжтой.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫГ ЖАГСААЛТАД ОРУУЛСАН ҮНДЭСЛЭЛ

ФАТФ-аас 2019 оны 10 дугаар сард Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой стратегийн дутагдалтай (саарал жагсаалт) улс гэж тодорхойлсон. Монгол Улс стратегийн дутагдалтай байдлаа арилгахын тулд ФАТФ-тай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Европын комиссоос Монгол Улсын дээрх асуудал болон холбогдох бусад мэдээллийг ФАТФ-аас хүлээн авч үнэлгээнд

ашигласан байна. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тогтолцоогоо бэхжүүлэх алхам хийж байгаа боловч дараах асуудлуудыг шийдвэрлэж чадаагүй гэж Европын комисс дүгнэсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч⁴ (СББМҮҮ)-дийг хянах, тэдгээрт мониторинг хийх чиг үүрэг бүхий байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн ойлголт дутмаг, мөн түүнчлэн тэдгээр байгууллагууд, ялангуяа үнэт металл болон үнэт чулуу арилжаалагчдад хяналт тавих байгууллагуудын эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж байгаа байдал нь хангалтгүй;
2. Тодорхойлогдсон эрсдэлүүдийг агуулж байгаа мөнгө угаах үйлдлийн янз бүрийн хэлбэрүүдийг мөрдөх, яллах үйл ажиллагааг идэвхжүүлсэн гэдгээ тодорхой нотлон харуулах шаардлага байгаа;
3. Санхүүгийн институциуд болон СББМҮҮ-дийн комплаенсын хяналт хангалтгүй.⁵

ГУРАВ. ЖАГСААЛТЫН ТАЛААРХ ШҮҮМЖЛЭЛ

2019 оны жагсаалтын төслийн талаар

Европын комиссын шийдвэрийн дагуу дээрх жагсаалтыг анх 2016 онд бий болгож, улмаар 2018 онд гурван удаа өөрчлөлт оруулсан байдаг. Харин 2019 оны 2 дугаар сарын 13-нд жагсаалтад нэмэлт оруулахаар Европын комиссоос шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэрийн төсөлд 23 улс орныг (АНУ-ын харьяаллын зарим нутаг дэвсгэр болон Саудын Араб, Панам зэрэг) хамруулсан ба үүнд ФАТФ-

ын жагсаалтад дурдагдаагүй 11 улс, газар нутгийг хамруулсан байсан.

Уг шийдвэрийг АНУ болон Саудын Арабаас ихээхэн эсэргүүцсэн бөгөөд Европын зөвлөлөөс Европын комиссын дээрх шийдвэрээс санал нэгтгэйгээр татгалзсан юм. Европын зөвлөл дээрх төслийг 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр хэлэлцсэн бөгөөд жагсаалтын төслийг боловсруулахдаа “хангалттай ил тод байж чадаагүй” гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Жагсаалтад АНУ-ын Виржиний арлууд, Пуэрто Рико, Гуам, Америкийн Самоаг оруулсанд АНУ ихээхэн шүүмжлэлтэй хандсан байдаг. Тухайлбал АНУ-ын Сангийн яамнаас “Европын комисс шийдвэр гаргахдаа дүн шинжилгээ хийгээгүй, холбогдох улсуудад дээрх шийдвэрийг эсэргүүцэх, эсхүл асуудлаа шийдвэрлэх боломж олгоогүй” гэж шүүмжилсэн. Мөн өөрийн улсыг жагсаалтын төсөлд оруулсан явдалд ихээхэн харамсаж байгаагаа Саудын Араб улсаас илэрхийлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны амжилтаа онцлон тэмдэглэсэн байдаг. 2018 оны 9 дүгээр сард гарсан ФАТФ-ын үнэлгээний тайланд Саудын Араб улсад анхаарах шаардлагатай асуудлууд байгаа ч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо бэхжүүлэх талаар ихээхэн амжилт гаргасныг онцлон тэмдэглэсэн байдаг.⁶

Энэ удаагийн жагсаалтын төслийн талаарх зарим байр суурь

Зарим судлаачид энэ удаагийн жагсаалтын төслийн талаар ихээхэн шүүмжлэлтэй хандаж дараах асуудлуудыг хөндөж байна. Тухалбал:

⁴ казино, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид, өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус хуульчид болон нягтлан бодогчид
⁵ https://ec.europa.eu/finance/docs/level-2-measures/aml-delegated-act-2020-2801_en.pdf
⁶ <https://www.lexology.com/library/detail.aspx?g=59a6c669-fd03-4828-b948-75056d5a097f>

- Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дээрх улсуудын эдийн засаг нь аль хэдийн хямралтай байхад жагсаалтыг гаргаж байгаа нь хэт нэг талыг барьсан шийдвэр болсон.
- ФАТФ-ын саарал жагсаалтад орсон улс орнуудыг Европын комиссын жагсаалтад хавтгайруулан оруулсан. Үнэндээ ФАТФ-ын хар жагсаалтад Хойд Солонгос, Иран Улс л байгаа.
- Жагсаалтад оруулах шийдвэрийн төслийн талаар тухайн улс орнуудад урьдчилан мэдэгдэх, санал авах, эсхүл шийдвэрийг эсэргүүцэх боломж олгоогүй.
- ЕХ-ноос жагсаалтад орсон улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх талаар дурдсан байгаа боловч уг туслалцаанд юу багтаж байгаа, мөн ФАТФ-ын санал болгодог туслалцаанаас ямар ялгаатай болох талаар тодорхой мэдээлэл өгөөгүй зэрэг шүүмжлэлийг гаргаж байна.⁷

ДӨРӨВ. ИЖИЛ ТӨСТЭЙ БУСАД ЖАГСААЛТЫН ТАЛААР

ФАТФ-ын жагсаалт

Парис хотод 1989 онд болсон “Их-7”-ийн уулзалтаар ФАТФ-ыг байгуулсан.

Тус байгууллагын үндсэн зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон олон улсын санхүүгийн системийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын норм, стандартыг бий болгох асуудал байсан юм. Энэ хүрээндээ ФАТФ-ын 40 зөвлөмжийг улс орнуудад зөвлөмж болгодог.

ФАТФ-аас “Үйл ажиллагаа явуулах шаардлагатай⁸” улс буюу хэвлэл мэдээллийн нэршлээр “хар жагсаалт”-ыг

2000 оноос хойш гаргаж ирсэн бөгөөд одоогийн байдлаар Хойд Солонгос, Иран Улс багтаж байгаа юм.

Харин тус байгууллагын саарал жагсаалтад Монгол зэрэг 11 улс багтаж байна.

ЕХ-ны татварын хүрээнд хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалт

Уг жагсаалтыг Европын холбооноос татвараас зайлсхийх асуудалтай тэмцэх зорилгоор 2017 оноос гаргаж эхэлсэн юм. Одоогийн байдлаар 12 улсыг хамруулсан байдаг.

Монгол Улс уг жагсаалтад ороогүй байгаа ч байнгын хяналтад байгаа улсаар тодорхойлсон байдаг⁹.

Шүүмжлэгчдийн зүгээс уг жагсаалтад “татварын диваажин” болсон Швейцарь, Кайманы арлууд болон ЕХ-ны Ирланд, Люксембург, Нидерланд, Мальта зэрэг хамгийн багадаа 35 улсыг хамруулах нь үр дүнтэй гэж дүгнэсэн байдаг¹⁰.

ТАВ. МОНГОЛБАНКНЫ МЭДЭГДЭЛ

Европын комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд Монголбанкаас 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдөр мэдэгдэл гаргасан¹¹.

Мэдэгдэлд Европын Холбооны Комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны стратегийн дутагдалтай өндөр эрсдэлтэй улсуудын жагсаалтад Монгол Улсыг оруулахаар төлөвлөж байгаатай холбоотойгоор энэ чиглэлээр өмнө хийгдсэн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээг дурдаад мэдээлэлд үнэн зөв, бодитой хандахыг уриалжээ.

7 <https://caribbeantradelaw.com/2020/05/10/the-eus-updated-draft-aml-cft-list-of-high-risk-third-jurisdictions-take-two-a-critique/>

8 Call for action

9 https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/MEMO_19_1629

10 <https://www.oxfam.org/en/press-releases/effective-eu-tax-haven-blacklist-must-include-least-35-countries>

11 <https://www.mongolbank.mn/news.aspx?id=2512&tid=1>

ДҮГНЭЛТ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий зарим “номхон” улс орнуудыг багтаасан жагсаалтыг Европын комиссоос гаргасан байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх боломжийг ихээр олгож байгаа оффшор бүсүүдийг уг жагсаалтад бүрэн оруулахгүй байгаа нь хэт нэг талыг барьсан шийдвэр гэж үзэхэд хүргэсэн юм.

Европын комиссоос гаргасан өндөр эрсдэл бүхий гуравдагч улсын жагсаалтын хувьд улс орнуудыг хамруулахдаа дээрх дурдсанчлан хэт нэг талыг барьсан, мөн улс орнуудад урьдчилан мэдэгдээгүй, хамгаалах боломж олгоогүй зэрэг шүүмжлэл давамгайлж байна.

Уг жагсаалтын талаар Европын холбооны байгууллагууд харилцан нэгдмэл бус байр суурьтай явж ирснийг өмнөх жагсаалтын төсөл харуулж байгаа.

Эх сурвалж:

- European Commission, 2020.5.7, *Commission steps up fight against money laundering and terrorist financing*, https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_20_800
- European Commission, 2020.5.7, *Questions and Answers – Commission steps up fight against money laundering and terrorist financing*, https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/qanda_20_821
- European Commission, Commission staff working document, *Methodology for identifying high-risk third countries under Directive (EU) 2015/849* https://ec.europa.eu/info/sites/info/files/business_economy_euro/banking_and_finance/documents/200507-anti-money-laundering-terrorism-financing-action-plan-methodology_en.pdf
- European Commission, COMMISSION DELEGATED REGULATION (EU) .../... of 7.5.2020, https://ec.europa.eu/finance/docs/level-2-measures/aml-delegated-act-2020-2801_en.pdf
- Монгол банк, Мэдэгдэл,
- <https://www.globalriskaffairs.com/2019/03/the-controversial-eu-list-of-high-risk-third-countries/>
- <https://www.politico.eu/article/eu-countries-revolt-against-commission-dirty-money-list-vera-jourova/>
- <https://www.politico.eu/article/eu-countries-revolt-against-commission-dirty-money-list-vera-jourova/>
- <https://www.lexology.com/library/detail.aspx?g=59aec669-fd03-4828-b948-75056d5a097f>
- <https://caribbeantradelaw.com/2020/05/10/the-eus-updated-draft-aml-cft-list-of-high-risk-third-jurisdictions-take-two-a-critique/>



НИЙГМИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАН ОЛОН НИЙТИЙН СЭТГЭЛ ЗҮЙД НӨЛӨӨЛЖ БҮЙ БАЙДАЛ

АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан
Д.Жаргалан

Өнөөгийн мэдээллийн эрин үед уламжлалт төрийн удирдлагын бүтэцтэй харьцуулахад интернэт нь олон нийтийн сэтгэл зүйг удирдахад илүү өндөр бүтээмжтэй байдгийг судлаачид онцолдог. Улс төрийн өрсөлдөөн, бизнесийн бараа, бүтээгдэхүүний маркетинг, зар сурталчилгаа, шашны үзэл суртлыг түгээх зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаанд интернэт ашиглан олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх явдал нь дэлхийн чиг хандлага болсон.

Цахим орчинд тайлбар нотолгоогүй, баримтгүй, шинжлэх ухааны үндэслэлгүй маш олон тооны мэдээллийг санал болгодог. Ингэхдээ мэдээллийн сайтууд, блогууд, нийгмийн сүлжээ, цахим шуудан, форумууд, чат сүлжээг өргөнөөр ашигладаг. Интернэт орчин дахь мэдээллийн илүүдэл болон давталт нь хуурамч шинжтэй, шинжлэх ухааны үндэслэлгүй контентийг үүсгэдэг.

“Дэлхийн хуурамч мэдээллийн систем-2019: нийгмийн сүлжээ дэх зохион байгуулалттай төөрөгдүүлэх ажиллагааны ангилал”¹ судалгааны тайланд дурдагдсанаар 70 улсад интернэт ашиглан олон нийтийн санаа

бодлыг төөрөгдүүлж байна. БНХАУ, Энэтхэг, Иран, Пакистан, ОХУ, Саудын Араб, Венесуэл зэрэг улсууд интернэт болон нийгмийн сүлжээ ашиглан бусад улс оронд улс төрийн зорилгоор нөлөөлөх ажиллагаа явуулсан хэмээн судлаачид үзэж байна. БНХАУ-ыг зөвхөн дотооддоо төдийгүй гадаад улс оронд хамгийн ихээр хуурамч мэдээлэл түгээдэг улс гэж судлаачид нэрлэжээ.

Дэлхийн 25 улс сурталчилгаа явуулах зорилгоор хувийн интернэт компаниудтай, тухайлбал Фэйсбүүк компанитай хамтран ажилладаг байна. АНУ, Англи, Хятад, Орос, Узбекистан, Вьетнам, Турк, Унгар, Грек, Өмнөд Африк, Өмнөд Солонгос, Сири, Куба, Хорват зэрэг 56 улс фэйсбүүк хэрэглэгчдийн дунд хуурамч мэдээлэл түгээх ямар нэгэн кампанит ажлыг гүйцэтгэсэн хэмээн судлаачид үзэж байна.

ОХУ нь олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх зорилгоор тэргүүлэгч интернэт платформууд болох Твиттер, Фэйсбүүк, Ютүб, Инстаграмыг ашигладаг байна. Харин Испани, Бразил, Энэтхэг, Мексик, Колумб, Венесуэл, Зимбабве зэрэг улс нь ВатсАп сүлжээг

¹ <https://comprop.oii.ox.ac.uk/wp-content/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>

ашигладаг.

Хамгийн ихээр ашиглагддаг байдлаараа Твиттер нь Фэйсбүүкийн дараа ордог. Энэхүү платформийг Орос, Австри, Австрали, Герман, Израил, Швед, Англи, Америк зэрэг 47 улс ашиглаж байна.

Судалгаанд хамрагдсан нийт улс орны 87 хувь нь олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх зорилгоор бодит хүмүүсийн хаягийг ашигладаг бол 80 хувь нь бот-хаяг, 11 хувь нь киборг-хаяг (өөрийн хаягаар бот удирдахыг хэлнэ), 7 хувь нь хулгайн болон эвдсэн хаяг ашигладаг байна.

Өнгөрсөн онд нийгмийн сүлжээ ашиглагчдын санаа бодлыг төөрөгдүүлэх, хуурамч мэдээлэл түгээх оролдлогыг 52 улсад зохион байгуулсан бол 47 улсын төр засаг нь улс төрийн сөрөг хүчин, улс төрийн идэвхтнүүдийн эсрэг трол, бот ашигласан нь 2018 онтой харьцуулахад даруй 2 дахин их байна.

Тусгай арга, хэрэгслүүд

Цахим орчинд олон нийтийн санаа бодол, хандлага ойлголтод нөлөөлөх, төөрөгдүүлэхийн тулд олон төрлийн арга хэрэгслийг ашигладаг байна.

Astroturfing. Астротурфинг гэдэг нь цахим орчин дахь тодорхой үйл ажиллагаанд зорилтот бүлгийг татан оролцуулах зорилгоор өргөн цар хүрээтэйгээр тэдний сэтгэл зүйг зохиомлоор өдөөх, төөрөгдүүлэх үйл ажиллагаа юм. Энэ хүрээнд мөн олон тооны хүмүүс тодорхой асуудлыг дэмжиж байгаа, эсхүл эсэргүүцэж байгаа мэт сэтгэгдлийг зохиомлоор бий болгох, хүмүүсийн санаа бодлын бодит тусгалыг дарагдуулах, бүдгэрүүлэх, арилгах зорилготой үйл ажиллагаа хийгддэг.

Cyber troops. Форум, блог, нийгмийн

сүлжээнд бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйл явдал, үзэл бодол, бие хүн, байгууллага, улс орны талаар олон нийт дэмжиж, эсхүл эсэргүүцэж буй мэт сэтгэгдэл төрүүлэх зорилгоор захиалгатай пост оруулах, захиалгат коммент хийх хүмүүсийг хөлслөн ажиллуулдаг. Засгийн газруудын зүгээс цахим цэргүүдийг ашиглах явдал жилээс жилд өсөж байна². Цахим цэргийн хүчээр интернэт, нийгмийн мэдээллийн сүлжээнд иргэд, олон нийтийг зохион байгуулалттайгаар төөрөгдүүлэх үйл ажиллагааг 2017 онд 28 оронд явуулж байсныг судалгаагаар тогтоосон бол 2018 онд 48, 2019 онд 70 оронд ийм үйл явц бүртгэгджээ.

Цахим цэргийг хамгийн ихээр ашигладаг талбар нь Фэйсбүүк юм. Учир нь энэ бол найз нөхөд, гэр бүлийн сүлжээ үүсгэдэг, улс төрийн, бизнесийн, үзэл бодлын болон бусад бүх төрлийн мэдээлэл солилцох боломжтой дэлхийн хамгийн том нийгмийн сүлжээний платформ юм. Ирээдүйд Фэйсбүүк, Ютүб, ВатсАп зэрэг платформуудыг идэвхтэй ашиглан олон нийтийн санаа бодлыг өөрчлөх, нөлөөлөх ажиллагаа ихээр хийгдэх төлөвтэй байгааг “Дэлхийн хуурамч мэдээллийн систем-2019: нийгмийн сүлжээ дэх зохион байгуулалттай төөрөгдүүлэх ажиллагааны ангилал” судалгааны тайлан онцолжээ.

Flaming. Флэйминг буюу “маргааны хажуугаар маргаан” дэгдээх арга нь интернэт-форум, чат, нийгмийн сүлжээнд мэдээлэл солилцохдоо маргааны анхдагч шалтгаанд хамааралгүй асуудлаар үгээр давшлах, доромжлох замаар хийгддэг.

Trolling. Троллинг гэдэг нь нийгмийн сүлжээнд санаатайгаар өдөөн хатгах, хууран мэхлэх, маргаан дэгдээх, хагарал үүсгэх, зүй бус үйлдэл хийхэд турхирах үйл ажиллагааг хэлдэг.

Web robot (bot). Интернэт бот, www-

2 Оксфордын Их Сургуулийн “Дэлхийн хуурамч мэдээлэл захиалагч 2019 он: Нийгмийн сүлжээ дэх төөрөгдөл” судалгааны тайлан

бот нь хүнд зориулсан интерфэйс (хоёр систем, байгууллага, сэдэв огтолцох цэг)-ээр дамжуулан автоматаар, эсхүл өгөгдсөн хуваарийн дагуу ямар нэгэн үйлдэл хийдэг тусгайлсан программыг хэлдэг.

Flood. Флуд нь интернэт чат, форумд нэг төрлийн, зарим нөхцөлд их хэмжээний зай эзлэх мэдээлэл, эсхүл програм түгээх үйл ажиллагаа юм. Энэ нь хэрэглэгчийг сүлжээнээс тасалдуулах, сүлжээнд ачаалал үүсгэх зорилготой. Техникийн флуд гэдэг нь нэгэн зэрэг ихээхэн хэмжээний мэдээлэл явуулснаар системийн ажиллагааг алдагдуулах хакерын дайралт юм. Флудыг троллингийн зорилгоор түгээж болдог ба энгийн пранк /тоглоом хийх/ зорилгоор ч түгээх явдал байдаг.

Internet surf. Энэ нь үгчлэн хөрвүүлэх нөхцөлд интернэт “ухах”, судлах, хайлт хийх гэсэн үг юм. Гэтэл интернэт серфинг гэдэгт рейтинг өсгөх зорилгоор ямар нэгэн мэдээллийг хэдэн удаа үзсэн талаарх “тоолуур”-ыг зохиомлоор “нэмэгдүүлэх”-ийг хэлдэг.

Fake news. Хуурамч мэдээ гэдэг нь уламжлалт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээнд санхүүгийн болон улс төрийн ашиг, давуу байдал олох зорилготой, санаатай төөрөгдөлд оруулах мэдээлэл цацах, түгээх үйл ажиллагааг хэлнэ.

Spin-doctoring. Спин-эмч, медиа-зөвлөх нь үйлчлүүлэгчийн (хувь хүн, хуулийн этгээд, улс орон байж болно) унасан нэр хүндийг богино хугацаанд өөрчлөх, олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилготой үйлчилгээ юм. Холбоотой хүнийг буруутгах, дайрч давшлах, анхаарлыг өөр зүйлд шилжүүлэх, эх сурвалжийг гутаах, нөхцөл байдлыг утга учиргүй болгох, тохуурхах, сүрдүүлэх зэрэг арга замаар дамжин хэрэгждэг.

Filter Bubble. Хөөсөн фильтр гэдэг

нь хайлтын системүүд (Фэйсбүүк, Гүүгл, ВКонтакте, Яндекс, Яхүү, Бинг, Байду, Аск, Навер зэрэг) хэрэглэгчид шаардлагатай бүх мэдээллийг бус харин хэрэглэгчийн байршил, сонирхол, өмнөх хайлтийн түүх, хулганы хөдөлгөөнд үндэслэн мэдээллийг эрэмбэлэн харуулах гаргах явдал юм.

Жишээ, баримт

Twitter дэх ботын жишээ. Ботууд төрөл бүрийн үүргийг гүйцэтгэж болно. Тухайлбал хүний оролцоогүйгээр асуултад хариулах, шинэ мэдээ, мэдээллийг нийтлэх, хуурамч мэдээлэл түгээх, цахим үнэлгээ, асуулгын дүнг өөрчлөх гэх мэт.

Mocksession.com цахим хуудасны CNN Breaking News Bot (@attention_cnn) нь Си Эн Эн агентлагаас хэрэглэгчдийн анхаарлыг татах онцлог шинэ мэдээ, мэдээлэл гаргах үед дамжуулдаг.

Washington Post (@PowerPost) нь Вашингтон дахь шийдвэр гаргагчдын талаар мэдээлэл гарахаар дохио өгдөг.

Бразил Улсад Twitter-т Роза нэртэй (Rosie@RosieDaSerenata) ботыг төрийн өндөр албан тушаалтнууд төсвийн хөрөнгийг хувийн зорилгоор завших явдлыг илрүүлэхэд ашиглаж байна.



Зураг 1. CNNBreakingNewsBot



Зураг 2. Бразилийн Засгийн газрын төсвийн хөрөнгийн зарцуулалтыг хиймэл оюуны тусламжтай нягтлан шалгах “Хайрын дуулал” нэртэй төслийн бий болгосон бот

Хуурамч мэдээллийн жишээ

BuzzFeed³ (Базфид) сайтад “OliverStonne” нэртэй хэрэглэгч Английн тагнуулын албаны ажилтантай хийсэн ярилцлага мэтээр мэдээ гаргасан байна. Тус мэдээний утга нь Английн Ерөнхий сайд асан Дэвид Камерон болон АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтон нарын захиалгаар нэр дэвшигч Дональд Трампыг сонгогдоход МИ6 саад учруулж байсан гэжээ.

Community

MI6 Operative On Anti-Trump Campaign

Few people doubted that Hillary Clinton was going to win the presidential race in the USA. However following the election results, billionaire Donald Trump becomes the 45th POTUS. The news proved to be a real shock to the global politics and denoted the intensification of the anti-Trump campaign aimed at disputing his victory.

Posted on January 20, 2017, at 8:33 a.m.

OliverStonne
Community Contributor

This post has not been vetted or endorsed by BuzzFeed's editorial staff. BuzzFeed Community is a place where anyone can create a post or quiz. Learn more or post your buzz!



BuzzFeed сайтын мэдээллээр тус нийтлэлийг 522 удаа үзэж, Фэйсбүүк, Твиттерт иш татсан байна. Мөн хэд хэдэн гадаад хэл рүү хөрвүүлэгдэн бусад орны нийгмийн сүлжээнд иш татагджээ.

3 <https://www.bbc.com/russian/features-50835324>

4 https://www.wikivand.com/ru/%D0%90%D1%81%D1%82%D1%80%D0%BE%D1%82%D1%83%D1%80%D1%84%D0%B8%D0%BD%D0%B3#/cite_note8

5 <https://www.dw.com/ru>

6 <https://evolkov.net/moodle/mod/forum/discuss.php?d=219>

Астротурфинг хэрэглэсэн тодорхой улс орнуудын жишээ⁴

Английн “Дөрөвдүгээр суваг” компанийн судалгаагаар Кэмбриж Аналитика компани нь 2013-2018 онд дэлхийн олон улсын сонгуулийн үйл явцад нөлөөлсөн гэжээ. Үүнд АНУ-ын 2016 оны Ерөнхийлөгчийн сонгууль, Английн Европын Холбооны гишүүнчлэлийн тухай референдумийн үр дүнд нөлөөлсөн гэж үзсэн⁵. Компани нь астротурфингийн арга хэрэгслүүдийг ашиглан их хэмжээний бот үүсгэсэн ба хуурамч бүртгэл үйлдсэн байна.

Хятадад 2000 оны дундаас эхлэн тус улсын Засгийн газар, түүний үйл ажиллагааны талаар эерэг үзэл бодол системтэйгээр илэрхийлдэг сүлжээ ажиллуулж эхэлсэн. Нэг удаагийн пост, эсхүл коммент хийсний төлөө 5 маогийн урамшуулал авдгаас үүдэн эдгээр интернэт бригадад “5 маогийн арми”⁶ буюу “Умадон” гэсэн нэр өгчээ. Зарим тооцооллоор бүх Хятадын хэмжээнд 300 мянган ийм хэрэглэгч байдаг.

Оросын төр, засгийн эрх ашгийн үүднээс тус улсын дотоодод болон гадаадад байгаа олон нийтийн санаа бодолд нөлөөлдөг интернэт судалгааны агентлаг Петербургд байдаг талаар 2013 онд “Новая газета” нийтэлсэн. Хөлсөлсөн албан хаагчдын тусламжтайгаар үүнийг гүйцэтгэдэг ба “кремлебот” гэсэн нэртэй болжээ. Тус компанийн байршилтай холбоотойгоор мөн “Ольгагийн троллууд” гэж нэрлэх нь байдаг. Америкийн зарим сэтгүүлчид тус компанийг АНУ-ын ерөнхийлөгчийн 2016 оны сонгуулийн үр дүнд нөлөөлсөн хэмээн мэдэгдэж байсан. Оросын ард иргэд төр, засагтаа итгэж байгаа, Засгийн газрын гаргасан

шийдвэрийг дэмжиж байгаа, улс төрийн сөрөг хүчнийг хүлээж авахгүй байгааг илэрхийлсэн мэдээллийг интернэтэд түгээх тусгайлан хөлсөлсөн “бригад” ажиллаж байна гэсэн таамаглалыг 2000 оны эхээс Оросын сөрөг хүчний зүгээс илэрхийлж эхэлсэн.

Америкийн Батлан хамгаалах яамны 27 мянган албан хаагч олон нийттэй харилцах асуудлыг хариуцдаг бөгөөд жилийн төсөв нь 4.7 тэрбум доллар болдог гэж “Ассошейтэд пресс” мэдээллийн агентлагийн 2009 онд хийсэн судалгаанд дурдагджээ. Тус агентлагийн ерөнхий захирал Том Керли АНУ-ын арми нь чөлөөт хэвлэл, мэдээллийн эсрэг маш том суртал ухуулгын машин болж хувирсан хэмээн мэдэгджээ.

Америкийн Засгийн газраас хилийн чанадад явуулах суртал ухуулгын үйл ажиллагаанд хэрэглэх програм хангамжтай холбоотойгоор Пентагон 2.76 сая ам.долларын гэрээг Нтрепид (Ntrepid) гэх компанитай 2011 оны гуравдугаар сард хийсэн⁷ байна.

Туркийн засгийн эрхийг барьж буй Шударга ёс, хөгжил дэвшлийн намын (туркаар Адалет ви Калкинма Партиси) нэрний эхний үсгүүдээр нэрлэгдсэн, тус намаас санхүүжигддэг “АК тролл”-ууд 2013 оноос ажиллаж байна. Мөн түүнчлэн сөрөг хүчин болон тэдний удирдагчдын эсрэг ажиллах үүрэгтэй “Шинэ турк дижитал оффис” нэртэй байгууллагыг 2015 онд болсон парламентын сонгуулийн өмнө байгуулсан бөгөөд тухайн үедээ 180 хүний бүрэлдэхүүнтэй байв⁸. Энэхүү байгууллага нь контент үйлдвэрлэх, нийгмийн сүлжээнд ажиллах, мэдээлэл хүлээн авах, кампанит ажлын зохион байгуулах үндсэн чиг үүргийг

хариуцсан дөрвөн нэгжтэй байсан.

Украины Ерөнхийлөгч Петр Порошенког сурталчилдаг төлбөртэй троллууд түүнийг засгийн эрхэнд байх үед ажилладаг байсан ба 2019 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр бусад нэр дэвшигчдийн эсрэг идэвхтэй ажилласан. Тухайлбал ялалт байгуулсан Владимир Зеленскийг гутаах ажиллагаа маш эрчтэй явагджээ. Эдгээр троллууд нь “Порохобот” гэж нэрлэгджээ. 2014 оны гуравдугаар сард Крымыг ОХУ-д нэгдэх үед интернэт орчинд Крымын орос хэлтэй оршин суугчдын нэрийн өмнөөс Украины бүрэлдэхүүнээс гарахыг эсэргүүцсэн коментууд ихээр явсан. Эдгээр коментийн зонхилох хэсгийг украин, америк цэргийнхэн хийсэн гэдгийг Украины Батлан хамгаалах яамны эх сурвалж мэдээлсэн байдаг.

Азербейжаны Засгийн газар тэрс үзэлтнүүдийн цахим шууданг хянахад ашиглах програм хангамжийг Америкийн Виржини мужид төвтэй Бүүз Аллен Хамилтон⁹ компаниас худалдан авсан гэж Азербейжаны мэдээллийн “Туран” агентлаг болон “Азадлик” сонин мэдээлж байв¹⁰. Програм нь нийгмийн сүлжээнд тэрс үзэлтнүүдийг илрүүлэх хуурамч хаяг нээн ажиллуулдаг байна. Тус улсын тусгай алба нийгмийн сүлжээ ашиглан төр засгийн бодлого эсэргүүцэгчдийг илрүүлдэг.

Улс орнууд, компаниудын зүгээс хийж буй тэмцэл

Улс орнууд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд энэхүү асуудалтай тэмцэхээр ихээхэн хүч чармайлт гаргаж байна. Тухайлбал тусгай алгоритм, програм боловсруулан цахим орчин дахь

7 <https://www.telegraph.co.uk/technology/social-media/8389577/Pentagon-buys-social-networking-spy-software.html>

8 <https://www.dailysabah.com/elections/2015/05/11/ak-party-founded-new-turkey-digital-office-for-the-general-elections-on-june-7>

9 https://pikabu.ru/story/astrotrufing_ili_che_u_vas_mnenie_3820821

10 <https://edri.org/edriogramnumber9-6identify-dissidents-online/>

хуурамч мэдээлэл, бот, троллийг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

Америкийн төрийн бус байгууллага болох “Ардчиллыг хамгаалах альянс”¹¹ нь Хамилтон-68 гэх (<http://dashboard.securingdemocracy.org>) талбар нээн ажиллуулж байна. Энэ нь АНУ болон бусад гадаад улс орнууд твиттерээр ямар мэдээлэл түгээж байгааг олон нийтэд тухайн цаг үед нь мэдээлж байх зорилготой байна. Түүнчлэн Индианагийн их сургуулиас боловсруулсан Ботометр¹² нь твиттер дэх бот програм хаах зориулттай бол Нью Мексико их сургуулиас боловсруулсан Debot програм¹³ нь бот програмыг олж илрүүлдэг бөгөөд 2017 онд 730 мянган бот олж тогтоожээ.

Фэйсбүүк, Ютүб, Гүүгл зэрэг компаниуд хуурамч мэдээ, мэдээлэл, тролл, бот зэрэгтэй тэмцэхээр ажиллаж байна. Эдгээр компаниуд нь хэрэглэгчдэд хуурамч мэдээллийг хэрхэн таних талаар зөвлөгөө зөвлөмж гаргах, хуурамч хаяг устгах, хүн удирдаж буй тролл, хүн болон програм ашиглан хуурамч хаяг нээж, түгээж буй хуурамч мэдээллийг таних програм боловсруулах зэргээр ажиллаж байна. Фэйсбүүк компани өөрийн сүлжээн дэх 2.2 сая гаруй хуурамч хаягийг 2019 оны 5 дугаар сард устгажээ. Компанийн зүгээс иймэрхүү хуурамч хаяг тогтмол өсөж байдаг ба нийт хэрэглэгчдийн 5 хувийг эзэлдэг хэмээн мэдэгдсэн.

Гүүглийн охин компани болох Жигсоу компаниас “машин танин мэдэхүй”-г ашиглан цахим хуудсуудыг үнэлж байна. Энэ зорилгоор сүүлийн 10 жилийн хугацаанд сүлжээнд явагдсан хэлэлцүүлэг, коммент зэрэг архивын баримтуудыг

“машин танин мэдэхүй”-гээр үнэлүүлэхээр Жигсоуд гаргаж өгч байгаа бөгөөд Нью Йорк таймс энэ үйл ажиллагааны талаар “Гүүгл компани бүх туршилт, загвар болон судалгааны үр дүн зэргийг нээлттэй гаргаж өгч байгаа” гэж мэдээлжээ.

Украин Инстаграм, Фэйсбүүк, Телеграм, ТикТок зэрэг сүлжээнд ашиглах Дия (Dija) гэх аппикэйшнийг украин хэлээр боловсруулсан байна¹⁴. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хуурамч мэдээлэл түгээх асуудлыг бууруулахад зориулагдсан ба туршилт хийгдэж байна.

Төрийн албаны бүх үйл ажиллагаа нь цахимаар явагддаг Эстоний e-Eston нь 2007 оны 4 дүгээр сарын 27-нд хакерын дайралтад өртсөн бөгөөд маш өргөн хүрээний хакерын дайралт байснаас үүнийг “кибер дайн” гэж нэрлэсэн байдаг. Тухайн үед төрийн цахим хуудсууд, бүртгэл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бараг бүгд гацжээ^{15,16}. Үүнээс улбаалан Эстони Батлан хамгаалах яамныхаа харьяанд кибер нэгж байгуулсан нь Европын цахим аюулгүй байдлын төв болсон.

Улмаар 2008 онд Таллинд Дэлхийн цахим төвийг байгуулсан. Умард Атлантын цэргийн эвслийн Цахим аюулгүй байдлын төвийн сургалтад 25 улс орны 900 мэргэжилтэн жил бүр цуглардаг болсон. Түүнчлэн жил бүр Таллинд болдог олон улсын цахим аюулгүй байдлын “Цахим асуудал”¹⁷ хуралд тус салбарын 600 мэргэжилтэн цуглардаг.

Эстони мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд блокчейн технологи Кей Эс И¹⁸ боловсруулсан. Энэхүү технологийг

11 The Alliance for Securing Democracy

12 <https://botometer.iuni.iu.edu>

13 <https://www.cs.unm.edu/~chavoshi/debot/>

14 <https://www.unian.info/society/10862348-ukraine-launches-dija-app-opening-access-to-wide-range-of-gov-t-services-online.html>

15 <https://foreignpolicy.com/2017/04/27/10-years-after-the-landmark-attack-on-estonia-is-the-world-better-prepared-for-cyber-threats/>

16 <https://www.wired.com/2007/08/ff-estonia/>

17 CyCon – Cyber Conflict Цахим асуудал <https://cycon.org/>

18 Keyless signature infrastructure

өнөөдөр Умард Атлантын цэргийн эвслийн улс орнууд болон АНУ-ын батлан хамгаалах салбарынхан ашиглаж байна.

Европын Холбооны гадаад харилцааны албанд (EEAS) Стратегийн харилцааны ажлын хэсгийг (East StratCom Task Force) 2015 онд байгуулсан. Ажлын хэсэг¹⁹ нь одоогийн байдлаар 4500 гаруй хуурамч мэдээлэл тараасан баримтыг тогтоогоод байгаа бөгөөд Европын холбооны бусад албадтай хамтран Европын холбооны талаарх үнэн бодит мэдээлэл түгээхэд оролцож байна. Гибрид аюулд²⁰ хариу өгөх Ерөнхий хөтөлбөрийг 2016 онд баталсан ба Европын холбооны гибрид аюул, заналхийлэлд шинжилгээ хийх төв (EU Hybrid Fusion Cell)²¹-ийг байгуулсан. 2017 онд Хельсинкид Гибрид аюулын эсрэг тэмцэх Европын тэргүүн туршлагын төв (European Centre of Excellence for Countering Hybrid Threats)-ийг байгуулан ажиллаж байна.

Монгол Улс дахь нөхцөл байдал²²

2020 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсад 2.2 сая интернэт хэрэглэгчид байна. Энэ нь 2019 оны тоо баримттай харьцуулахад төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

2020 оны 1 дүгээр сарын байдлаар интернэт нэвтрэлт 68 хувьтай байгаа бөгөөд нийгмийн сүлжээ ашиглагчдын тоо 2.2 сая байна. Үүнийг 2019 оны 4 дүгээр сарын хэрэглэгчдийн тоотой харьцуулахад 219 мянгаар буюу 11 хувиар өссөн байна. Нийгмийн сүлжээнд нэвтрэлтийн тоо 68 хувиар өссчээ.

2020 оны 1 дүгээр сарын байдлаар 4.42 сая гар утасны холболт бүртгэгдсэн бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын тоотой

харьцуулахад 199 мянгаар буюу 4.7 хувиар нэмэгдсэн байна. 2020 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсын гар утасны холболт нийт хүн амын 136 хувьтай тэнцэж байна.

СИКА ХХК нь болон Монголын санхүүгийн зах зээлийн холбоо байгууллагууд “Монголын нийгмийн үеийн судалгаа”-г 2020 онд зохион байгуулан гүйцэтгэжээ. Тус судалгаагаар 7327 хүний мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна.

Тайланд²³ манай улсын иргэдийн нас залуужих тусам интернэт болон төрөл бүрийн цахим талбар ашигладаг хувь хэмжээ нэмэгдэж байгаа (Зураг 1), цахим орчинд хамгийн ихээр ашигладаг талбарууд нь Фэйсбүүк, Ютүб, Инстаграм гэж тодорхойлогдсон (Зураг 2), судалгаанд оролцогчдын 43.6 хувь нь телевизийг, 23.6 хувь нь нийгмийн сүлжээг, 12.5 хувь нь найз нөхөд, ажлын хамт олны хүрээнд сонссон мэдээллээ, 11.0 хувь нь сонин, сэтгүүлийг, 9.8 хувь нь мэдээллийн цахим хуудсуудыг, 8.6 хувь нь гэр бүлийн хүрээнд сонссон мэдээллийг, 3.2 хувь нь радио/богино долгионы радиог мэдээллийн голлох эх сурвалжаа гэж нэрлэсэн (Зураг 3) талаар тус тус дурджээ.


¹⁹ <https://euvsdisinfo.eu/disinfo-review/>

²⁰ Гибрид аюул гэдэгт ардчилсан улс, институцийн сул, эмзэг талын эсрэг улс орнууд, эсхүл субъектууд зохион байгуулалттай өргөн хүрээний арга хэрэгсэл, үйл ажиллагаа явуулахыг ойлгоно. Үүнд цахим дайралт, хуурамч мэдээлэл түгээх, сонгуулийн үр дүнд нөлөөлөх, нийгмийн сүлжээнд хуурамч мэдээлэл түгээх зэрэг багтана.

²¹ https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/IP_19_2788

²² <https://datareportal.com/reports/digital-2020-mongolia>

²³ <file:///C:/Users/jargalan/Downloads/download.pdf>



Зураг 3. Интернет ашиглалтын хэмжээ



Зураг 4.Тогтмол ашигладаг апликаци нийт оролцогчоор, хувиар



Зураг 5. Мэдээллийн эх сурвалж нийт оролцогчдоор, хувиар

Монгол Улсын хувьд цахим аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлд (3.6)

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсийг “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг

баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” хэмээн зааж өгсөн байна. Уг үзэл баримтлалын 3.6.1.12.-т Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ /3.6.1.12./ хэмээн тусгасан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.6 дахь хэсэгт “Мэдээллийн аюулгүй байдал” гэсэн ойлголтыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай ойлголтод хамруулсан байна. Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлд “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэг оруулж өгсөн.

Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 01 дүгээр тогтоолоор цахим хуудас дахь сэтгэгдлийг зохистой хэрэглэх зорилгоор “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай журам баталсан. Үүний дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2013 оны 05 тоот тогтоолоор “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг баталсан хэдий ч Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны ээлжит 7 дугаар хуралдаанаар “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг хүчингүй болгох арга хэмжээг авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дүгээр тогтоолоор “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” баталсантай холбоотой юм.

Уг төлөвлөгөөний наймдугаар хэсэгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг

хангах чиглэлээрх арга хэмжээнүүдийг тусгасны дотор цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай Засгийн газрын 2013 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болгохыг тусгажээ.

“Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг хүчингүй болгох нь хэд хэдэн шалтгаантай²⁴ байсан гэж “Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт” судалгааны тайланд дурдсан байна. Үүнд:

- Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд халдлаа, боомилох үндсийг тавьж байна гэж хүчтэй эсэргүүцсэн.

- Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх зөрчигдөж байна. Ялангуяа мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгэж, шүүлтүүр хэрэглэж байгаа нь Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй зөрчилдөж байна.

- Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтоох ёстой ч зохицуулах байгууллагын гаргасан, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй, хүчин төгөлдөр бус дүрэм, журмаар хязгаарлалт тогтоож байгаа нь цензур болон ашиглагдаж байна гэх зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн байна.

“Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт”²⁵ судалгаанаас харахад Монгол Улсад цахим орчин дахь худал мэдээ, мэдээлэл тараах, гүтгэх, доромжлох үйлдэл, түүнд

24 <http://nli.gov.mn/wp-content/uploads/2018/04/tsahim-orchim.pdf>

25 <http://nli.gov.mn/wp-content/uploads/2018/04/tsahim-orchim.pdf>

хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой байдлаар хуульчилсан байна гэж дүгнэж болох байна.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлд тусгаж өгсөн. Үүнд 26.1 - Цахим мэдээлэлд хууль бусаар халдах, 26.2 - Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах програм, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах, 26.2 - Хор хөнөөлт програм хангамж бүтээх, ашиглах, тараах)²⁶

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 оны гуравдугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дурдсанаар өмнөх оны мөн үеийн хэмжээнээс 18-аар буюу 2.5 дахин (2019 оны 3 дугаар сард – 16, 2020 оны 3 дугаар сард - 34) өссөн байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 57 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2018 он (42)-той харьцуулахад 15-аар буюу 35.7 хувиар өссөн байна.

Харилцаа холбооны зохицуулах газар болон Цагдаагийн байгууллагаас интернэт ашиглалт, олон нийтийн нийгмийн сүлжээг зохистой ашиглах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд хандсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернэтийн зохистой хэрэглээг хүүхэд, залуучууд, эцэг, эхчүүдэд сургах зорилгоор интернэт ашиглах зөвлөмж, зөвлөгөө өгөх, тусгай сайт (ekids.mn, <http://www.happywebs.mn/>)-ыг ажиллуулж байна.

Цагдаа, тагнуулын байгууллагаас хүүхдийг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь залилангийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн хэвлэл, мэдээллийн

хэрэгслээр ярилцлага өгөх²⁷, “Интернэт орчинд үйлдэгддэг гэмт хэргийн төрлүүд”-ийн талаар цуврал зөвлөмж²⁸ хүргэн ажиллаж байна.

Ийнхүү цахим орчин дахь аюулгүй байдлын талаар холбогдох эрх зүйн актад зохицуулалт оруулж, төрийн байгууллагуудаас олон нийтэд зориулсан урьдчилан сэргийлэх, танин мэдэхүйн шинж чанартай арга хэмжээ зохион байгуулж байгаа хэдий ч үр дүн, нөлөөллийг тооцсон судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байна.

Түүнчлэн Фэйсбүүк, Твиттер, Инстаграм зэрэг олон нийтийн сүлжээ ашиглан олон нийтийн санаа бодлыг зохион байгуулалттайгаар удирдах, санаа бодолд нөлөөлөх явдал ямар түвшинд байгааг тодорхойлсон судалгаа шинжилгээний ажил байхгүй байна.

Хэвлэлийн хүрээлэнгийн захирал М.Мөнхмандах²⁹ “Үй олноор самууруулах зэвсэг” нийтлэлдээ цахим нийгмийн сүлжээний талаар “Саяхан л хүмүүс шахмал түлшнээс айж, олны танил дуучин эрийн хар тамхины хэрэгт эгдүүцэж, тэтгэврийн зээлгүй хөгшдийг хөөрхийлж, ямааг өрөвдсөн дуучин эмэгтэйг муулж, Австралийн ард түмний төлөө залбирч суугаад хэдхэн долоо хоногийн дараа корона вирусийг “илрүүлж” өдөр бүр ямар нэг шинэ сенсацаар давалгаалж ирсэн” хэмээн дурдсан байна.

Хэдийгээр нарийн судалгаа хийгдээгүй ч цахим орчин дахь олон нийтийн санаа бодол хэрхэн хурдан хугацаанд өөрчлөгдөж, хувирдаг, эсхүл өөрчилж, хувиргаж болдгийг нотлох явдал 3 дугаар сард гарлаа. Монгол Улсад коронавируст халдварын анхны тохиолдол болсон франц иргэнд хандсан

26 <https://police.gov.mn/resource/information/File/2020/03/31/fu0192erqaaqecjpy/2020.03%20sar%20Burtgegdnsen%20gemt%20hereg.pdf>

27 <https://ikon.mn/n/1nww>

28 <http://ncsc.gov.mn/index.php?id=102>

29 <https://medium.com/@Pressinst/%D2%AF%D0%B9-%D0%BE%D0%BB%D0%BD%D0%BE%D0%BE%D1%80-%D1%81%D0%B0%D0%BC%D1%83%D1%83%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D0%B7%D1%8D%D0%B2%D1%81%D1%8D%D0%B3-05fe4f66d11>

цахим сэтгэгдлийн өнгө аяс ихэнхдээ сөрөг байсан хандлага 1-2 хоногийн дараа эрс өөрчлөгдөн эерэг хандлагаар солигдсон нь нийгмийн сүлжээ хэрхэн олон нийтийн санаа бодолд хурдацтай нөлөөлж буйг гэрчилж байна.

Дүгнэлт

Өнөөдрийн мэдээллийн эрин үед цахим орчин нь “мэдээллийн дайны талбар” болоод байна. Улс гүрэн, компани, хувь хүмүүс интернэт орчинд үзэл бодол, бараа, бүтээгдэхүүний сурталчилгаа түгээж олон нийтийн санаа бодолд нөлөөлж, удирдаж байна. Олон нийтийн санаа бодлыг өөрчлөх, санаа бодолд нөлөөлөх, удирдахын тулд төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглаж байна.

Монгол Улсын хувьд интернэт хэрэглэгчдийн тоо, нийгмийн сүлжээ ашиглагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Нийгмийн сүлжээ ашиглан аливаа зүйлийг нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх орон зай нэгэнт бүрдсэн байна.

Энэхүү цахим талбарт төрөл бүрийн гэмт хэрэг үйлдэх, залилан хийх, хүүхэд залуучуудыг садар самуунд уруу татах, худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох зүй бус үйлдэл гаргах явдал нэмэгджээ. Харин эдгээр асуудал нь зохион байгуулалттай явагдаж буй эсэх, дээр дурдсан арга хэрэгслүүдийг ашиглан явуулж буй эсэхэд хийсэн судалгаа одоогоор байхгүй байна. Иймд өнөөгийн эрх зүйн орчин болон бодит нөхцөл байдлын уялдаа холбоог тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх олон улсын жишигт хүргэх зэрэг ажлууд зайлшгүй шаардлагатай юм.

Нөгөө талаас олон нийтийн нийгмийн сүлжээ ашиглагчдын тоо жилээс жилд

өсөн нэмэгдэж, “...Манай томоохон гэгдэх өдөр тутмын бараг бүх сонин, телевиз, сайтууд “Хэн юу жиргэв” булантай, зарим нь жиргээнээс ишлэл авч мэдээнд ...”³⁰ оруулдаг, нийгмийн сүлжээнээс мэдээ, мэдээллийг аваад эх үүсвэрийг шалгалгүй түгээдэг асуудал маш түгээмэл болжээ.

Нийгмийн сүлжээ ашиглан тодорхой улсын сонгуульд нөлөөлж байгаа нь хэр хүчтэй зэвсэг болохыг нотолж байна. Манай улс дээрх арга хэрэгслийг өргөн ашигладаг хоёр улстай хиллэн оршдогийн дээр өөрийн үндэсний гэсэн нийгмийн сүлжээний платформ байхгүй, зөвхөн гаднын нийгмийн сүлжээний платформ дээр өөрсдийн бүх мэдээлэл, санал бодлоо дэлгэн тавьж байдаг нь өндөр эрсдэлийг агуулж байна.

30 <https://medium.com/@Pressinst/%D2%AF%D0%B9-%D0%BE%D0%BB%D0%BD%D0%BE%D0%BE%D1%80-%D1%81%D0%B0%D0%BC%D1%83%D1%83%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D0%B7%D1%8D%D0%B2%D1%81%D1%8D%D0%B3-f05fe4f66d11>

Хавсралт

Хүснэгт 1. Нийгмийн сүлжээгээр олон нийтийн санаа бодлыг өөрчлөх стратеги, хэрэгсэл, техник

Улсын нэр	Месэж		Харилцааны стратеги		
	Нийгмийн сүлжээний comment	Зорилтот бүлэг	Хуурамч мэдээлэл	Засгийн газрын цахим сайт, хаяг, аппликейшн	Агуулга бий болгох
Аргентин	+/-	Нотолгоо олдсон	Автомат	0	0
Австрали	+/-	0	Автомат	0	0
Азербейжан	+/-/n	Нотолгоо олдсон	Автомат	0	0
Бахрейн	-	Нотолгоо олдсон	Автомат, хүн	0	0
Бразил	+/n	Нотолгоо олдсон	Автомат, хүн, киборг	0	Нотолгоо олдсон
БНХАУ	+/-/n	+	Хүн	0	Нотолгоо олдсон
Чех Улс	n	0	0	0	0
Эквадор	+/-	Нотолгоо олдсон	Автомат, хүн	Нотолгоо олдсон	0
ХБНГУ	+/-	Нотолгоо олдсон	Автомат	Нотолгоо олдсон	Нотолгоо олдсон
Энэтхэг Улс	+/-	0	0	0	Нотолгоо олдсон
Иран	+/n	0	Автомат	0	Нотолгоо олдсон
Израиль	+	0	0	Нотолгоо олдсон	Нотолгоо олдсон
Мексик	+/-	Нотолгоо олдсон	Автомат, хүн, киборг	0	Нотолгоо олдсон
Хойд солонгос	+/-	0	Хүн	0	0
Польш	-	Нотолгоо олдсон	Хүн	0	0
Филипин	+/-	Нотолгоо олдсон	Автомат	0	0
ОХУ	+/-/n	Нотолгоо олдсон	Автомат, хүн,	0	Нотолгоо олдсон
Саудын Араб	+/n	0	Автомат	0	0
Серб	+/-	0	Хүн	0	0
БНСУ	+/-	Нотолгоо олдсон	Автомат, хүн	0	0
Сири	+	Нотолгоо олдсон	Автомат	0	0

Тайвань	+/-/п	Нотолгоо олдсон	Киборг, хүн	Нотолгоо олдсон	Нотолгоо олдсон
Турк	+/-	Нотолгоо олдсон	Автомат, хүн	Нотолгоо олдсон	
Англи		Нотолгоо олдсон	Хүн	Нотолгоо олдсон	Нотолгоо олдсон
Украин	+/-	0	Хүн	Нотолгоо олдсон	
АНУ	+/-/п	0	Автомат, хүн, киборг	0	Нотолгоо олдсон
Венесуэл	+	0	Автомат, хүн	Нотолгоо олдсон	0
Вьетнам	+	0	Хүн	0	Нотолгоо олдсон

Тайлбар: Автомат болон улс төрийн троллинг ажиллагаа

Нийгмийн сүлжээнд:

+ засгийн газрын эсхүл үндэсний үзэл бүхий comment

-Хүчирхийлэл, троллинг, хэрэглэгчидтэй сөрөг харилцаанд орох

п хэлэлцүүлгийн сэдвийг өөрчлөх, анхаарал сарниулах, мэдээлэл шалгах

0 мэдээлэл байхгүй

Хүснэгт 2. Цахим цэргийн чадавхи

	Улсын нэр	Байдал	Хүчин чадал, сургалт, зардал
Өндөр чадавхи	БНХАУ	Тогтмол	300,000-2,000,000 хүн ажилладаг
	Египет	Тогтмол	-
	Иран	Тогтмол	Нүүрномны зар сурталчилгаанд 6,000 ам.доллар
	Израиль	Тогтмол	400 хүнтэй, албан ёсны сургалт хийсэн тухай нотолгоо байгаа. 778,000-100 сая ам.доллар хүртэл гэрээ хийсэн
	Мьянмар	Тогтмол	ОХУ-д сургалт авсан тухай нотолгоо байгаа
	ОХУ	Тогтмол	-
	Саудын Араб	Тогтмол	Твиттерт ажиллахад 150 фунт стерлинг
	Сири	Тогтмол	4,000 ам.доллар гэрээнүүд
	АНЭУ	Тогтмол	1 сая ам доллар
	АНУ	Тогтмол, цаг үе	-
	Венесуэл	Тогтмол	500 хүн, албан ёсны сургалт авсан
	Вьетнам	Тогтмол, цаг үе	10.000 хүн

Дунд чадавхи	Азербейжан	Тогтмол	-
	Бахрейн	Тогтмол	32 сая ам.доллар гэрээнүүд
	Босни Герцоговин	Цаг үе	-
	Бразил	Цаг үе	12 сая гэрээнүүд
	Камбож	Тогтмол, цаг үе	-
	Куба	Тогтмол	-
	Этиоп	Тогтмол	БНХАУ-д сургалт авсан, цалин 300 ам.доллар сард
	Гүрж	Цаг үе	-
	Гватемал	Тогтмол	100.000 доллар гэрээнүүд
	Энэтхэг	Цаг үе	50-300 хүн, 1.4 сая ам.доллар гэрээнүүд
	Казахстан	Цаг үе	-
	Киргиз	Тогтмол, цаг үе	50 хүн, 2000 ам. доллараас эхлэн гэрээнүүд хийдэг, цалин 3-4 доллар өдөрт
	Малайз	Тогтмол	50-2000 хүн, албан ёсны сургалт авсан
	Мальти	Тогтмол	-
	Мексик	Цаг үе	-
	Пакистан	Тогтмол	-
	Филипин	Тогтмол	300-500
	Катар	Цаг үе	-
	Шри Ланк	Тогтмол, цаг үе	Энэтхэгт албан ёсны сургалт авсан тухай нотолгоо бий
	Судан	Тогтмол	-
	Тажик	Тогтмол	400 хүн
	Тайланд	Тогтмол	Албан ёсны сургалт авсан
	Турк	Тогтмол	500 хүн
Украин	Тогтмол	20000 хүн	
Англи	Цаг үе	3,5 сая фунт стерлинг	
Узбек	Тогтмол	-	

Доогуур чадавхи	Австри	Цаг үе	-
	Колумб	Цаг үе	-
	Чех	Цаг үе	-
	Эритрей	Тогтмол	-
	ХБНГУ	Цаг үе	-
	Гондурас	Цаг үе	-
	Унгар	Цаг үе	-
	Индонез	Цаг үе	1 сая-50 сая рупи хүртэл олон удаагийн гэрээ
	Итали	Цаг үе	-
	Кени	Цаг үе	6 сая ам долларын нэг удаагийн гэрээ Кэмбридж Аналитика ³¹ компанитай хийсэн
	Македон	Цаг үе	-
	Молдав	Цаг үе	Нүүрном, Инстаграмд 20000 ам.доллар зарцуулсан
	Нигер	Цаг үе	Кэмбридж Аналитика компанитай нэг удаагийн 2,8 сая ам доллар бүхий гэрээ хийсэн
	Хойд Солонгос	Тогтмол	200 хүн
	Польш	Цаг үе	-
	Руанда	Цаг үе	-
	Серби	Тогтмол	Сарын цалин 370 евро
	Өмнөд Африк	Цаг үе	2 сая ам доллар хүртэл олон удаагийн гэрээ хийсэн
Испани	Цаг үе	-	
Зимбабвэ	Цаг үе	-	
Бага чадахи	Ангол	Цаг үе	-
	Аргентин	Цаг үе	30-40 хүнтэй, 14 сая песо, 11 сая песо хүртэл гэрээнүүд 2015 онд хийсэн, 2017 онд 200 сая песогийн гэрээ
	Армен	Цаг үе	-
	Австрали	Цаг үе	-
	Хорват	Цаг үе	-
	Эквадор	Идэвхтэй бус	200.000 ам доллар хүртэл олон удаагийн гэрээ
	Грек	Цаг үе	-
	Нидерланд	Цаг үе	-
	БНСУ	Идэвхтэй бус	20 хүн
	Швед	Цаг үе	-
	Тайвань	Идэвхтэй бус	-
	Тунис	Цаг үе	-

31 Кембридж Аналитика (Cambridge Analytica) английн компани. Big data-тай – ажиллан 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Трампын ялалтанд нөлөөлсөн гэж үздэг. Тус компани нь нээлттэй бүхий эх сурвалжаас (үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, утасны лавлах, эрүүл мэндийн даатгал, үйлчилгээ гэх мэт) мэдээллийг худалдан авч нүүрномны лайк (Like) дарсан байдалтай харьцуулан тухайн нэг хэрэглэгчийн хүсэл, сонирхол, дургуй зүйл, айдас гэх мэт дүр зургийг гаргадаг. Нүүрномны хэрэглэгчийн 68 удаагийн лайк дарсан эсхүл репост хийсэн байдалд шинжилгээ хийснээр тухайн хэрэглэгчийн арьсны өнгө, дуртай зүйлс, оюуны хөгжил, шашин шүтлэг, архинд донтох байдал, хэрэглэгчийг насанд хүрээгүй байхад эцэг, эх нь салсан эсэх гэх мэтийг 95 хувийн магадлалтайгаар тогтоох боломжтой хэмээн тус компанийн захирал Никс дурдсан.

Ашигласан эх сурвалж:

- <https://www.bbc.com/russian/features-46117864>
- <https://www.theguardian.com/media/2017/may/02/google-and-Фэйсбүүк-bring-in-one-fifth-of-global-ad-revenue>
- <https://ro.uow.edu.au/cgi/viewcontent.cgi?referer=&httpsredir=1&article=2765&context=lhapapers>
- https://www.ideals.illinois.edu/bitstream/handle/2142/105420/South_Korean_Disinformation_Campaign__Political_Communication_Special_Issue.pdf?sequence=2&isAllowed=y
- <https://www.monitoringjournal.ru/index.php/monitoring/article/view/744/709>
- <https://medium.com/@Pressinst/%D2%AF%D0%B9-%D0%BE%D0%BB%D0%BD%D0%BE%D0%BE%D1%80-%D1%81%D0%B0%D0%BC%D1%83%D1%83%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D0%B7%D1%8D%D0%B2%D1%81%D1%8D%D0%B3-f05fe4f66d11>
- <https://point.md/ru/novosti/v-mire/v-Фэйсбүүк-zablokirovali-rossiiskoe-agentstvo-po-izucheniiu-interneta>
- https://www.gazeta.ru/tech/news/2018/04/04/n_11371442.shtml
- <https://lenta.ru/news/2019/02/22/reguliruem/>
- https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/811449/DCMS_REA_Online_trolling_.pdf
- https://www.business-standard.com/article/current-affairs/how-govts-across-the-world-use-cyber-troops-to-manipulate-public-opinion-117071900815_1.html
- <https://comprop.oii.ox.ac.uk/wp-content/uploads/sites/89/2017/07/Troops-Trolls-and-Troublemakers.pdf>
- <https://www.intel.com/content/dam/www/program/education/us/en/documents/intel-easy-steps/easy-steps-activity-surf-internet.pdf>
- <https://evolkov.net/moodle/mod/forum/discuss.php?d=219>
- <https://tass.ru/mezhdunarodnaya-panorama/5046957>
- https://www.gazeta.ru/tech/2017/01/27/10493867/social_botnetwork.shtml
- <https://www.spiegel.de/netzwelt/netzpolitik/donald-trump-und-die-daten-ingenieure-endlich-eine-erklaerung-mit-der-alles-sinn-ergibt-a-1124439.html#spRedirectedFrom=www&referrrer=https://t.co/XLkO9egVVe>
- https://ec.europa.eu/commission/presscorner/detail/ru/MEMO_18_6648
- <https://securingdemocracy.gmfus.org/hamilton-dashboard/>
- <https://www.theguardian.com/technology/2011/mar/17/us-spy-operation-social-networks>
- <https://www.unian.info/society/10862348-ukraine-launches-diia-app-opening-access-to-wide-range-of-gov-t-services-online.html>
- <https://www.wired.com/2007/08/ff-estonia/>



ЧОНО БОРООНООР БУЮУ АВЛИГА “ХОРООНОО”-ГООР...

АТГ-ын хэвлэлийн ажилтан Т.Мөнхтунгалаг

Монголд COVID-19-ийн 11 дэх тохиолдол илэрсэн тухай ЭМЯ-ны мэдээллийн дараа энэ нийтлэлийг бичив.

Дэлхийг хамарсан цар тахлын эсрэг улс орнуудын Засгийн газар, эрүүл мэндийн байгууллагууд бүхий л хүч чадлаа дайчлан ажиллаж байгаа өнөөгийн цаг үед хэрвээ (хэрвээ шүү!) авлига гарч ирвэл хүн төрөлхтний хамаг хүчин чармайлт үгүй болно хэмээн даян дэлхийн авлигын эсрэг хөдөлгөөн-“Транспэрэнси интернэшнл” сануулж байна.

Ердийн үед дэлхий нийтийн хэмжээнд эрүүл мэндийн салбар дахь авлигын хэмжээ жилдээ 500 тэрбум ам.долларт хүрдэг талаар 2019 оны судалгааны эмхэтгэлд бичсэн нь бий. Тэгвэл нийтийг хамарсан хямрал буюу онцгой цаг үед хяналт суларч авлига нэмэгддэг нь бодит явдал бөгөөд бид өнгөрсөн түүх, туршлага, сургамжаас суралцах хэрэгтэй.

2014-2016 онд эбола вирусийг тогтоон барихаар оролдож байсан үйл явц нь авлигатай тэмцэх үйл хэрэгт гашуун сургамж болжээ. Гвиней, Сиерра-Леон дахь эболагийн тархалтын үеэр зургаан сая ам.долларыг авлигад төлсөн талаар олон улсын Улаан

загалмайн нийгэмлэгээс мэдээлж байв. Эбола вирусний үед хөрөнгө завших, урвуулан ашиглах, цалингийн тайланг буруу гаргах, давхар санхүүжилт хийх, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хахууль өгөх, хорионы бүсийг давах зэрэг зөрчлүүд гарч байв.

Тэгвэл Английн анагаах ухааны сэтгүүлийн мэдээлэлд дурдсанаар 2009-2010 оны гахайн ханиадны дэгдэлтийн үеэр “Тамифлю” эмийг зөвлөж байснаас үүдэн уг эмэнд дэлхийн хэмжээнд зарцуулсан хөрөнгө 18 тэрбум ам.долларт хүрчээ. Гэтэл дөрвөн жилийн клиник туршилтын мэдээлэлд хийсэн үнэлгээгээр Швейцарийн эм үйлдвэрлэгч “Роше” компанийн “Тамифлю” эмэнд парацетомолоос илүү нөлөө байхгүйг тогтоосон байдаг. Харин SARS өвчний 2003 оны дэгдэлтийн үеэр эрүүл мэндийн салбар дахь ирээдүйд үүсэж болох онцгой байдлыг зохицуулах, уялдааг хангах үндэсний удирдлагын төвийг Тайваньд байгуулж, ингэснээр ил тод байдлыг нэмэгдүүлэн, шинэ технологийг ашиглаж урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажиллаж байгаа нь нэгэн сайн туршлага болоод байна. Баруун Африк дахь эбола болон Ази дахь SARS өвчний дараа нэмэлт хөрөнгө гаргаж, хяналтыг

чангатгаснаар эрүүл мэндийн салбарын дэд бүтэц сайжирсан байна.

Өнөөдрийн байдлаар дэлхийн хэмжээнд 200 улс, бүс нутагт COVID-19 цар тахалтай нүүр тулан тэмцэж байна. 462 мянга гаруй хүн өвчилж, 20 мянга гаруй хүн нас барсан. Цаашид энэ тоо өдөр тутам өсөх хандлагатай байна. Эрүүл мэндийн үйлчилгээ хүссэн иргэд огцом олширсоор байгаа энэ цаг үед тухайн улс орны эрүүл мэндийн салбар нь тийм ч тогтвортой биш бол нуран унахад ойрхон байна. Ихэнх улс орон эмнэлгийн мэргэжилтнүүдээр дутмаг байгаа бөгөөд тэдэнд оношлох, эмчлэх боломж хязгаарлагдмал байна. Дэлхий нийтийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ муудаж байна. БНХАУ, Энэтхэг болон бусад улсын эм үйлдвэрлэгч компаниуд жороор олгодог эм, бусад эмэнд ордог бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ бууруулж байна. Эрдэмтэд, судлаачид COVID-19-ийн эсрэг вакцин гаргаж авах өрсөлдөөнийг эхлүүлээд байна.

Авлига хаана үүсэх вэ?

Дэлхийн эрүүл мэндийн салбарт өмнө нь тухайлбал, эбола вирус, гахайн ханиадны үеэр хүний зовлонгоор ашиг хонжоо ологчид гарч ирсэн энэ мэт эрсдэлийг урьдчилан тодорхойлох нь эрүүл мэндийн тусламж нэн шаардлагатай одоо цаг үед улс орнуудын авч хэрэгжүүлж буй хүчин чармайлтад томоохон дэмжлэг болно. Тиймээс одоогоор үүсээд байгаа нөхцөл байдлаас улбаалж авлигын дараах эрсдэлүүд үүсэж мэдэхээр байна. Тухайлбал,

Эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд болон эмнэлгийн ор, эм, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр дутаж байна. Эмнэлгийн албан хаагчид хэнийг түрүүлж эмчлэх вэ, хэн нь илүү хүнд байна

вэ гэдгийг тодорхойлох хэцүү сонголттой тулгарч байна. Энэ нь хээл хахуулийн орчинг аандаа бий болгох эрсдэлтэй. Европын холбооны иргэдийн 29 хувь, Африк, Ойрхи Дорнод, Хойд Африкийн улсуудад 14 хувь, Латин Америк болон Карибын тэнгисийн бүс нутагт 10 хувь нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахын тулд хээл хахууль өгдөг байна. Үүний эсрэг талд төлбөрийн чадваргүй, эмзэг давхаргын хүмүүс амь нас, эрүүл мэндээрээ хохирч үлдэж болзошгүй.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ муудсанаас шалтгаалж худалдан авахаас өөр ямар ч сонголтгүй болсон Засгийн газруудаас нийлүүлэгч компаниуд үнэ өртгөө дураар нэмэн мөнгө нэхэх эрсдэл үүсэхээр байна.

Цар тахлын эсрэг вакцин гаргаж авах өрсөлдөөнд Засгийн газрууд ихээхэн хөрөнгө оруулж байна. Тухайлбал, АНУ гэхэд халдвар тахлыг судлахад 2002 оноос 700 сая ам.долларыг зарцуулаад байгаа. Саяхан Англи коронавирусыг судлахад 20 сая фунт стерлинг амласан бол Европын холбоо энэ чиглэлээр төсвөө 47.5 сая евро болгож өсгөжээ.

Засгийн газар юу хийх ёстой вэ?

“Транспэрэнси интернэшнл” байгууллага нь амин чухал эм тариа, вакцины худалдан авалтыг сайжруулах, гэрээ, хэлцлийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөрөгдөлтөөс урьдчилан сэргийлэх, цаг тухай бүрт нь шаардлагатай байгаа эмийн талаарх мэдээлэл солилцож байх талаар улс орнуудын Засгийн газарт дараах уриалгыг хүргэж байна.

Юуны түрүүнд эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг нээлттэй, ил тод байлгаснаар авлигын эрсдэлийг бууруулах боломжтой. Эрүүл

мэндийн салбарт эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт угаасаа авлигын өндөр эрсдэлтэй байдаг. Ердийн үед дэлхийн хэмжээнд худалдан авалтын 10-25 хувь нь авлигад хулгайлагддаг болохыг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба тооцоолон гаргасан. Тэгвэл Европын холбооны эрүүл мэндийн салбарт үйлдэгдсэн авлигын хэргийн 28 хувь нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалттай холбоотой байв.

Үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлэх ёстой. Үүний тулд зарим улс орны сайн туршлагыг хэрэгжүүлж болох юм. Тухайлбал, Энэтхэгт жижиглэнгийн үнээс дээш үнээр борлуулж буй бараа, бүтээгдэхүүний талаар мэдээлэл хүлээн авах тусгай үтсыг ажиллуулж байна. Түүнчлэн “Amazon” цахим худалдааны компанийн зүгээс COVID-19-ийг эмчилдэг, хамгаалдаг гэх хуурамч бүтээгдэхүүний жагсаалтыг интернэтэд тухай бүрийд устгаж байна.

Онцгой нөхцөл байдлын үед тусламж үзүүлэх, хуваарилах зорилгоор нэмэгдүүлсэн нөөцийг авлигачид завшихаас сэргийлж мөнгөний урсгалд мониторинг хийж, хөрөнгийг хянаж байх шаардлагатай.

Анагаах ухааны судалгаа, боловсрол, үйлчилгээнд санхүүгийн ашиг сонирхол, хувийн нөлөөлөл нэлээд байдаг нь нууц биш. Германы “CureVac” компанийн вирусний эсрэг вакцин гаргахаар ажиллаж буй судлаачдад ихээхэн хэмжээний мөнгө амласан талаарх мэдээлэл гарч байгаа нь дэлхийн бусад улс орнуудад сөрөг үлгэр дуурайл болж буй. Тиймээс цар тахлын эсрэг

гаргаж авах вакцин, эмийн үйлдвэрлэл нь хувийн компаниуд ба улс орнуудын нууц өрсөлдөөний талбар байх ёсгүй. Энэ нь ил тод бөгөөд тэдний хамтын ажил байх ёстой юм.

Мэдээллийн ил тод байдлыг хангах нь Засгийн газрын үүрэг гэж ТИ зөвлөж байна. Өөрөөр хэлбэл, хуурамч мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэх, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд дэх хээл хахуулийн эрсдэлийг бууруулахын тулд шүгэл үлээж байгаа мэдээлэгчийг хамгаалах талаар арга хэмжээ авах нь чухал хэмээн онцлов.

COVID-19 цар тахал үргэлжлэн тархаж буй энэ цаг үед эрүүл мэндийн салбарын эмзэг асуудлыг нээлттэй хэлэлцэж байхыг ТИ уриаллаа. Эцсийн дүндээ олон нийтийн эрх ашгийн төлөө зөв шийдвэр гаргахын тулд том бизнесийн болон хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах ёстой. Улс төрийн болон бизнесийн эрх ашиг бус зөвхөн олон нийтийн эрүүл мэнд нэгдүгээрт тавигдах ёстой хэмээн ТИ онцлон тэмдэглэлээ.

Манай монголчууд “Чоно борооноор” хэмээн хэлцдэг. Энэ нь чоно бороо орох үеэр далимдуулан хоттой хонь эргэж байдаг буюу муу хүн үргэлж сиймхийг харж хөдөлдөг гэсэн утга юм. Тиймээс иргэдийн хувьд эрүүл мэндийн сонор сэрэмжээ эрс нэмэгдүүлсээр байгаа энэ онцгой цаг үед авлигын эсрэг хараа хяналтаа ч бас алдахгүй байх хэрэгтэй юм.

**АТГ-ын США-наас орчуулж
бэлтгэсэн “Corruption and the
Coronavirus” нийтлэлийг эх
сурвалж болгов.**




“ТӨРИЙН АЛБАН ХААГЧ АВЛИГЫН МӨНГӨӨ ОЛОН ХҮН ЦУГЛАСАН ГАЗАР УУЛЗАЖ, БЭЛНЭЭР АВДАГ ЮМ БИЛЭЭ”

Сэтгүүлч Н.Пунцагболд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, авлигын асуудалд хандах хандлага, авлигатай холбоотойгоор гарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, цаашид авлигыг бууруулах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэхэд ашиглах санал, зөвлөмж дэвшүүлэх зорилгоор АТГ-аас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа”-г хийжээ. Гэхдээ Улаанбаатар хотод амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй


иргэдийг хамруулсан юм байна. 2019 оны нэгдүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод 18 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй нийт 35580 гаруй иргэн амьдардаг аж. Түүнээс 355 иргэнийг судалгаанд хамруулжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 75 хувь нь манай улсад авлига нийтлэг үзэгдэл болсон гэж хариулсан байна. Харин авлигаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд илүү хохирдог гэж 67 хувь нь хариулжээ.



Судалгаанд оролцогчдын 75.1 хувь нь эрүүл мэндийн салбар, 70.7 хувь нь боловсролын салбарт авлига “маш их, нэлээд хэмжээнд, тодорхой хэмжээнд” байдаг хэмээн хариулсан байна. Үүнээс харвал эрүүл мэнд, боловсролын салбар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “хамгийн ээлгүй” салбар гэж хэлж болохоор

байна. Судалгаанд оролцогчдоос авлигын түвшин сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх байр суурийг нь сонирхож үзэхэд 43.9 хувь нь өссөн, 15.3 хувь нь буурсан, 26.5 хувь нь өөрчлөгдөөгүй, 14.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График 5. Авлигад хамгийн өртөмтгий салбар



Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх гэсэн асуултад “Тийм” гэж хариулсан оролцогчдоос “Хэнд авлига өгсөн бэ?” гэсэн асуултад 51.4 хувь нь эмчид, 12.9 хувь нь багшид, 7.1 хувь нь шүүгчид гэж хариулжээ. Түүнчлэн хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн 58.6 хувь нь бэлэн мөнгө өгсөн аж. Авлигаас үүдэлтэй дарамт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхийн төсөвт их хэмжээгээр нөлөөлдөг гэж 27.1 хувь, дунд болон бага зэрэг нөлөөлсөн гэж 58.6 хувь нь хариулсан байна. Судалгааны дүнгээс товч танилцуулахад ийм байна. Харин судалгаанд оролцсон иргэд авлигад яаж өртөж байсан талаараа ярьсан бодит жишээнүүдийг хүргэе.

Жишээ 1

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн хувьд эцэг, эхчүүдийн нэг нь ажил

хийхгүй хүүхдээ асрах шаардлагатай болдог. Тийм гэр бүлийн орлого шууд буурдаг хэрнээ хүүхдийнхээ эм тариа, эмчилгээ сувилгаанд зарцуулах зардал нэмэгддэг. Тэгэхээр тухайн гэр бүлд хүүхдэд төрөөс өгч буй халамжийн мөнгө, хөнгөлөлт ямар чухал гэдгийг харуулж байна. Гэхдээ халамж нь тийм их мөнгө биш шүү дээ. Хүүхдийнхээ эм тариаг ч авч хүрэхгүй. Тэр мөнгийг авахын тулд хорооны эмч, халамжийн мэргэжилтнүүдтэй харилцдаг. Миний хувьд эмчийн зөвлөлийн хурлаар орох гээд материалаа өгсөн чинь хурал болох болоогүй, хойшилсон гээд удаад байхаар нь эмчдээ цайны мөнгө өгч байсан. Уг нь миний хүүхдийн нөхцөл байдлыг харвал хурдан шийдээд өгчихмөөр л байгаа юм.

(Ганцаарчилсан ярилцлагаас. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ээж, 27 настай)

Жишээ 2

Эмнэлэгт очоод үзүүлэхээс авахуулаад хагалгаанд орох ч юмуу, энгийн үйлчилгээ авахад заавал гар хараад байдаг. “Яасан юм, зүгээр байна, яах гээд байгаа юм” гээд бичиг бичээд гаргаад хаячихна. Эмчилгээ, бичиг заалтыг нь үзүүлсэн үзлэгт орохоор “Чи үнэтэй эм авч чадах уу. Антибиотик авах уу” гээд антибиотик бичнэ. Үнэтэй эм авч чадах уу гэдэг асуултыг байнга асуудаг. Ингэж асууж байгаа нь ялгаварлан гадуурхалт. Тэр эмч ингэж асууна гэдэг маш бүдүүлэг байхгүй юу. Хүний эрхийг гажуудуулсан доромжлол. Хямдхан эм бичих үү, үнэтэй эм бичих үү гэж асууж байгаа юм шиг. Сонсголгүй хүнд эмчийн үзлэг хийхдээ үзэхгүйгээр шууд гаднаас нь хараад тэгээд дур мэдэн эмийн жор бичиж өгдөг.

(Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Жишээ 3

Манай охин өвдөөд гэнэт халуураад хүндэрсэн. Тэгэхэд би жирэмсэн, даралт ихсээд, утсаар ярьж чадахгүй байсан. 103 руу ярихыг мэдээд байгаа ч аав нь бас сонсголгүй, охин өвдсөн байсан. Тэгээд 103 руу охин маань ярьсан чинь хүүхдийн дуудлага хүлээж авахгүй, том хүнээр яриул гэхэд манай нөхөр хэлгүй, би сонсголгүй яаж ярихав. Тэгээд гар утасны тусламжтайгаар видео калл хийж би найз руугаа яриад, найз маань 103 руу холбогдсоноос цаг алдаж, түргэн шуурхай эмнэлгийн тусламж, үйлчилгээг авч чадаагүй.

(Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Жишээ 4

Хүүхдийнхээ багшид нэгж, заримдаа ангийн хуримтлалын мөнгийг хураалгахдаа яаж ийгээд илүү өгдөг. Хэрвээ ингэж өгөхгүй бол аав нь харааны бэрхшээлтэй гээд хүүхдийг маань ангийн багш нь ялгаварлан гадуурхдаг, ангиараа салхинд гарах зэрэг зарим олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй үлдээчихсэн байдаг. Гэтэл миний хүүхэд ямар буруутай юм? Багш хүн эцэг, эхийнх нь хөгжлийн бэрхшээлээс болж хүүхдийг нь ялгаж харьцах ёсгүй биз дээ.

(Харааны бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас. Харааны бэрхшээлтэй, эрэгтэй, 39 настай)

Жишээ 5

Миний дээд сургуульд сурах сургалтын төлбөрийг буцалтгүй тусламжаар бүрэн төлнө гэсний дагуу сургуульд элсэн суралцсан. Гэтэл гэнэт сургалтын алба мөнгөгүй байна, төлбөр мөнгөө өг гэсэн. Тэгээд байсхийгээд л ийм ч мөнгө аваад ир, тийм ч мөнгө аваад ир гээд нэхдэг. Би дохионы хэлний орчуулагчаар дамжуулаад асуухаар ерөөсөө нарийн мэдээлэл авч чаддаггүй. Тэгсэн хэрнээ юунд зарцуулагдаж байгаа нь мэдэгдэхгүй мөнгө аваад байдаг. Би англи хэлд өөрөө дуртай мөртлөө даанч дохионы орчуулаггүй болохоор би ойлгодоггүй, багш нь ч энийг мэдэхийг хүсдэггүй. Бас тэгээд хамгийн арын ширээнд суудаг.

(Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй хийсэн Фокус бүлгийн ярилцлагаас)

Жишээ 6

Хэдэн жилийн өмнө дүүргийн халамжийн мэргэжилтэн над руу яриад, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлд материалаа бүрдүүлээд өгөөдөх

гэсэн. Маш богино хугацаанд хэлсэн материалыг нь бүрдүүлээд өгсөн чинь нэг сая төгрөг авсан. Тэр мэргэжилтэн миний материалыг бүтээж өгснийхөө шанд тэр мөнгөний талыг нь авч байсан. Тухайн үед юу болоод байгааг сайн ойлгоогүй, тэгээд л өнгөрсөн. Сүүлд бодохнээ тэр хүн намайг ашиглаж мөнгө авсан байгаа юм. Гэтэл тэр хүн ажлаа хийж байгаа хүн байж тэгж авлига авч, мөнгө завшиж болохгүй гэдгийг ойлгосон. Одоо ч гэсэн тэр зээлийг авч байгаа хүмүүс тэр хүндээ хувь өгдөг юм билээ.

*(Ганцаарчилсан ярилцлагаас.
Хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэй, 43
настай)*

Жишээ 7

... Манай байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэд эвлэлдэн нэгдсэн байгууллага л даа. Төрийн байгууллагаас зарласан тендерт оролцоод шалгарч байсан. Тухайн тендерийн мөнгө нь тийм их биш, бид үйл ажиллагааны зардалдаа зарцуулаад л дууссан. Гэтэл эргээд нөгөө тендэр авсан байгууллагаас биднийг байнга дарамталж, шаналгах болсон. Энд тендерийн мөнгөнөөс тухайн хүмүүст мөнгө эсвэл хувь өгөх зүйл яригдаагүй байна. Юу гэхээр мөнгөн бус хэлбэрээр авлигын хэлбэр явагддаг. “Манайхаас явуулж байгаа хүмүүнлэгийн аянд танайхаас хандив хэрэгтэй байна, шинэ жилээр ч юм уу янз бүрийн баяруудаар хүмүүс шагнах гэсэн юм, шагналд хувь оруулаач, шинэ жил зохион байгуулах гэсэн чинь зардал дутаад байна” гэх зэргээр эргээд тэр байгууллагаасаа бид хараат болчихдог.

*(Ганцаарчилсан ярилцлагаас.
Хөдөлгөөний бэрхшээлтэй эрэгтэй, 36
настай)*

Жишээ 8

Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд маш олон байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг болсон. Төрийн байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, тэднээр хийлгэх гэсэн олон тендерүүд зарлагддаг болчихсон. Тэгээд тэр тендерүүдэд оролцоход тендер хариуцсан ажилтнууд нь биднээс “тендерийн тодорхой хувийг аваад танайхыг шалгаруулаад өгье” гээд наймаалцаж байсан. Хэдэн төгрөг, хэдэн хувийг тэр хүнд өгөх вэ гэдэг нь тухайн тендерийн нийт үнийн дүнгээс хамаараад 10-15 хувь байсан. Тэр хувь өгч байгаа мөнгийг төрийн албан хаагч өөрийнхөө дансаар авдаггүй, олон хүн цугласан газар уулзаж бэлнээр авдаг юм байна лээ. Миний оролцсон тендерийн хувьд төдийлөн түршлагагүй, яадгийг нь мэдэхгүй байсан учраас тухайн үедээ тендерээ авахын тулд тухайн нэхсэн мөнгийг өгч байсан.

*(Ганцаарчилсан ярилцлагаас.
Сонсголын бэрхшээлтэй эмэгтэй, 45
настай)*



АВЛИГЫН КРИМИНОЛОГИ

*“Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоог
бэхжүүлэх нь” төслийн зохицуулагч А.Амармэнд*

Авлигын криминологи: Онолын чиг хандлага номын тухай

Аливаа нийгмийн асуудлын мөн чанарыг үнэн зөв, ул суурьтай ойлгох нь уг асуудлыг үр дүнтэйгээр, эцэслэн шийдвэрлэх чухал нөхцөл болох нь хэн бүхэнд тодорхой болов уу. Монгол Улсад авлигатай тэмцэх үйл ажиллагаанд ч мөн ялгаагүй юм. Авлигын талаар монгол хэлээр олон бүтээл байдаг боловч авлигыг гэмт хэрэг судлал талаас буюу криминологийн үүднээс авч үзсэн бүтээл ховор байна. Иймд сүүлийн үеийн, шинэлэг судалгаа, шинжилгээний ололтыг тусгасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чанартай бүтээлийг олон нийтийн хүртээл болгохыг зорьж, орчуулах номыг эрж хайсаар АТГ-ын албан хаагчидтай зөвшилцөн Их Британийн Баруун Лондонгийн их сургуулийн профессор Грахам Брүүксийн “Criminology of Corruption, Theoretical Approaches” номыг сонгон орчуулахаар болж Та бүхэнд эхний бүлгийг толилуулж байна.

Уг зохиогч нь авлига, криминологи, хууран мэхлэх гэмт хэрэг зэрэг сэдвээр олон бүтээл туурвиж, шинжлэх ухааны

сэтгүүлд олон нийтлэлээ хэвлүүлсэн бөгөөд БНСУ, Тайван, Кипр, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсын эрдэмтэдтэй авлигын талаар хамтран ажилласан туршлагатай ажээ. Тухайлбал БНСУ-ын Цагдаагийн байгууллагыг шинэчлэх тусгай зөвлөхөөр 2017 оноос эхлэн ажиллаж буй ажээ. Мөн орчуулан хүргэж буй бүтээлийг хэвлэн гаргасан Palgrave Macmillan компани нь академик буюу судалгаа шинжилгээний чиглэлийн чанартай бүтээлийг голчлон хэвлэдэг нэр хүндтэй компани юм. Орчуулагч миний хувьд уг бүтээлийг шинжлэх ухааны бүтээл болохын хувьд аль болох эх текстийн өгүүлбэрийн бүтэц, үг хэллэгийг нэгэн жигдээр хадгалан орчуулахыг хичээсэн болно.

Зарим нэр томьёо, шаардлагатай гэж үзсэн зарим зүйлд тайлбар нэмж оруулсан боловч орчуулах явцад оновчгүй нэр томьёо ашигласан, алдаа мадаг гаргасан байж болзошгүй тул мэргэн уншигчид та бүхэн хэрхэн засаж залруулбал зохилтой талаар саналаа amaraa18@gmail.com хаягаар ирүүлнэ үү.

АВЛИГЫН КРИМИНОЛОГИ Онолын чиг хандлага

Нэгдүгээр бүлэг. Оршил

Социологийн болон криминологийн холбогдох онолын арга хэрэгслүүдийг авлигын асуудал дээр ашигласанд энэ номын учир утга оршино. Энэхүү номыг бичих санааг Хьюсман ба Ванде Валле нарын 2010 оны ижил нэртэй бичлэгээс авсан бөгөөд социологийн ба криминологийн мэдлэгтэй ч авлигын талаар тийм сайн мэдэхгүй хүнд, эсхүл авлигын талаар мэдлэгтэй ч социологийн ба криминологийн мэдлэггүй тийм хүмүүст хэрэг болох ном бичихийг зорьсон болно. Авлигын талаар тайлбарласан ихэнх онолын урсгал нь социологи болон криминологийг бага зэрэг ашиглах ч улс төрийн ба эдийн засгийн шинжлэх ухааны салбарт багтдаг. Энэ номоор энэ талыг нөхөхийг оролдлоо. Энэ бол авлигын талаарх бүтээлүүдийг шүүмжилж буй хэрэг бус харин олон улсын авлигын талаарх хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулж буй хэрэг юм. Тиймээс энэ ном авлигын талаарх бүтээлд ашиглагдаж буй онолын арга хэрэгслийг өргөтгөж, хувь хүн, байгууллага, улс орнууд яагаад, бас яаж авлигажсан үйлдэл хийдэг вэ гэдэг хэлэлцүүлгийн хүрээг тэлнэ. Улс төрийн шинжлэх ухаан ба эдийн засгийн онолд авлигыг хэмжих, түүнээс урьдчилан сэргийлэх тал дээр төвлөрч, гэмт хэрэгтнүүдийг ихэвчлэн рационал тоглогч гэж үздэг. Энэ нь рационал сонголт (Wilson, Herrnstein 1985)¹ ба давтагдах үйлдлийн (Cohen, Felson 1979) талаарх криминологийн арга хэрэгслийг дуурайсан байдаг. Гэвч авлигын болон криминологийн талаарх бүтээлийн аль алинд оролцогчдын үйл хөдлөлийг

рационал бөгөөд өөрийн эрх ашгаа харсан гэж үздэг учир хувь хүн, байгууллага яагаад авлигын эсрэг байдаг тал дээр төвлөрдөггүй. Рационал криминологийн чиглэлийн ба авлигын талаарх бүтээлд процесс болон бүтцийг өөрчлөн авлига авах боломж, бололцооноос сэргийлэх замаар авлигын үйлдэл гаргахад хэцүү болгоход анхаардаг.

Харин социологи ба криминологид “шийтгэл” нь авлигаас сэргийлэхэд хамаагүй чухал үүрэг гүйцэтгэх талаар илүү нарийн өнгө аястай тайлбар хийдэг бөгөөд гэмт үйлдлийн талаар хүмүүс бусадтай харилцах процессоор болон юуг хууль зөрчсөн үйлдэл гэх вэ гэдэг тодорхойлолтоос ажиглаж (Sutherland 1939) суралцдаг гэдгийг тодотгодог. Түүнчлэн “амжилт”-ыг баялаг хуримтлуулах явдал гэж тодорхойлох үед хууль ёсоор амжилтад хүрч чадахгүй хүн хууль бус үйлдэл гаргаснаа (Merton 1938) саармагжуулах арга хэрэгслээр өөрийгөө зөвтгөн (Sykes, Matza 1957), гэмт хэргийн замд нэг орж, нэг гарч байдаг (Matza 1964). “Бусдад” авлигач гэсэн нэр хаяг зүүх эрх мэдэлтнүүд (Becker 1963; Erickson 1966) өөрсдөө авлигажсан байдаг капитализмд авлига бол зайлшгүй гэж үзэх үзлийн (Dahrendorf 1958; Turk 1969; Quinney 1969; Chambliss 1975) зэрэгцээ хүмүүс яагаад авлигаас ангид байж, авлигын үйлдлийг гаргах сэдлийг эсэргүүцдэг талаарх тайлбар ч байдаг. Энэ номдоо зохиогч миний бие “анхдагч” онолын тайлбарыг ихэвчлэн ашиглах боловч шаардлагатай тохиолдолд холбогдох орчин үеийн бүтээлийг ашиглах болно. Үүний шалтгаан нь

¹ Зохиогч тухайн асуудлаар цаашид дэлгэрүүлж унших боломжтой бүтээлийн эшлэлийг өгүүлбэр дунд хаалтан дотор бичсэн байсныг хэвээр үлдээв. Ашигласан материал хэсгээс ямар бүтээл болохыг дэлгэрүүлж харна уу. Ном, бүтээлийн нэрийг хайхад хялбар байх үүднээс бүтээлийн нэрийг орчуулаагүй болно.

социологийн болон криминологийн онолын чиг хандлага нь “анхдагч” эх үүсвэрийг ашиглах боломжтой болох ба уг хандлага үр өгөөжтэй эсэхийг бусдын тайлбарт найдалгүйгээр өөрөө үнэлэх боломжтой болно.

Онол боловсруулахыг ихэвчлэн “хий дэмий бодол болсон” хэрэг гээд тоодоггүй боловч онол нь бид гэмт хэрэгтнүүдтэй яаж харьцах, яаж шийтгэх, урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг (Lilly г.м 1989). Гэмт хэргийн шүүхийн бодлогыг товчхон шүүгээд үзэхэд ямар хууль, арга хэрэгслийг хэрэгжүүлж байгаад онолын чиг хандлага нөлөөлснөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол бүтцийг бүрдүүлж байгааг харж болно. Түүнээс гадна авлига нь ёс зүйгүй ч хууль ёсны үйлдлээс ноцтой хууль бус үйлдэл хүртэл өргөн хүрээг хамардаг учир түүнийг нийтлэг хэм хэмжээнээс гажсан ба/эсхүл гэмт үйлдэл гэж үзэж болно. Энэ тохиолдолд ялангуяа социологи болон криминологи хэрэг болдог бөгөөд эдгээрийн талаар хязгаарлагдмал мэдлэгтэй хүмүүс энэ номын цар хүрээнээс хэтэрсэн онолын дүн шинжилгээ бүхий олон бүтээлтэй танилцаж болно (Tierney, O’Neill 2009; Hagan 2012; Siegal 2012; Treadwell 2012; Hopkins-Burke 2013; McLaughlin, Newburn 2013; Vito, Maahs 2015). Социологи болон криминологийн аль аль нь нийтлэг хэм хэмжээнээс гажих үйлдэл, дүрэм зөрчих, ёс зүйг зөрчих үйлдэл, гэмт хэргийн үйлдлийг тайлбарлаж ирсэн түүхтэй ба энэ ном нь ихэвчлэн улс төр, эдийн засгийн ухааны талаас хүмүүс яагаад авлига авдаг ба түүнээс яаж сэргийлэх талаарх өнөөгийн тайлбараас илүү өргөн хүрээг хамарна. Хүмүүс авлигын болон гэмт үйлдэл яагаад гаргадаг талаарх эрэл хайгуул нь нийгмээс тусгаарлагдсан орчинд хийгдээгүй, харин ч өөрчлөгдөн буй нийгмийн нэг хэсэг юм. Авлига яагаад гарч

байгааг ойлгох нь түүнийг хянаж, түүнээс урьдчилан сэргийлэх урьдач нөхцөл болно. Онолын чиг хандлага гэмт хэргээс урьдчилан сэргийлж бууруулах бодлогын өөрчлөлт, эсхүл бодлогын өөрчлөлтийг дагалдан түүнийг зөвтгөх, тайлбарлах түвшин хүртэл хөгжсөн (Lilly г.м 1989). Онолын чиг хандлага ихэвчлэн хувь хүний хариуцлага ба сайн сайхан байдалтай холбогддог авлигын хяналтын (Garland 2001) болон урьдчилан сэргийлэх (Clarke 1980; O’Malley 1992; Clarke 1997; Farrington г.м 2003; Grawford 2009) арга хэрэгслийг хууль ёсны болгох процессыг туулдаг гэвч цаг хугацааны эрхээр тэдгээр нь нийгэм, улс төрийн нөхцөл байдалд илүү тохирсон “шинэ” чиг хандлагад дарагдаж байна. Бодлогыг өөрчилж, эсхүл хэвээр хадгалж буй онолын тайлбар дахь өөрчлөлт нь улс төр, нийгмийн өөрчлөлт, түүнээс үүдсэн гэмт хэрэгтнийг харах өнцөг өөрчлөгдсөнөөс үүдэн гардаг. Гэхдээ өмнөх чиг хандлага зүгээр алга болчихолгүй, түүний элемент нь боловсруулагдсан шинэ чиг хандлагын хэсэг болж үлддэг. Энэ номд авлигын үйлдлийг тайлбарлахад дөхөм болох хамгийн хамаарал бүхий онолын чиг хандлагын хөгжлийг харуулна. Цагаан захтны гэмт хэрэг болон эрх мэдэлтнүүдийн гэмт хэрэг дээр төвлөрсөн ялгаатай нөхөрлөлийн онолоос (Sutherland 1939) гадна зөрчлийн талаарх бүтээлүүдэд (Dahrendorf 1958; Turk 1969; Quinney 1969) эдгээр анхдагч социологи, криминологийн онолын чиг хандлагад авлигын талаар дурдагдах нь ховор байсан ба ихэвчлэн гудамжны гэмт хэрэгт төвлөрч байсан. Эдгээр анхдагч тайлбарын хувилбарууд (Agnew 1992; Agnew, White 1992) нь харин гудамжны гэмт хэргийн хүрээнээс хальж авлигын талаарх хэлэлцүүлэгт социологи ба криминологийн оруулах хувь нэмрийг

харуулсан. Авлигыг онолын тогтолцоон дунд авч үзэхэд салбар дамнасан ба/эсхүл улсын хил дамнасан хүрээнд асуудлыг олон улсын түвшинд ойлгох хэрэгтэй болно.

Номоо эхлэхээс өмнө тодруулах хэдэн зүйл бичье. Үргэлж биш ч ихэнх тохиолдолд энэ номд корпорацаас илүү байгууллагыг заалаа, яагаад гэвэл авлига нь корпорацад хамаарах зүйл бус улс орон, ТББ болон бүхий л төрлийн байгууллагад болдог зүйл юм. Хамгийн жигшмээр авлигын үйлдлийг авлигажсан төртэй хамтарсан корпораци үйлдэж болох ч хэмжээнээс үл хамааран бүхий л төрлийн байгууллага авлигын үйлдлийг гаргадаг. Мөн энэ номд “авлига” гэсэн нэр томъёонд хамаатан саднаа гэх үзэл зэрэг хууль ёсных ч ёс зүйгүй үйлдэл болон хууран мэхлэх зэрэг илэрхий хууль бус үйлдлийн аль алиныг багтаав. Эдгээр ойлголтын аль аль нь авлига гэсэн үргэлжилсэн ойлголтын дотор багтана (Brooks нар 2013). Гэхдээ зарим тохиолдолд “авлигын гэмт хэрэг” гэдэг нэр томъёогоор ёс зүйтэй холбоотой үйлдэл бус гэмт үйлдэл гаргасан болохыг заав. Түүнчлэн авлигын үйлдлийг мөн цагаан захтны гэмт хэрэг гэж нэрлэсэн бөгөөд энэ нэр томъёог Америкийн зохиолчдын бүтээлүүдэд голлон ашигладаг (Wheeler нар 1982; Weisburd нар 1991; Weisbur, Waring 2001). Тэдгээр бүтээлд цагаан захтны гэмт хэрэг гэдэгт ихэвчлэн залилах, луйвардах, болон хуйвалдах үйлдэл холилдсон эдийн засгийн гэмт хэргийг заадаг (Weisburd г.м 1991; Weisbur, Waring 2001; Shover, Hochstetler 2006; Ferguson 2010; Gottschalk 2010; Payne 2013). Энэ нэр томъёо нь мөн Европт дэлгэрсэн (van Erp нар 2015).

Ийм өргөн хүрээний тодорхойлолттой асуудал нь төрөл бүрийн цагаан захтны гэмт хэрэг ба гэмт хэргийн нарийн

төвөгтэй байдал, холбогдсон хүмүүсийн тоо, хохирлын зэрэгтэй холбогддог. Энэ номд залилан ба цагаан захтны гэмт хэргийг ялгасан ч бусад бүтээлүүдэд байнга тэгж ялгагдаггүй. Үүний шалтгаан нь цагаан захтны гэмт хэрэг гэдэг нь зөвхөн гэмт хэрэгтний албан тушаалыг заана. Жишээлбэл, хэрэв албан тушаалтан ашиг хүртэх залилан үйлдвэл түүнийг цагаан захтны гэмт хэрэг (мөн залилан) гэж тодорхойлох бол ажилгүй хэн нэг хүн ашиг хүртэх залилан үйлдвэл түүнийг залилан гэнэ. Ижил гэмт үйлдэл хийсэн боловч гэмт хэрэгтний албан тушаал, статус нь гэмт хэргийг тодорхойлж байна. Тиймээс будлихаас сэргийлэх үүднээс боломжтой тохиолдолд гэмт хэргийг нэрээр нь мөнгө угаах, залилах, хахуульдах гэж нэрлэв.

Асуудлын тодорхойлолт

Мэдлэгийн салбар болохын хувьд криминологи нь гэмт хэргийн статистикийн сул болон ашигтай тал, мөн хэрэг бүртгэлийн асуудалтай тал, түүнээс үүдсэн гэмт хэргийн хэмжилтийн асуудлыг хэлэлцэж ирсэн түүхтэй. Coleman, Moynihan нар (1996) гэмт хэргийг хэрхэн бүртгэдэг ба яагаад гэмт хэргийн статистик нь гэмт хэргийг нэлээд дутуу бүртгэдгийг тайлбарласан. Маргалдагчид болон прокурортой холбоотой гэмт хэргийн шүүхийн тогтолцооноос үл хамааран цагдаагийн хүчин өөртөө итгэлгүй байх, цагдаад үл итгэх, даатгалгүй байх, гэмт хэргийн хохирогч хэрэг үйлдэх, хулгайд алдсан зүйлс нь өмчлөгчийн хувьд үнэ цэнэ багатай байх зэрэг ижил төрлийн асуудлууд үүсдэг (Bottomley, Coleman 1981; Bottomley, Pease 1986). Гэмт хэргийн статистик асуудалтай боловч гэмт хэргийн түвшний баримжаа болохынх нь хувьд авч үзэн хязгаарлалтуудыг нь мэдэж байвал тэдгээр нь зорилгоо гүйцэтгэж, хэрэгцээтэй байх болно. Хэдийгээр

хязгаарлалттай ч бүртгэгдсэн гэмт хэрэг нь замбараагүй, оновчтой бус, сэтгэлийн хөдлөлд автсан үзэл бодлоос сэргийлдэг (Jones 2006) бөгөөд цагдаа хэрхэн ажиллаж байгааг тодотгодог. Жишээлбэл, хэн, аль байршилд гэмт хэрэг үйлдэж байгаад ялгаатай анхаарал тавиад үзвэл баривчилгаа болон яллах ажиллагааны талаарх статистикийг илүү гүнзгий ойлгох болно. Түүнчлэн залилан зэрэг “нууц гэмт хэргийг” бүртгэхэд учрах асуудлын талаар авч үзсэн бүтээлүүд бий (Levi, Burrows 2008; Button г.м 2011). Авлига нь үргэлж биш ч голдуу хүчирхийлэлгүй гэмт хэрэг байх ч “нууц” байдгийн хувьд төсөөтэй учраас үйлдэгдэж буй хэмжээг үнэлэхэд (Heywood 2015) хүндрэлтэй ба тэдгээр үйлдлийн хохирогчдын тоог тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

Хэрэглэж буй онолын чиг хандлагаас шалтгаалан гэмт хэргийг янз бүрээр тодорхойлдог. Диттон (1979) шүүхээс сэжигтний гэм бурууг, эсхүл буруугүйг тогтоох хүртэл ямар ч гэмт хэрэг үйлдэгдсэнд тооцохгүй гэж тайлбарласан. Гэхдээ хууль зөрчсөн хүн бүрт ял тулгаж чаддаггүй: Зарим хэрэгтэнд анхааруулаад өнгөрдөг. Зарим нь үүрд нууц үлддэг. Зарим хэрэг гэмт хэрэгтэн нь нас барсны дараа илэрдэг. Гэвч энэ тодорхойлолт нь бөөрөнхий. Эрүүгийн хууль нь гэмт хэрэгт үзүүлэх хариу үйлдэл болохын зэрэгцээ түүний тодорхойлолтод үзүүлэх хариу үйлдэл болно. Энэ нь яагаад зарим төрлийн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцох болсныг, нөхцөл байдлаас шалтгаалан төсөөтэй үйлдлүүд хүлээн зөвшөөрөгдөх ба/эсхүл хүлээн зөвшөөрөгдөхгүй байгааг, яагаад зарим гэмт үйлдлийг хүчингүй болгодгийг тайлбарлаж чаддаггүй. 1919-1933 оны АНУ-ын архины хоригийн Волстийдийн хууль, дайны үед энгийн иргэнийг алах, эсхүл цэргийг алах, АНУ-ын мужуудын хууль үр хөндөлтийг хэрхэн харж буйгаас

хамааран ялгаатай байгаа байдал нь үүний жишээ болно. Тиймээс гэмт хэргийг тодорхойлох нь ярвигтай ажил бөгөөд дараах бүлгүүдээр дэлгэрэнгүй авч үзэх онолын үндэслэлээс ихэвчлэн хамаардаг.

Бүхий л гэмт хэргийн статистикт эрүүгийн үйлдлийг хэмжих нь зүйтэй эсэх талаар маргаан явж байдаг. Зохиогчийн хувьд энэ бол зүйтэйгээр барахгүй зайлшгүй зүйл юм. Гэмт хэргийн статистик дутагдалтай боловч тэглээ гээд статистик мэдээлэл гаргахаа болих шалтгаан болохгүй бөгөөд зарим статистик, бүртгэл одоог хүртэл зарим талаар хэрэгтэй байдаг. Аливаа бодлого, стратегиар урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгохын тулд асуудлын хэмжээний талаарх ямар нэг баримжаа хэрэгтэй байдаг учир гэмт хэргийг хэмжих ба илүү нарийн төвөгтэй аргачлал боловсруулах нь асуудлын талаарх бидний мэдлэг, зарим үед хохирлын түвшний талаарх мэдлэгийг нэмэгдүүлж байдаг.

Мөн авлига гэдэг ойлголт, түүний шалтгаан, хэмжилт, байршил, түүний үр нөлөө, хэрхэн сэргийлэх талаар бичигдсэн бүтээлүүд маш их байдаг (Philip 1997; Gardiner 2002; Johnston 2005; Golden, Picci 2005; Doig 2011; Brooks ба бусад 2013; Heywood 2015; Hough 2015). Гэхдээ асуудал авлигыг хэмжихээс өмнө зөв тодорхойлолттой байх шаардлагатай ч тэр нь байнга маргаантай байдаг оршдог. Түүнээс гадна 1990-ээд оны авлигатай тэмцсэн хамгийн хүчтэй оролдлого нь бодлогын том бүтэлгүйтэл байсан (McCusker 2006; Persson ба бусад 2008, 2010; Heeks, Mathisen 2012; Heywood 2015). Энэ нь магадгүй судалгааны олонх нь үнэлгээний гол нэгжээр тусгаар улсыг авч ирсэнтэй холбоотой, ялангуяа авлигыг хэмжих, түүний шалтгааныг тодорхойлох зорилготой үед энэ нь үнэн юм. Гэвч

практикт бодитой авлигын тохиолдол нь орон нутгийн шинж чанартай, тодорхой нөхцөл байдалд байдаг бөгөөд салбар доторх болон салбар хоорондын ялгааны улмаас тэдгээр авлига нь шууд улс орны хэмжээнд таардаггүй, мөн авлига нь нэлээд тохиолдолд улс орон дамнасан байдаг (Heywood 2015).

Нэмж хэлэхэд авлига, ялангуяа улс төрийн авлигыг төрийн албаны асуудал гэж дийлэнх нь хардаг. Гэхдээ хувийн хэвшил төрийн албатай ямар ч хамаарал, холбоогүйгээр авлигажсан байж болно (Hough 2015; Heywood 2015) гэдэг нь хүлээн зөвшөөрөгдөхийн хэрээр энэ ойлголт аажмаар өөрчлөгдөж байна. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байдал нь өөрчлөгдөж, төрийн албыг цомхотгож, хувийн салбараар гүйцэтгүүлэх болсноор авлигажсан гэж муу хэлэгддэг улсын салбар (Tanzi 1998, 2000) ба хувийн хэвшлийн ялгаа бүдгэрсэн. Төрийн үйлчилгээнд гарсан өөрчлөлт нь улсын болон хувийн хэвшлийн хооронд одоо орших болсон ойрын, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой авлигын шинэ эрсдэлийг үүсгэж байна. Тиймээс төрийн албаны авлигыг онцлон үзэх нь төөрөгдөл үүсгэх бөгөөд авлигын цар хүрээг, буруутныг алдаатай авч үзсэн хэрэг болно. Хэйвүүдийн тэмдэглэснээр (2015) авлига гэсэн ойлголтыг хэрхэн авч үзэх, жишээгээр хэрхэн судлах, шинжлэхээ дахин тогтоосны дараа сая үр дүнтэйгээр тэмцэх боломжтой болно. Энэ номын зорилго бол энэ хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах боловч мөн социологи болон криминологийн онолын арга хэрэгслийг авлигыг тайлбарлах, ойлгоход ашиглах ба боломжит арга хэрэгслийг авлигаас урьдчилан сэргийлэх, бууруулахад ашиглахад оршино.

Эрх мэдлээ урвуулан ашиглах, албан тушаалд тавигдах шаардлага

болон олон нийтийн итгэлийг зөрчих, хувьдаа болон байгууллагадаа санхүүгийн ашиг тус хүртэх зэрэг авлигын нийтлэг бүрдэл хэсэг байдаг (Bowman, Gilligan 2007; Brooks ба бусад 2013). Энд дурдсан бүрдэл хэсэг нь бүрэн бус бөгөөд авлигыг ангилах оролдлого нь авлигад хандах нийгэм, соёл, хуулийн хандлагыг авч үзэхтэй холилдох болно. Маш тодорхой тодорхойлолт гаргах нь боломжгүй биш ч гэсэн хэцүү бөгөөд ийм тодорхойлолттой байлаа ч гэсэн авлигыг хэмжихэд (Anderson, Heywood 2009; Brooks ба бусад 2013) хүндрэлтэй ба авлига нууцлаг байдаг тул илрүүлэхэд хэцүү (Sandholtz, Gray 2003) байдаг. Ялангуяа олон улсын хил дамнасан авлигын хувьд тийм байдаг. Учир нь тийм авлига тодорхой байршилд уягдахгүй, улс орны хилээр хязгаарлагдахгүй (Becker ба бусад 2009). Эдгээр үйлдлийн нарийн төвөгтэй байдал ба улс хоорондын нийгэм, соёл, улс төрийн хөгжлийн ялгаа нь авлига гэж юу болох, аль улсын мөрдөн шалгах харьяалалд байх вэ гэдэг асуудлыг улам хүндрүүлдэг. Цаашлаад авлигын талаарх олон улсын ихэнх хууль тогтоомж барууных байгаа бөгөөд хүчтэй өрсөлдөгч болон гарч ирж буй хөгжиж буй орнуудыг дарамтлах шинэ төрлийн хяналтын арга хэрэгсэл гэж харж болно (Brooks ба бусад 2013). Авлигыг магадгүй үргэлжилсэн шулуун гэж харах нь хамгийн сайн байж болох юм: ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөхгүй ч хууль ёсны үйлдлээс, ноцтой хууль зөрчсөн үйлдэл ба улсын ба хувийн хэвшилтэй холбогдсон гэмт үйлдэл, ганцаар ба хамтран үйлддэг үйлдлийн хэлбэртэй байж болно. Төрийн үйлчилгээг төрийн алба дангаар хүргэдэг ялангуяа барууны орнуудад төрийн уламжлалт чиг үүрэг аажмаар төрийн үйлчилгээний ихэнхийг хамарч, бодлогын шийдвэрийг бодлогын хэрэгжилтээс салгахыг дэмжсэн

улсын салбарын шинэ менежмент (NPM)-ийн шинэчлэлтээс үүдсэн төрийн аппаратын “Балканжилт”-тай хамт хоцрогдсон (Heywood, Wright 1997 : 91).

Эдгээр улсын салбарын шинэ менежментийн (NPM) шинэчлэл нь авлигын шинэ боломжийг нээсэн ба төрийн албан хаагчид өндөр цалинтай төрийн болон хувийн хэвшлийн албан тушаалд цөөн жилээр эсхүл тэтгэвэртээ гараад ажиллах болсноор ашиг сонирхлын зөрчлийг нэмэгдүүлсэн. Хувийн хэвшлийн хувьд төрийн албаны процедур, үйл явцын талаарх мэдлэг, танил тал маш үнэ цэнэтэй. Эндээс доор дурдсан хүмүүсийг авлигажсан гэж хэлж болох ч энэ шинэ боломж нь тэдэнд нээлттэй байсан. Жишээлбэл, 2011 онд өрсөлдөөнгүйгээр гэрээ авсны дараа Агуста Вэстландын Олон улсын худалдаа хариуцсан дэд ерөнхийлөгч болсон Жеофф Хүүн (өмнө нь Батлан хамгаалах яамны Нарийн бичгийн дарга байсан), Онц ноцтой залиланг мөрдөх албанаас ВАЕ системс компанийн Саудын Арабад зэвсэг нийлүүлсэн талаарх мөрдлөгийг зогсоохоор шахалт үзүүлж байгаад дараа нь 2011 оны 2 дугаар сард “ВАЕ системс” компанийн Олон улсын бизнесийн хөгжлийн албаны дарга болсон Сир Күпер-Колес (өмнө нь Саудын Араб дахь Их Британий элчин сайд байсан), 2011 оны 1 дүгээр сард “ВАЕ системс” компанийн Ахлах зөвлөх болсон агаарын ахлах маршал Сир Глен Торпи (өмнө нь Агаарын хүчний боловсон хүний албан дарга байсан) нар үүнд хамаарна (Heywood 2015 : 10).

Хүмүүсийн эдгээр хөдөлгөөн нь нэг байгууллага нууц мэдээллийг олж авах ба/эсхүл бусад байгууллагууд нь төрийн худалдан авалтын гэрээний төлөө материалаа бүртгүүлж байхад

дангаар мэдээлэлтэй байж болох учир хувийн хэвшилд нууц мэдээллийг хэрхэн ашиглах талаар хэд хэдэн улсын хуулийн байгууллага анхаарлаа хандуулж байна (Della Porta, Vannucci 1997 :75). Эдгээрийн цэвэр үр дүн нь хувьчлал нэмэгдэж байгаа явдал боловч бас өмнөх хамтран ажиллагсдаа лоббидож, шан харамж, хээл хахууль авсан, мөнгө идсэн гэсэн сэжиг дагуулсан албаны мэдээллийг зүй бусаар ашиглан хуулийн хүрээнд эсхүл хуулиас гадуур албан тушаалаа илүү ихээр урвуулан ашиглаж хэлэлцээрт жуучлал хийдэг “бизнес үлс төрчид” ч нэмэгдсэн. Ирээдүйд авлигын чиг хандлага нь хамгийн зохицуулалт багатайгаараа онцлог болсон санхүүгийн болон үлс төрийн салбар хооронд үүсэх шинэ талбар байх бөгөөд түүнд авлигатай тэмцэх байгууллагууд хүрч ажиллаж чадахгүй байж болох юм. Үүнийг Мексикийн картелийн хөрөнгийг Дойче банкны хөрөнгөтэй нийлүүлж Либорын² зээлийн хүүг барихад оролцсон (Hosking, Wilson 2015; Wilson 2015) мөн АНУ-ын 2015 оны сонгуулийн зарим нэр дэвшигчдийн санхүүгийн ар талыг Волл Стрийтээс даасантай холбогдсон НВОС нэгдлийн жишээ илэрхий харуулдаг. Тэд магадгүй татвар төлөгчдийн мөнгөөр “баталгаа” гаргах магадлалтай (Acharya 2010) гэдгийг мэдэж байсны үндсэн дээр Додд Франкын³ хуулийн зарим хэсгийг хүчингүй болгосноор эрсдэлтэй хөрөнгө оруулалт (үүнийг мөрий тавьсан хэрэг гэсэн нь илүү оновчтой болов уу) хийж чадна гэдгээ ойлгож байсан болов уу.

Тиймээс дээр дурдсан өөрчлөлтийн улмаас Транспэрэнси интэрнэшнлийн (2012) олон удаа эшлэгддэг ч бас сул тал бүхий хэллэг болох “өөрт нь даатгасан эрх мэдлийг хувийн ашиг харж ашиглах”

2 Лондонгийн мөнгөний зах зээл дээр гарсан тодорхой банкуудын банк хоорондын дундаж хүүг тооцож гаргадаг.

3 АНУ-д хууль өргөн барьсан гишүүдийн нэрээр тухайн хуулийн нэрлэх явдал түгээмэл байдаг.

гэдэг хэллэгийг хэрэглэхээс зайлсхийхийг хүсэж байна. Маш өргөн хүрээний үйлдлийг хамрах, улс төрийн болон соёлын үүднээс тодорхойлогдох зүйлийг бүхий л нөхцөл байдлыг багтаасан тодорхойлолтод тааруулах гэж оролдох нь авлигын үйлдлийг багтаахаас илүү орхигдуулна. Криминологи ба социологи нь нөхцөл байдалд хамаагүй илүү таарсан аргачлалыг санал болгох ба авлигыг тасралтгүй хэлбэрээр авч үзэж хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, гэмт хэрэг тооцогдохгүй үйлдэл, гэмт үйлдэл хүртэлх бүхий л төрлийн үйлдлийг тасралтгүй үргэлжлэх шугам дээр тодотгон, шинжлэхэд тус болно.

Номын товч агуулга

Уншигчид сонирхлоосоо хамаарч энэхүү номын бүлгүүдийг дараалуулан эсхүл түүвэрлэн уншиж болно. Бүлэг бүрт онолын чиг хандлагын талаар товч тойм оруулсан ба уг онолын хэрэглээ, хэрэгцээтэй эсэх талаарх шинжилгээг оруулснаар авлигыг ойлгоход бидэнд туслах болно.

Авлигыг судлах нь: Салбар дамнасан асуудал гарчигтай 2 дугаар бүлэгт авлигын цар хүрээг хамрах салбар хоорондын аргачлал хэрэгтэй болохыг тодотгодог эрх зүй, улс төр, эдийн засаг, соёлын чиг хандлагыг ашигласан социологи болон криминологийн авлигыг тайлбарладаг онолын чиг хандлагад голчлон төвлөрнө. Тиймээс энэ бүлэгт салбар хооронд маргаангүйгээр хүлээн зөвшөөрөгдөх “зөв тодорхойлолт”-ыг гаргахад учрах саадыг нарийвчлан авч үзнэ. Мөн салбар бүр өөрийн түлхүүр ойлголтыг товойлгон гаргаж янз бүрээр авч үздэг нь хэдийгээр хэрэгтэй боловч энэ нь авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг төвөгтэй болгодог. Гэхдээ эрх мэдэл гэдэг ойлголт, түүний хэрэглээ, ашиглалтыг

тайлбарладаг социологи болон криминологийн онолын чиг хандлага нь авлигыг тодорхойлоход хэрэгтэй байх болно гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс энэ бүлэгт авлигыг нийгэм, улс төрийн агуулгаар авч үзэнгээ социологи/криминологийн бүтээлүүдийг ашиглан “авлига” гэж юу вэ гэдэг асуудлын нарийн төвөгтэй талыг харуулна. Авлигыг тэгэхээр түүний янз бүрийн талуудыг тодотгосон онолын чиг хандлагын үргэлжилсэн шулуун дээр авч үзэх болно.

Авлигын цар хүрээ гарчигтай 3 дугаар бүлэгт авлигын цар хүрээг хэмжих асуудалд анхаарлаа хандуулах учир одоогоор бий болоод буй янз бүрийн хэмжих арга хэрэгслийг авч үзэж, хэвлэгдэн гарсан төсөөллийн судалгаа, өөрөө мэдүүлэх судалгаа, ажиглалтын судалгааны хамрах хүрээ (McCusker 2006; Heywood ба бусад 2015) зэрэг тэдгээрийн давуу болон сул талыг судална. Дараа нь авлигын цар хүрээ, эсхүл авлигатай тэмцэх стратеги/санаачилга амжилтад хүрсэн эсэхийг зөвөөр ойлгоход учирч буй бэрхшээлийн талаар авч үзнэ. Түүврийн хэмжээ болон тодорхой хэмжилтийн нарийн төвөгтэй байдлын аль аль нь өмнө бидний хүрч чаддаггүй байсан тэр хэмжээгээр авлигын цар хүрээг баримжаалах боломж олгосон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Авлигыг тайлбарлах нь: Ялгаатай нөхөрлөл гарчигтай 4 дүгээр бүлэгт цагаан захтны гэмт хэргийн талаарх Сүтерландын (1939) тайлбар, энэ нь авлигыг ойлгоход бидэнд хэрхэн тус болох вэ гэдгийг авч үзнэ. Уг тайлбар нь гудамжны гэмт хэрэг бус цагаан захтны гэмт хэрэгт төвлөрсөн учир “костюмтай хүний гэмт хэрэг”-ийг ойлгох эхлэлийн цэг болдог бөгөөд социологи/криминологийн хөгжил болон хувь хүний ба байгууллагын авлигыг тайлбарлахад чухал байр суурь эзэлдэг. Уг тайлбар нь зөрчлийн

онолтой холбоотой мэдлэгийн салбарын хэсэг гэж тооцогддог ч “корпораци”-ыг “мөлжлөгийн байгуулал” гэж үздэггүй (7 дугаар бүлэгт дурдсан зөрчлийн онолын бусад эрдэмтэдтэй адилгүйгээр) ба энэ нь авлигын үйлдэл гаргагчдыг улс төрийн бус өнцгөөс харах боломж олгодог. Гэхдээ энэ нь цаашид авлигын талаар онолын хэлэлцүүлэг өрнөх талбарыг бий болгодог. Үүнийг автомашины үйлдвэрлэлийн болон дайны бүсэд “ажиллаж” буй хувийн цэргийн гэрээлэгчийн жишээгээр харуулна.

Авлигыг тайлбарлах нь: “Орчин үеийн” дэлхий ертөнцөд бухимдлыг мэдрэх нь гарчигтай 5 дугаар бүлэгт авлигын талаарх бидний ойлголтод “бухимдал”-ыг авч үзэх нь хэрхэн хувь нэмэр оруулахыг судална. Голчлон хувь хүний болон байгууллагын санхүүгийн амжилт болон хэрэглээгээр хэмжигддэг капитализм хэт давамгайлсан ертөнцөд бухимдал нь болзошгүй авлигын үйлдлийн талаар нэлээд төсөөлөл өгдөг (Merton 1938; Agnew 1992; Schoepfer, Piquero 2006; Langton, Piquero 2007). Энэ асуудлыг сансрын тандан судалгаа болон эрүүл мэнд зэрэг өргөн цар хүрээтэй салбар дахь авлигын үйлдлийг шинжлэхэд ашигладаг. Тиймээс “орчин үеийн ертөнц”-д бухимдалд автаж буй хувь хүн, байгууллага, улс орон дээр төвлөрч, өнгөрсөн, одоо, ирээдүйн авлигын үйлдлийг тайлбарладаг.

Авлигыг тайлбарлах нь: Авлигын ертөнц рүү орж гарах ба саармагжуулах арга хэрэгсэл гарчигтай 6 дугаар бүлэгт авлига бол сонголт бөгөөд хувь хүн, байгууллага нь олон янзын хүчин зүйлээс хамаарч халтиран орж, гарч болох зүйл гэдэг тайлбарыг авч үзнэ (Matza 1964). Мөн хувь хүн, байгууллагууд авлигажсан үйлдлээ зөвтгөхөд ашигладаг саармагжуулах арга хэрэгслийн талаар авч үзнэ (Sykes, Matza 1957). Тиймээс бид

авлига бол тогтонги зүйл бус уян хатан зүйл юм гэж үзэж байна. Энэ хандлага нь хувь хүн, байгууллага нь тодорхой цаг хугацаанд санхүүгийн салбар, спортын ертөнц, автомашины салбарын эдийн засгийн нөхцөл байдалд хариу үйлдэл болгон авлигажсан болон ёс зүйтэй үйлдлийг зэрэг хийж, авлигын үйлдэл нэг гаргаж, нэг больж байдгийг ойлгоход тустай.

Авлигыг тайлбарлах нь: Яагаад бид бүгдээрээ авлигын үйлдэл гаргадаггүй вэ? гарчигтай 7 дугаар бүлэгт авлигын талаарх ихэнх онолын тайлбараас ялгаатай арга зүй ашиглан авлигыг яагаад үйлддэг вэ гэдэгт бус яаж авлигаас ангид байдаг төвлөрөн тайлбарлана (Hirschi 1969; Hirschi, Gottfredson 1987). Энэ утгаар авч үзвэл гол зүйл нь хуулийн сүрдүүлэг, шийтгэл бус хувь хүний дотоод хяналт болж таарна. Онолын тайлбарыг авч үзсэний дараа бид анхаарлаа гадаад хяналт руу чиглүүлнэ, учир нь урьдчилан сэргийлэх боломжийн талаарх тайлбар үүнтэй хамаатай байдаг.

Авлигыг тайлбарлах нь: Зөрчилдөөний “тогтолцоонд” авлига гарцаагүй юу? гарчигтай 8 дугаар бүлэгт “бизнес” нь эцэстээ хэрхэн зөрчилд хүргэдгийг судлаад авлига нь мөлжлөг дээр суурилсан тогтолцооны хэсэг болохыг харуулна (Quinney 1969, 1975, 1977). Энэ бүлэгт харуулснаар “шинэ капиталист улс” болох ОХУ нь авлигын болон зөрчилдөөний тогтолцоон дээр хэрхэн бий болсонтой (Rawlinson 2012) адил байнга өсөн нэмэгдэх ашгийн төлөөх мөлжлөг болон заль мэх нь хүмүүс, нөөц, улс орны асуудал болж байна. Төрөл бүрийн капиталист болон социалист улсууд бүгд л авлигатай нүүр тулдаг бөгөөд ялгаа нь гэвэл капиталист улсад эрх мэдэл байнга биш ч санхүүгийн эрх мэдэл байдаг бол социалист улсад эрх

мэдэл хүнд суртлын бүтцэд эзлэх авлигад өртөж болзошгүй албан тушаалд оршдог тул авлигаас сэргийлэх эрс тэс арга хэмжээ авахыг зөвлөмж болгохгүй. Баялгийг бий болгож, хуваарилах бүхий л улс төрийн тогтолцоо, арга хэрэгсэл нь авлигажсан хүн, байгууллагаар бохирдсон байдаг болохыг энэ бүлэгт онцлон авч үзнэ.

Авлигыг тайлбарлах нь: Байгууллага, институц, хувь хүмүүсийг авлигажсан гэх нэр зүүх эрх мэдэл гэсэн гарчигтай 9 дүгээр бүлэгт хувь хүн, байгууллага, улс орныг дур зоргоороо, хууль бус, авлигажсан гэж хаяглах эрх мэдлийг авч үзнэ (Becker 1966). Тиймээс эрх мэдэл гэдэг ойлголт энэ бүлгийн гол хэсэг байх болно. Хэдийгээр энэ эрх мэдэл гэсэн ойлголтыг шүүмжилж болох ч аливаа үйл явдал ба/эсхүл хувь хүнийг тодорхойлох эрх мэдлийн талаар маргаж байдаг. Жишээлбэл, 1989 оны Английн Хилсбороу цэнгэлдэх хүрээлэнгийн ослын шалтгаан ба хөл бөмбөгийн дэмжигчдийг “араатнууд” гэж хаяглах, ОУВС ба Дэлхийн банк хэрхэн авлигын талаарх яриа хэлэлцээрт давамгайлдаг ба төрийн албыг авлигын эх үүсвэр гэж хаяглах асуудал байна. Мөн энэ бүлэгт хувь хүн/байгууллага/улс бусдад нэр хоч зүүх эрх мэдлийн талаар авч үзэх бөгөөд энэ нь авлигын талаарх баруун төвтэй үзэлд хүргэдэг.

Авлигыг тайлбарлах нь: Рационал, тооцоолсон сонголт уу? гэсэн гарчигтай 10 дугаар бүлэгт авлига бол зардал-үр өгөөжийн шинжилгээнд үндэслэсэн рационал сонголт болохыг батална. Энэ онолын чиг хандлагын түлхүүр бүрэлдэхүүн хэсгийг ашиглан (Clarke 1980) энэ бүлэгт байгаль орчныг сүйтгэх асуудал болон түүнээс урьдчилан сэргийлэх орчин үеийн арга хэрэгсэл ба тийм үйлдэл гаргасан этгээдийг хэрхэн шийтгэх талаар авч үзнэ.

Авлигыг тайлбарлах нь: Ердийн “бизнесийн” үйл ажиллагаа юу? гэсэн

гарчигтай 11 дүгээр бүлэгт авлига нь тодорхой хэдэн тогтолцоо байхгүй л бол авлига авах боломжтой байсаар байдаг байнга давтагддаг зүйл гэсэн үзлийн талаар судална. Тиймээс энэ хандлагын түлхүүр бүрэлдэхүүн хэсгүүдийг авч үзэн санхүүгийн тогтолцоонд авлигаас урьдчилан сэргийлэхэд уг онолыг тайлбарыг хэрхэн ашиглах талаар хэлэлцэнэ. Мөн зарим орчин үеийн шинэ санааг танилцуулж санхүүгийн салбар зэрэг зарим газарт гэмт хэрэг, авлига нь байнгын зүйл (Cohen, Felson 1979) мэт байгааг хүлээн зөвшөөрнө.

Сургамж авах зүйлс ба дүгнэлт гэсэн гарчигтай 12 дугаар бүлэгт эдгээр онолын тогтолцоо болон хэлэлцүүлэг нь авлигыг ойлгох, түүнээс сэргийлэх холбогдох арга хэрэгсэл, стратегийг ашиглахад оруулах хувь нэмрийн талаар эргэн авч үзнэ.

Ашигласан материал

Acharya, V. V., Cooley, T.F., Richardson, M. P., & Walter, I. (2010). *Regulating Wall Street: The Dodd-Frank Act and the new architecture of global finance*. Winchester: John Wiley & Sons.

Agnew, R. (1992). Foundation for a general strain theory of crime and delinquency. *Criminology*, 30 (1), 47–87.

Agnew, R., & White, H. (1992). An empirical test of general strain theory. *Criminology*, 30 (1), 475–499.

Anderson, S., & Heywood, P. M. (2009). The politics of perception; use and abuse of Transparency International's approach to measuring corruption. *Political Studies*, 57 (4), 746–767.

Becker, H. S. (1963). *Outsiders: Studies in the sociology of deviance*. New York: Free Press.

Becker, H. S. (1966). *Outsiders: Studies in the sociology of deviance*. New York: Free Press.

Becker, S., Egger, P., & Seidel, T. (2009). Common political culture: Evidence on regional corruption contagion. *European Journal of Political Economy*, 25 (3), 300–310.

Bottomley, K., & Coleman, C. (1981). *Understanding crime rates*. Farnborough: Gower.

Bottomley, K., & Pease, K. (1986). *Crime and punishment: Interpreting the data*. Milton Keynes: Open University Press.

- Bowman, D., & Gilligan, G. (2007). Public awareness of corruption in Australia. *Journal of Financial Crime*, 14 (4), 438–452.
- Brooks, G., Walsh, D., Lewis, C., & Kim, H. (2013). *The prevention of corruption: Investigation, enforcement and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Button, M., Gee, J., & Brooks, G. (2011). Measuring the cost of fraud: an opportunity for the new competitive advantage. *Journal of Financial Crime*, 19 (1), 65–75.
- Chambliss, W. (1975). Toward a political theory of crime. *Theory and Crime*, 2, 152–153.
- Clarke, R. (1980). *Situational crime prevention*. *British Journal of Criminology*, 20 (2), 136–147.
- Clarke, R. V. G. (1997). *Situational crime prevention*. Monsey, NY: Criminal Justice Press.
- Cohen, L. E., & Felson, M. (1979). Social change and crime rates trends: A routine activity approach. *American Sociological Review*, 44 (4), 588–608.
- Coleman, C., & Moynihan, J. (1996). *Understanding crime data: haunted by the dark figure*. Milton Keynes: Open University Press.
- Crawford, A. (2009). *Crime prevention policies in comparative perspective*. Devon: Willan Publishing.
- Currie, E. (1985). *Confronting crime: An American challenge*. New York: Pantheon.
- Dahrendorf, R. (1958). *Class and class conflict in industrial society*. Stanford, CA: Stanford University Press.
- Della Porta, D., & Vannucci, A. (1997). The “perverse effects” of political corruption. *Political Studies*, 45 (3), 516–538.
- Ditton, J. (1979). *Controlology*. London: Macmillan.
- Doig, A. (2011). *State crime*. Cullumpton: Willan Publishing.
- Erickson, K. T. (1966). *Wayward puritans: A study in the sociology of deviance*. New York: Wiley.
- Farrington, D. P., MacKenzie, D. L., Sherman, L. W., & Welsh, B. C. (2003). *Evidence-based crime prevention*. Basingstoke: Routledge.
- Ferguson, J. E. (2010). *White collar crime*. New York: Chelsea House Publishers.
- Gardiner, J. (2002). Defining corruption. In A. Heidenheimer & M. Johnson (Eds.), *Political corruption, concepts and contexts*. New Brunswick, NJ: Transaction Publishers.
- Garland, D. (2001). *The culture of control: Crime and social order in contemporary society*. Oxford: Oxford University Press.
- Golden, M., & Picci, L. (2005). Proposal for a new measure of corruption, Illustrated with Italian data. *Economics and Politics*, 17 (1), 37–55.
- Gottschalk, P. (2010). *White-collar crime: Detection, prevention and strategy in business enterprises*. Boca Raton, Florida: Universal Publishers.
- Hagan, F. (2012). *Introduction to criminology: Theories, methods and criminal behavior*. Thousand Oaks, CA: Sage.
- Heeks, R., & Mathisen, H. (2012). Understanding success and failure of anticorruption initiatives. *Journal of Crime, Law and Social Change*, 58 (5), 533–549.
- Heywood et al. (2015). *Routledge handbook of political corruption*. London: Routledge.
- Heywood, P. M. (2015). *Routledge handbook of political corruption*. Abingdon: Routledge.
- Heywood, P. M., & Wright, V. (1997). Executives, bureaucracies and decision making. In M. Rhodes, P. M. Heywood, & V. Wright (Eds.), *Development in West European politics*. London: Macmillan.
- Hirschi, T. (1969). *Causes of delinquency*. Berkeley, CA: University of California Press.
- Hirschi, T., & Gottfredson, M. (1987). Causes of white-collar crime. *Criminology*, 25 (4), 949–974.
- Hopkins-Burke, R. (2013). *An introduction to criminological theory*. Abingdon: Routledge.
- Hosking, P., & Wilson, H. (2015, April 24). How Deutsche cheated and misled. *The Times*, p. 38.
- Hough, D. (2015). *Corruption, anti-corruption and governance*. Basingstoke: Palgrave Macmillan.
- Huisman, W., & Vande Walle, G. (2010). *The criminology of corruption. The good cause. Theoretical perspectives on corruption*. Barbara Budrich: Opladen.
- Johnston, M. (2005). *Syndromes of corruption: Wealth, power and democracy*. Cambridge: Cambridge University Press.
- Jones, S. (2006). *Criminology* (3rd ed.). Oxford: Oxford University Press.
- Langton, L., & Piquero, N. L. (2007). Can general strain theory explain white collar crime? A preliminary investigation of the relationship between strain and select white collar offenses. *Journal of Criminal Justice*, 35 (1), 1–15.
- Levi, M. and Burrows, J. (2008). Measuring the impact of fraud in the UK: A conceptual and empirical journey. *British Journal of Criminology*, 48 (3), 293–318.
- Lilly, R. J., Cullen, F. T., & Ball, R. A. (1989). *Criminological theory: Context and consequences*. Thousand Oaks, CA: Sage Publications.
- Matza, D. (1964). *Delinquency and Drift*. New York: Wiley.
- McCusker, R. (2006). *Review of anti-corruption*

- strategies*. Canberra: Australian Institute of Criminology.
- McLaughlin, J., & Newburn, T. (2013). *The sage handbook of criminological theory*. London: Sage.
- Merton, R. K. (1938). Social structure and anomie. *American Sociological Review*, 3, 672–210.
- Murray, C. (1990). *The emerging British underclass*. London: Institute for Economic Affairs.
- O'malley, P. (1992). Risk, power and crime prevention. *Economy and Society*, 21 (3), 252–275.
- Payne, B. (2013). *White collar crime*. Thousand Oaks: Calif: Sage.
- Persson, A., Rothstein, B., & Teorell, J. (2010). *The failure of anti-corruption policies: A theoretical mischaracterisation of the problem* (QoG Working paper Series 19).
- Philip, M. (1997). Defining political corruption. In P. Heywood (Ed.), *Political corruption*. Oxford: Blackwell.
- Quinney, R. (1969). *Criminal justice in American society*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1975). *Criminology: Analysis and critique of crime in America*. Boston: Little Brown.
- Quinney, R. (1977). *Class, state, and crime: On the theory and practice of criminal justice*. New York: David McKay.
- Rawlinson, P. (2012). Corruption, organised crime and the free market in Russia. In P. Gounev & V. Ruggiero (Eds.), *Corruption and organised crime in Europe*. Abingdon: Routledge.
- Sandholtz, W., & Gray, M. M. (2003). International integration and national corruption. *International Organization*, 57 (4), 761–800.
- Schoepfer, A., & Piquero, N. L. (2006). Exploring white collar crime and the American dream: A partial test of institutional anomie theory. *Journal of Criminal Justice*, 34, 227–235.
- Shover, N., & Hochstetler, A. (2006). *Choosing white collar crime*. Cambridge: Cambridge University Press.
- Siegal, L. (2012). *Criminology: Theories, patterns and typologies*. Belmont, CA: Wadsworth Cengage Learning.
- Sutherland, E. H. (1939). *Principles of criminology* (3rd ed.). Philadelphia, PA: Lippincott.
- Sykes, G. M., & Matza, D. (1957). Techniques of neutralization: A theory of delinquency. *American Sociological Review*, 22, 664–670.
- Tanzi, V. (1998). *Corruption around the World: Causes, consequences, scope and cures* (Working Paper 98/63). Washington, DC: IMF.
- Tanzi, V. (2000). Policies, institutions and the dark side of economics. Cheltenham: Edward Elgar.
- Tierney, J., & O'Neill, M. (2009). *Criminology: Theory and context*. Harlow: Person Longman.
- Timmer, D. A., & Eitzen, S. (1989). *Crime in the streets and crime in the suites: perspectives on crime and criminal justice*. New Jersey: Prentice Hall.
- Transparency International (2012). *Corruption Perception Index 2012*. London: Transparency International.
- Treadwell, J. (2012). *Criminology: The Essentials*. London: Sage.
- Turk, A. T. (1969). *Criminality and legal order*. Chicago: Rand McNally.
- van Erp, J., Huisman, W., & Walle, G. V. (2015). *The Routledge handbook of white-collar and corporate crime in Europe*. London: Routledge.
- Vito, G. F., & Maahs, J. R. (2015). *Criminology: Theory, research and policy*. Burlington, MA: Jones and Bartlett Publishers.
- Weisburd, D., & Waring, E. (2001). *White-collar crime and criminal careers*. New York: Cambridge University Press.
- Weisburd, D., Wheeler, S., Waring, E., & Bode, N. (1991). *Crimes of the middle classes: White collar offenders in the federal courts*. New Haven, CT: Yale University Press.
- Wheeler, S., Weisburd, D., & Bode, N. (1982). Sentencing the white-collar offender: Rhetoric and reality. *American Sociological Review*, 47 (5), 641–659.
- Wilson, H. (2015, November 13). How bankers in last chance saloon fixed forex markets. *The Times*, p. 50.
- Wilson, J. Q., & Herrnstein, R. (1985). *Crime and human nature*. New York: Simon and Shuster.